



ХЭҮК



# “ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ- ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ  
2005 ОН



## АГУУЛГА

<b>ОРШИЛ</b> .....	2
<b>Нэг. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ</b> .....	3
1.1 Судалгааны арга зүй	
1.2 Судалгааны аргачлал	
1.3 Тест	
1.4 Судалгааны мэдээллийн боловсруулалт	
<b>Хоёр. ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖМЕНТ</b> .....	11
2.1 ЕБС-ийн боловсролын удирдлага, боловсролын стандарт	
2.2 Багшлах боловсон хүчний талаарх зарим асуудал	
2.3 Сэдвийн дүгнэлт	
<b>Гурав. ХҮНИЙ ЭРХ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА</b> .....	17
3.1 Хүний эрхийн боловсролын агуулгын тухай товчхон	
3.2 ЕБС-ийн хүний эрхийн боловсролын агуулга	
3.3 Сэдвийн дүгнэлт	
<b>Дөрөв. ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТЫН ОРЧИН</b> .....	30
4.1 ЕБС дахь хүний эрхийн сургалтын технологийн дүр төрх	
4.2 Хүний эрхийн сургалтын технологийг боловсронгуй болгох, шинэчлэх талаар хийгдсэн зарим ажил	
4.3 Хүний эрхийн сургалтын технологи, арга зүйн талаар хийсэн судалгааны дүн	
4.4 Сэдвийн дүгнэлт	
<b>Тав. ХҮНИЙ ЭРХ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН</b> .....	38
5.1 ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн хичээлийн сурах бичиг	
5.2 ЕБС-иудын номын сан дахь хүний эрхийн холбогдолтой ном, гарын авлагын байдал	
5.3 Эрх зүйн кабинет	
5.4 Хэрэглэгдэхүүн ба менежмент	
5.5 Сэдвийн дүгнэлт	
<b>Зургаа. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ОРЧИН</b> .....	50
6.1 Ерөнхий боловсролын хүний эрхийн орчны тухай ойлголт	
6.2 МУ-ын ЕБС-иудын хүний эрхийн орчны өнөөгийн байдал	
6.3 ЕБС-д хүний эрхийн орчинг бүрдүүлэхэд анхаарах зүйлс	

## ДҮГНЭЛТ



## ОРШИЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллага(НҮБ)-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12-р сарын 10-нд баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26-р зүйлийн 2-т “Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой” гэж заасан нь **“Хүний эрхийн боловсрол”**-ын тухай сонгодог тодорхойлолт юм.

Өөрөөр хэлбэл хүний эрхийн боловсролын агуулга нь хүмүүсийн суурь үнэт зүйлсийг төлөвшүүлэх, эрхийг нь хамгаалах стратеги боловсруулах, хүний эрхийг хангах, хамгаалах бодит үйл ажиллагаа өрнүүлэхэд чиглэгдэх ёстой. Тиймээс ч хүний эрхийн боловсрол нь хүмүүс соёл, зан заншил, хэл, шашин шүтлэг, хүйс гэх мэт ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчиж, өөр өөр бүлгүүд, олонх, цөөнх бие биетэйгээ зохицон амьдрах, эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломжоор хангагдах ёстойг мэдэх угтвар нөхцөл болох учиртай. Хувь хүн эрхээ мэддэг, хэрэгжүүлж чаддаг болж, улмаар энэ нь дэлхий нийтийн энх тайван, хувь хүмүүсийн дээд зэргийн хөгжлийг хангах чухал арга зам болно.

1993 онд Австри улсын нийслэл Вена хотноо хуралдсан НҮБ-ын “Хүний эрхийн олон улсын бага хурал” хүний эрхийг хангах, хамгаалах явдалд ахиц гаргахад хүний эрхийн боловсролыг бүх нийтэд олгох нь зайлшгүй болохыг онцлон тэмдэглэж уг бага хуралд оролцсон орнуудын Засгийн газар, түүний дотор Монгол Улсын Засгийн газар иргэддээ хүний эрхийн боловсрол олгоход анхаарал тавьж ажиллахаар тогтсон юм.

Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих явдалд чухал түлхэц өгсөн өөр нэг арга хэмжээ бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1995 оны 1-р сарын 1-ээс 2004 оны 12-р сарын 31-нийг Хүний эрхийн боловсролын арван жил болгон зарласан явдал юм. Хүний эрхийн боловсролын арван жилийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

1. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх
2. Бие хүн, түүний нэр хүндийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэн үзэх
3. Аливаа улс түмэн, тэр дундаа нутгийн уугуул иргэд, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд, үндэстний цөөнх бие биенээ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, хүйсийн тэгш байдлыг хангах
4. Бүх хүмүүст чөлөөт нийгэмд үр бүтээлтэйгээр оролцох бололцоог олгох
5. Энх тайвныг сахиулах Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан НҮБ-аас олон улсын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Хүний эрхийн Дээд Комиссарын газарт хариуцуулсан бөгөөд арван жилийн үйл ажиллагааны үр дүнг хэлэлцээд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Хүний эрхийн боловсролын хөтөлбөр”-ийг батлан гаргасан билээ. Энэхүү хөтөлбөр нь уян хатан, үр дүнтэй байх үүднээс тодорхой хугацаанд, тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилт дэвшүүлэн тавьсан. Юуны өмнө 2005-2007 онд ерөнхий боловсролын систем дэх хүний эрхийн боловсролд анхаарал хандуулах зорилтыг дэвшигдэн гарч ирээд байна. Энэ ажлын хүрээнд улс орнуудын Засгийн газруудад 2005 онд багтаан өөрийн улсын ерөнхий боловсролын систем дэх хүний эрхийн





боловсролын үйл ажиллагаандаа үнэлгээ, дүгнэлт хийж, хөтөлбөр төлөвлөгөөгөө боловсруулж, чиглэлээ тодорхойлохыг уриалсан.

Монгол Улс 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиндаа хүний эрх, эрх чөлөөг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн, шинэ утга агуулгаар баталгаажуулсан билээ. Үндсэн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс (2001 он) байгуулагдаж, Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөр (2003 он) батлагдан гарлаа. Эдгээр нь манай улсын хувьд хүний эрхийн салбарт гарсан шинэ, томоохон ололт юм. Улмаар манай улсын их, дээд сургуулиудад хүний эрхийн хичээл цөөн цагаар боловч заагдах болж, хүний эрхийн мэргэжилтэн бэлтгэх эхлэл тавигдаж байна.

1990-ээд оноос ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн хүний эрхийн сургалтын агуулга, арга зүйг шинэчлэн боловсронгуй болгох талаар багагүй ажил хийгдлээ. Тухайлбал, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлсэн “Хууль бидний амьдралд” хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн эрх зүйн хөтөлбөрийг шинэчлэх ажил хийгдэж, “Хүний эрх” хичээлийн стандартыг өмнө үзэж байсан агуулгаас ялгаатайгаар, олон улсын хүний эрхийн боловсролын стандартад нийцүүлэн боловсруулж гаргасан бөгөөд ЕБС-д сургалт явагдаж эхэлсэн.

Монгол Улсын хувьд НҮБ-аас зарласан Боловсролын 10 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн томоохон ажил бол ЕБС-ийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг цогцоор нь шинэчилсэн явдал билээ. Эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх ажлыг МННХ (Соросын сан)-ийн “Хууль бидний амьдралд” төслийн хүрээнд 1998-2003 онуудад хийж гүйцэтгэжээ. Эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхдээ хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролд ихээхэн анхаарал тавьсан бөгөөд анги тус бүрийн хичээлийн агуулгад хүний эрхийн асуудлыг тусгахыг зорьсноос гадна, 6-р ангид “Хүний эрх” хичээлийг бие даалган оруулахаар төлөвлөж боловсруулсан. Шинэчилсэн хөтөлбөрийн дагуу 2003 оноос орж эхэлсэн хүний эрхийн хичээлийн зорилго бол сурагчдыг хүний эрх, эрх чөлөөний тухай, хүний эрхийн зөрчил, түүнээс хэрхэн сэргийлэх талаар мэддэг, бусдын эрхийг өөрийн эрхийн адил хүндэтгэдэг болгон төлөвшүүлэх явдал юм.

ХЭҮК-ын нэг чухал үүрэг бол хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих асуудал мөн. Тус комисс 2004 онд хууль зүйн боловсрол олгодог их дээд сургуулиудын хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Хүүхэд залуучуудад эхнээс нь хүний эрхийн боловсрол, мэдлэг, чадвар, хандлагыг зөв эзэмшүүлэх нь тэд өөрсдийнхөө эрхийг мэддэг зөрчигдсөн эрхээ хамгаалж чаддаг, бусдын эрхийн хүндэтгэдэг болох гол нөхцөл хэмээн үздэг. Иймээс ерөнхий боловсролын сургуульд зааж буй хүний эрхийн хичээлийн чанар нөлөөг дээшлүүлэх, сургалтын өнөөгийн байдалд судалгаа дүгнэлт хийх нь зүйтэй гэж үзсэн. Түүнчлэн боловсролын тогтолцоонд сүүлийн үед олон чухал өөрчлөлт гарч, энэ чиглэлээр олон тооны төсөл хэрэгжиж байгаа нь судалгаа хийх бас нэг шалтгаан болсон. Иймээс ХЭҮК энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс “Хүний эрхийн боловсрол- ЕБС-д” хэмээх төсөл боловсруулж энэ төслийг UNESCO дэмжсэнд талархаж байна.

Судалгааны ажлын гол зорилго нь ЕБС-д орж буй хүний эрхийн хичээлийн чанар үр нөлөө, сургалтын агуулга, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ, багшлах боловсон хүчний өнөөгийн байдал, сургуулийн хүний эрхийн орчинд судалгаа хийж нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид энэ хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсронгуй болгох, заах арга барилыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргаж, багшид тавигдах шаардлагыг



боловсруулан гаргахад оршино. Төслийн чанар үр нөлөөг дээшлүүлэх үүднээс энэхүү судалгааны ажлыг БСШУЯамны холбогдох мэргэжилтнүүд, зарим судлаачидтай хамтран хэрэгжүүлсэн болно.



## Нэг. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

### 1.1. Судалгааны арга зүй

#### 1.1.1 Судалгааны үндэслэл, зорилго

Уг судалгааг хийх дараах үндэслэлүүд байна. Үүнд:

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлагдсан “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2005 онд улс орнуудын Засгийн газрыг өөрийн улсын ЕБС-ийн хүний эрхийн боловсролын хөтөлбөрт үнэлгээ, дүн шинжилгээ хийхийг уриалсан билээ.
- 1998 онд батлагдсан ерөнхий боловсролын стандарт болон Гэгээрлийн сайд /хуучин нэрээр/ 100-р тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу хүний эрхийн агуулгыг 6-р ангид хувьсах болон тогтвортой агуулгаар судлахаар тогтоосон байна. Гэвч ЕБС-иудад агуулга бүрэн биш, судалж байгаа цаг харилцан адилгүй, хэрэглэгдэхүүн, заах арга зүй учир дутагдалтай байх явдал элбэг байна.

Энэхүү судалгааны зорилго нь:

- ЕБС-ийн 6-р ангид орж буй “Хүний эрх” хичээлийн агуулга, заах арга зүй, хэрэглэгдэхүүнд үнэлгээ, дүгнэлт өгөх;
- ЕБС-иудын хүний эрхийн сургалтын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, холбогдох байгууллагуудын анхаарлыг хандуулах;
- Хүний эрхийн сургалтын чанар, үр дүнг сайжруулах боломж, арга замыг тодорхойлох явдал юм

#### 1.1.2. Судалгааны судлах зүйл

ЕБС-ийн 6-р ангид судалж буй хүний эрхийн сургалтын агуулга, заах арга, сургалтын хэрэглэгдэхүүн, багш, сурагчийн мэдлэг, чадвар, хандлага, сургуулийн хүний эрхийн орчин зэрэг болно.

#### 1.1.3. Судалгааны объект

Судалгаанд түүвэрт аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгогдсон ЕБС-ийн багш, сурагчид хамрагдсан. Мөн энэ чиглэлээр өмнө нь хийгдсэн судалгаа, хяналт, шинжилгээний тайлан, төрийн холбогдох байгууллагуудаас гаргасан баримт бичгүүд зэрэг хоёрдогч эх үүсвэр материалуудыг үзэж судлав.

### 1.2. Судалгааны аргачлал

#### 1.2.1. Түүвэр судалгаа

Тоон судалгаанд түүврийг тогтоохдоо олон шатат санамсаргүй түүврийн аргыг хэрэглэсэн. Энэ арга нь үндэсний хэмжээний суурь судалгааг төлөөлөл сайтай явуулахад ихээхэн үр дүнтэй хэрэглэгддэг түүвэр судалгааны төрөл болно. Харин чанарын судалгаанд зорилтот түүврийн аргыг ашигласан. Түүврийн аргыг хэрэглэснээр хөрөнгө хүч, цаг хугацаа хэмнэхийн дээр төлөөлөх чадвар сайн болсон тохиолдолд эх олонлогоос дутуугүй үр дүн өгдөг. Энд объектын гол



шинжүүдийн хувьд эх нийлбэрийг төлөөлж чадах зөв бүтэц, хэмжээ бүхий судлах нэгжийг тогтоох нь чухал юм.

Судалгааны түүврийг төлөөлөх чадвар сайтай, үндэслэлтэй хийхийн тулд түүврийн бүтэц, тоо хэмжээг харгалзах хэрэгтэй.

### Түүврийн бүтэц

Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан бүсийн төлөөлөл бүрээс нэг аймаг, нийт зургаан аймгийг, тус бүр нэг сумтай сонгон авсан. Үүнд: Архангай, Баян-Өлгий<sup>1</sup>, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд аймаг, Их-Тамир, Толбо, Хөтөл, Хүрмэн, Онгон, Эрдэнэбүрэн сумын ЕБС-иуд хамрагдсан. Нийслэлийн 9 дүүргээс өмчийн хэлбэр, сургуулийн байршил зэргийг харгалзан 6 дүүргийг сонгон авсан. Үүнд: Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг болно.

Хүснэгт 1. Эх олонлог ба түүврийн бүтэц

Аймаг/ Хот	Сум/ Дүүрэг	Сургууль, сурагчдын тоо /өмчийн хэлбэрээр/			Эх олонлог ба судалгаа явуулах газрын байршил	
		Төрийн	Хувийн	Нийт сурагч	Ү-ҮIII ангийн сурагчдын тоо	Алслагдсан байдал
Улаанбаатар	<b>6 дүүрэг</b>	<b>12</b>	<b>6</b>	<b>578</b>	<b>17709</b>	
	Баянгол	2	1	105	3903	Хотын төв
	Баянзүрх	2	1	98	4250	Хотын төв
	Налайх	2	1	69	592	45км
	Сүхбаатар	2	1	106	3102	Хотын төв
	Сонгино хайрхан	2	1	105	3952	Хотын төв
	Хан-уул	2	1	95	1910	Хотын төв
<b>Аймаг:</b>	<b>12 сум</b>	<b>21</b>	<b>3</b>	<b>628</b>	<b>26082</b>	
Дархан-Уул	Дархан	2	1	80	9653	УБ-аас 219км
	Хөтөл <sup>2</sup>	1	-	25	801	Аймгаас 68км
Сүхбаатар	Баруун-Урт	2	-	70	1856	УБ-аас 560км
	Онгон	1	-	35	326	Аймгаас 160км
Өмнөговь	Даланзадгад	2	-	81	2224	УБ-аас 553км
	Хүрмэн	1	-	24	133	Аймгаас 61км
Архангай	Цэцэрлэг	2	1	70	2590	УБ-аас 480км
	Их-Тамир	1	-	35	466	Аймгаас 27км
Баян-Өлгий	Өлгий	2	1	70	4019	УБ-аас 1636км
	Толбо	1	-	35	244	Аймгаас 76км
Ховд	Ховд	2	-	71	3530	УБ-аас 1425км
	Эрдэнэбүрэн	1	-	32	240	Аймгаас 61км

Судалгааны түүвэрт хамрагдаагүй аймгуудад ажиглалт болон багшийн санал асуулга, сорил авах ажлыг явуулсан. Үүнийг аймгийн төвүүд, дүүргүүдээс авсан нэлэнхүй судалгаа гэж үзэж болно.

<sup>1</sup> Үндэстний цөөнхийг төлөөлүүлж сонгосон.

<sup>2</sup> Дархан Уул аймаг нь цөөн сумтай аймгуудын тоонд ордог тул Сэлэнгэ аймгийн Хөтөл сумыг судалгааны түүвэрт оруулахаар сонгов.





Тоон судалгаанд нийт 1206 сурагч, 184 багшийг хамруулж, чанарын судалгаагаар нийт 20 бүлгийн ярилцлага (багш, сурагч), 180 ганцаарчилсан ярилцлага (сурагч, багш, сургуулийн удирдлагууд), 3-5 экспертийн ярилцлагыг хийсэн. Ажиглалтын судалгаанд нийслэл, 21 аймгийн төв, 6 сумын нийт 175 ерөнхий боловсролын сургуулийг хамрууллаа.

### Түүврийн хэмжээ, төлөөлөх чадвар

Энд эх олонлог ба түүвэр олонлогийн харьцааг томъёолол ашиглан тооцов.

$$N = t_0^2 \cdot x p x q / E^2$$

*N*-түүврийн хэмжээ

*E*<sup>2</sup>-түүврийн алдаа

*t*<sub>0</sub><sup>2</sup>- итгэх түвшний утга

*t*<sub>0</sub><sup>2</sup>- итгэх түвшин бүхий Стьюдентийн тархалтын критик утга

*p*- хүний эрхийн сургалтад хамрагдсан сургуулийн сурагчдын хувийн жин

*q*- хүний эрхийн сургалтад хамрагдаагүй сургуулийн сурагчдын хувийн жин

Дээрх томъёонд түүвэр судалгааны алдааг 0.025-0.026, итгэх түвшний утгыг 0.05 гэж тооцон, түүврийн зохистой хэмжээг 1260-аар тогтоосон. Түүвэр судалгааг хийх явцад Налайх дүүргийн 6-р ангийн сурагчдын тоо хэмжээ нийт түүвэрт тусгаснаас бага байсан тул түүврийн хэмжээ багасаж 1206 болсон. Энэ нь түүврийн хувьд эх олонлогоо төлөөлөх тоо хэмжээний алдаа үүсгэхгүй юм. Учир нь түүвэр олонлогт эх олонлогийн элементүүд бүрэн тусгагдсан болно.

### Механик түүвэр

Сургуулиудын нэрсийн жагсаалтаас эхний сургуулийг сонгож, 5 алхамтайгаар түүвэрлэлт хийхэд дараах сургуулиуд сонгогдсон. Ингэж сонголт хийхдээ түүврийн шалгуур хангаагүй (тухайлбал 6-р анги байхгүй) сургуулийг хасах зарчмаар түүврийн алхамыг хийж, түүврийн нэгж болох сургуулийг сонгов. Судалгаа хийх явцад түүвэрлэлтийн зарчимд зарим нэг алдаа гарсан. Тухайлбал зарим хувийн сургуульд хүний эрхийн хичээл ордоггүй, ОХУ-ын сургалтын хөтөлбөртэй байхад, зарим нь, тодруулбал 14-р сургууль хүний эрхийн хичээл ордог боловч судалгаанд оролцохыг татгалзаж байсан.

#### **1.2.2. Асуулга судалгаа**

Асуулга бол аливаа судалгааны мэдээллийг цуглуулахад өргөнөөр хэрэглэгддэг тоон арга юм. Асуулга судалгаа нь нийгмийн амьдралын ерөнхий хандлага, үзэгдлийг нээн илрүүлэхэд чиглэхийн зэрэгцээ хүмүүсийн санал бодлыг богино цаг хугацаанд илэрхийлдэг онцлогтой.

#### Анкетыг боловсруулах үе шат

Санал асуулгыг зохиоходоо дараах үндсэн хоёр үе шатыг дамжин хийсэн.

*Зорилго ба төлөвлөх үе шатанд* асуулгын хэв шинжийг тогтоон, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан. Ингэхдээ утгуудыг хэмжих асуултууд, хариултын хэлбэрүүд, асуултын дараалал, асуултын тоо хэмжээг тус тус тодорхойлсон ба асуулгыг энгийн, ойлгомжтой болгохын тулд хариултыг хэрхэн тэмдэглэх талаар удирдамж боловсруулсан.





Мэдээлэл цуглуулах үе шатанд мэдээллийг хэрхэн авах техник ажиллагаа болох респондентуудтай холбогдох, асуултыг асуух ба хариултыг тэмдэглэх, дараагийн судалгааг үргэлжлүүлэн авах, мэдээллийг зохион байгуулж цуглуулах зэрэг ажлыг хийсэн.

#### Асуулгын бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүд

Санал асуулгыг хоёр зорилтот бүлэгт чиглэн зохиосон. Үүнд:

- Багшийн санал асуулга
- Сурагчийн санал асуулга

Судалгааны зорилготой холбоотойгоор санал асуулга нь оршил, эхэн, дунд, төгсгөл гэсэн бүтэцтэйгээр зохиогдсон бөгөөд оршил хэсэгт тухайн судалгааны зорилго болон хэрхэн хариулах талаар зааварчилгааг бичсэн болно. Харин эхэн хэсэгт багш, сурагчдын оршин амьдарч байгаа газар, сургууль, ангийн тухай ерөнхий мэдээлэл болон хүний эрхийн хичээлийн талаарх ерөнхий үнэлгээний асуултуудыг оруулж өгсөн. Санал асуулгын дунд хэсэгт судалгааны зорилготой шууд холбогдох хүний эрхийн сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн, сургалтын орчинг өөрсдөөр нь үнэлүүлэх асуултуудыг оруулж өгсөн. Асуулгын төгсгөл хэсэгт хүний эрхийн хичээлийн ач холбогдол болон хариулахад хялбар энгийн асуултуудыг оруулж өгсөн. Санал асуулгад хаалттай, хагас хаалттай, нээлттэй хариултын хувилбаруудыг оруулав. Энд ялангуяа үнэлгээ гаргах, санал бодлоо илэрхийлэх чанарын шинжтэй асуултуудыг нээлттэй байдлаар авсан.

Хүснэгт 2. Тоон судалгаанд хамрагдсан багш сурагчийн мэдээлэл

Аймаг/ нийслэл	Сургуулийн сурагчаас авах асуулга		Сургуулийн багшаас авах асуулга	
	Судалгаанд хамрагдах сургууль	Нийт	Судалгаанд хамрагдах сургууль	Нийт
Улаанбаатар	12/6	578	12/6	36+6
Дархан-Уул	3	105	3	6
Сүхбаатар	3	105	3	6
Өмнөговь	3	105	3	6
Архангай	3	105	3	6
Баян-Өлгий	3	105	3	6
Ховд	3	103	3	6
<b>БҮГД</b>	<b>36</b>	<b>1206</b>	<b>36</b>	<b>78+[106<sup>3</sup>]=184</b>

#### 1.2.3. Чанарын судалгаа

Судалгааг хийхдээ тоон судалгаагаар илэрхийлэн гаргахад бэрхшээлтэй чанарын мэдээллийг гарган харуулах зорилгоор чанарын судалгааны зарим хэлбэрүүд болох фокус бүлгийн хэлэлцүүлэг, ажиглалт, ганцаарчилсан ба экспертийн ярилцлагыг тус тус хийсэн. Чанарын судалгааны аргууд нь учир шалтгааныг нээн илрүүлэхэд чиглэдэг тул судлаачаас ихээхэн ур чадвар шаардахын зэрэгцээ тоон аргатай хослуулан хэрэглэснээр судалгааны үр дүнг илүү ач холбогдолтой болгодог.

<sup>3</sup> 106 сургуулиас хүний эрхийн тэлэслэгчид судалгаа хийсэн.



Судалгаа хийхээр сонгосон газар бүрт судлаачид сурагчидтай бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, уулзалт бүрт 8-12 хүн хамрууллаа. Нийт 20 гаруй бүлгийн ярилцлага (багш, сурагч), 180 ганцаарчилсан ярилцлага (сурагч, багш, сургуулийн удирдлагууд), 3-5 экспертийн ярилцлагыг хийсэн. Ажиглалтын судалгаанд нийслэл, 21 аймгийн төв, 6 сумын нийт 175 ерөнхий боловсролын сургуулийг хамрууллаа.

Хүснэгт 3 Чанарын судалгаанд хамрагдсан хүмүүсийн мэдээлэл

Аймаг/ Нийслэл	Бүлгийн ярилцлага		Ганцаарчилсан ярилцлага			Ажиглалт *
	Сурагч	Багш	Сурагч	Багш	Удирдлага	
Улаанбаатар	6/2 <sup>4</sup>	2	12/6	12/6	36/18	18
Дархан-Уул/ Хөтөл	1/1	1	2/1	2/1	6/3	3
Сүхбаатар/ Онгон	1/1	-	2/1	2/1	6/3	3
Өмнөговь/ Хурмэн	1/1	-	2/1	2/1	6/3	3
Архангай/ Их-Тамир	1/1	-	2/1	2/1	6/3	3
Баян-Өлгий/ Толбо	1/1	-	2/1	2/1	6/3	3
Ховд/ Эрдэнэбүрэн	1/1	-	2/1	2/1	6/3	3
<b>БҮГД</b>	<b>20[10-12]</b>	<b>2[8-10]</b>	<b>36</b>	<b>36</b>	<b>108</b>	<b>36+[14<sup>5</sup>8] = 184</b>

Чанарын судалгаанд аймаг, нийслэлийн 400 гаруй хүмүүс хамрагдав. Үүнээс сурагчийн фокус бүлгийн хэлэлцүүлэгт 200-240, багшийн фокус бүлгийн хэлэлцүүлэгт 24-30, сургуулийн сурагч болон багштай хийх ганцаарчилсан ярилцлагад тус бүр 36, сургуулийн удирдлагатай хийх ганцаарчилсан ярилцлагад 108 хүн тус тус оржээ.

#### Чанарын судалгааны төрөл хэлбэр

Судалгаанд чанарын судалгааны дараах төрөл хэлбэрийг хэрэглэв. Үүнд:

- Бүлгийн ярилцлага (багш, сурагч)
- Ганцаарчилсан ярилцлага (багш, сурагч, сургуулийн удирдлага)
- Экспертийн ярилцлага
- Стандарт ажиглалт

*Бүлгийн ярилцлага* нь судалгааны чанарын аргуудын нэг бөгөөд төслийн үр дүн, нөлөөллийг хувь хүмүүсийн хандлага, хувийн туршлагад үндэслэн ярилцлага хэлбэрээр судлахад чиглэгдсэн.

*Ганцаарчилсан стандарт ярилцлага* нь хувь хүнтэй нүүр тулан ярилцах хэлбэрээр хийгддэг, судалгаанд нэлээд өргөнөөр хэрэглэгддэг арга болно. Энэ удаагийн сурвалжлага нь урьдаас төлөвлөгдсөн стандарт сурвалжлага хэлбэрээр хийгдсэн.

<sup>4</sup> Хувийн сургуулиуд

<sup>5</sup> Хүний эрхийн төлөөлөгчид судалгаа хийсэн.



*Экспертийн ярилцлага* нь ганцаарчилсан стандарт ярилцлагатай төстэй боловч, тухайн асуудлыг сайтар мэдэх, мэргэжлийн хүмүүстэй нүүр тулан ярилцдагаараа судлаачаас мэдлэг болоод хувийн бэлтгэл илүүтэй шаарддаг.

*Стандарт ажиглалтын* хувьд сэтгэл хөдөлгөсөн зүйлийг бус хүмүүст өдөр тутам тохиолдож буй үзэгдлийг танин мэдэхэд чиглэдэг чанарын судалгааны нэгэн төрөл юм.

### *Ярилцлагын бүтэц*

Ярилцлага нь эхэн ба дунд, төгсгөл хэсгээс бүрдэл болно. Ярилцлагын эхэн хэсэгт ярилцлага хөтлөгч өөрийгөө танилцуулахын зэрэгцээ, ярилцлагын мэдээллийн нууцыг хадгалах баталгааг судалгаанд оролцогчдод хандан гаргаж, ярилцлагад идэвхтэй оролцуулахын тулд сэдэл өгөх, ярианд татан оруулах, асуултуудыг оруулсан. Ярилцлагын дунд хэсэгт судалгааны зорилго, хөтөлбөрийн үнэлгээтэй холбоотой, учир шалтгааныг тодруулахад чиглэсэн асуултуудыг оруулсан. Ярилцлагын төгсгөлд судалгаанд оролцогчдын хариултуудад үндэслэн тодруулах, шалгах, дахин шалгах асуултуудыг оруулсан. (Хавсралтаас дэлгэрүүлж харна уу.)

### **1.3. Тест**

Тест нь богино хугацаанд хүмүүсийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог асуулт хариултын цогц юм. Уг тест нь сурагчдын мэдлэгийг шалгах, бусадтай харьцуулах зорилго агуулаагүй бөгөөд өнөөгийн хүний эрхийн сургалт дунд сургуульд хэрхэн явагдаж байгаа, сурагчдад хүний эрхийн хандлага, чадвар хэрхэн төлөвшиж байгааг илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тестэд нийт ЕБС-ийн 1202 сурагч, 184 багш хамрагдав. Багш, сурагчийн тест нь тухайн субъектуудын онцлогтой холбоотойгоор ялгаатай зохиогдсон. Багшийн тест нь нийт 15, сурагчийн тест 12 асуулттай. Тестэд багш, сурагчийн мэдлэг, чадвар; хандлагыг тусгах асуултуудыг оруулж өгсөн.

### **1.4. Судалгааны мэдээллийн боловсруулалт**

Судалгааны тоон мэдээллийг боловсруулалтын программ болох SPSS 11.0 үйлдлийн программ дээр гүйцэтгэсэн.

#### **1.4.1. Мэдээллийн кодлолт ба цэвэрлэлт**

*Кодлолт:* Мэдээллийг цуглуулсаны дараагаар дүнг нэгтгэх үүднээс кодлолтыг SPSS программ дээр хийсэн. Энэ нь анкетын асуултуудын харгалзах утгад харгалзах тоо оноон, эрэмбэлж, анхдагч ба хоёрдогч бүлэглэлт, тоололт хийх боломж олгодог.

*Кодлолтын найдвартай байдал:* Мэдээллийг кодлож, мэдээллийн бааз үүсгэсний дараагаар кодлолт тухайн утгуудыг нэг төрөл байдалтай хэмжиж байгаа эсэх, шинж тэмдгийг дахин кодлолт хийх эсэхийг нягталж үзсэн.

*Цэвэрлэлт:* Мэдээллийг цэвэрлэхдээ алдаатай /missing value/ болон дахин бүлэглэлт хийх боломжгүй мэдээллийг хариулаагүй гэсэн хариулт руу оруулан нэгтгэлээ.



#### 1.4.2. Мэдээлэл боловсруулах үе шат (анхдагч ба хоёрдогч шатны боловсруулалт)

Судалгааны мэдээллийг кодлож, мэдээллийн баазад оруулсны дараа судалгааны анхдагч шатны шинжилгээ болох давтамж ба хувь бодох үйлдлийг гүйцэтгэсэн. Үүний дараа асуулт хоорондын хамаарлыг гаргах үүднээс хоёрдогч шатны шинжилгээ болох солбицуулсан бүлэглэлт хийх, шинж тэмдгээр бүлэглэх, ангилах, дахин харьцуулалт хийх, үр дүнг график хэлбэрээр харуулах үйлдлүүдийг тус тус хийсэн болно.

### Хоёр. ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖМЕНТ

#### 2.1 Ерөнхий боловсролын сургуулийн боловсролын удирдлага, боловсролын стандарт

Монгол улсын ерөнхий боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актаар дамжуулан зохицуулж байна.

Боловсролын удирдлагын тогтолцоо нь боловсролын удирдлага, боловсролын арга зүйн удирдлагаас бүрдэж байгаа бөгөөд боловсролын удирдлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлага хэрэгжүүлэх бөгөөд боловсролын арга зүйн удирдлагыг эрдэм, шинжилгээ, арга зүйн байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар хэрэгжүүлэхээр тус тус Боловсролын тухай хуульд заасан.

Ерөнхий боловсролын байгууллагын удирдлагыг сургуулийн зөвлөл, удирдах зөвлөлийн саналыг харгалзан үүсгэн байгуулагчийн томилсон захирал, эрхлэгч, өөрийн удирдлагыг тус сургуулийн зөвлөл хэрэгжүүлнэ. Тус зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх, бусад байгууллагын төлөөлөл нийт 9-11 гишүүнтэй байх бөгөөд 3 жилийн хугацаагаар хамт олны хурлаас сонгохоор зохицуулжээ. Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжил, арга зүйн удирдлагыг багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл эрхэлж байна.

Бага, дунд боловсролын байгууллагын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авъяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслах явдал юм. Энэ хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгыг хуулиар тогтоож өгсөн. Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын агуулгыг суралцагчдад боловсролын стандартад нийцүүлэн эзэмшүүлэх үүрэгтэй. Боловсролын стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгэж мөрдүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь боловсролын стандартад нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн сайдын баталсан “Сургалтын төлөвлөгөө”-г мөрдөж, боловсролын стандартыг суралцагчдад эзэмшүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Боловсролын стандарт, сургалтын





байгууллагын ажлын түвшин, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд боловсролын улсын хяналтын байгууллага, улсын байцаагч мэргэжлийн хяналт тавьдаг.

Судалгааны хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтнуудын зүгээс ЕБС-ийн хүний эрхийн сургалтыг удирдан зохион байгуулж буй арга туршлага, тулгарч буй бэрхшээл зэргийг тодорхойлохыг зорьсон. ЕБС-ийн хүний эрхийн сургалтын менежментийн тухайд боловсролын хүрээлэн, аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага тодорхой үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. БСШУ-ны сайдын 2003 оны 392 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн хичээлийн эрхлэгчийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод сургалтын менежер буюу хичээлийн эрхлэгч нь боловсролын стандарт, киррикулим, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургуулийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт-шинжилгээ хийж дүгнэлт өгөх чиг үүрэгтэй хэмээн тодорхойлсон.

Гэвч энэхүү чиг үүргээ холбогдох байгууллага, албан тушаалтнууд хангалтгүй биелүүлж байгаа болох нь судалгаанд хамрагдсан сургуулиудийн хүний эрхийн хичээлийн менежментээс харагдаж байна.

### **ШИГТГЭЭ**

*Сургуулийн удирдлагуудыг сургууль дээр сургалтыг удирдан зохион байгуулах менежментэд сургах ажлыг системтэйгээр зохион байгуулах хэрэгтэй байна.*

*Түүнчлэн ярилцлагад оролцсон сургуулийн удирдлагын зүгээс энэ талаар тусгай сургалтын хэрэгцээ байгаа бөгөөд хүний эрхийн хичээлийн талаар тодорхой ойлголт, мэдлэггүй тул энэ хичээлийг зохион байгуулахад хүндрэлтэй байдаг тухайгаа ярьж байсан.*

**Судлаачийн тэмдэглэлээс...**

Судалгааны хүрээнд 1998 онд батлагдсан боловсролын стандарт болон мөн оны Гэгээрлийн сайдын /хуучин нэрээр/ 100 тоот тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд шинжилгээ хийсэн. Уг төлөвлөгөөгөөр хүний эрхийн сургалт нь бие даасан хичээл болж, 6-р ангид хувьсах болон тогтвортой агуулгаар, нийт 18<sup>6</sup>+9<sup>7</sup> цагаар судлагдах ёстой.

Судалгааны хүрээнд нийт төрийн, хувийн өмчийн 175 ерөнхий боловсролын сургуульд ажиглалт хийсэн бөгөөд үүнээс Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан дүүргийн 13 хувийн өмчийн сургуульд “Хүний эрх” хичээл огт ордоггүй, 4 сургууль 6-р анги байхгүй тул ороогүй, 31 сургуульд 9 цагаар, 37 сургуульд 18 цагаар, 38 сургуульд 27 цагаар тус тус орж байна.

Судалгааны хүрээнд Улаанбаатар хотын 53 сургууль (үүнээс хувийн өмчийн 8 сургууль, төрийн өмчийн сургууль 45), хөдөө орон нутгийн 56 сургуулийн (үүнээс хувийн өмчийн 1 сургууль, төрийн өмчийн сургууль 55), нийт 108 сургуулийн 256 6-р ангийн журналын сэдвийн хөтлөлт, хичээл заасан цагийн байдалд ажиглалт хийсэн.

Улаанбаатар хотын хамрагдсан сургуулиудын 37.7%-д нь 27 цагаар, 39.6% нь 18 цагаар, 18.8% нь 9 цагаар хүний эрх хичээлийг зааж байна. Мөн хөтөлбөрт тусгагдсан цагаас илүү буюу 4 улиралд нийт 36 цаг орсон Улаанбаатар хотын 2

<sup>6</sup> Боловсролын Хөгжлийн Сургууль, ТНУ-ны Боловсролын стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж, УБ, 1998, 22-р тал

<sup>7</sup> Хувьсах агуулгын заавал судлах цаг



сургууль байгаагийн нэг нь төрийн өмчийн нөгөө нь хувийн өмчийн ЕБС байна. (Сүхбаатар дүүргийн 11-р сургууль, Искра сургууль) Хөдөө орон нутгийн сургуулиудын 37.5%-д нь 9 цагаар, 28.5%-д нь 18 цагаар, 33.9%-д нь 27 цагаар орж байна.

Хүснэгт 4. Хичээлийг судалж буй цаг

№		9 цаг	18 цаг	27 цаг
1.	Хотод	10	21	20
2.	Хөдөөд	21	16	19
	<b>НИЙТ</b>	<b>31</b>	<b>37</b>	<b>38</b>

Боловсролын стандартыг хангах, сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг сургууль дээрээ зохион байгуулна гэдэг нь нэг багшид тухайн хичээлийн цагийг тавьж өгснөөр хэрэгжчихгүй бөгөөд үүний тулд багшид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажилд нь хяналт-шинжилгээ хийх зэрэг байдлаар бүрэн хэрэгжиж, үүний дүнд хүүхдүүд хүний эрхийн чанартай боловсролыг эзэмших боломжтой болно.

### ШИГТГЭЭ 1

*Би түүх, нийгмийн ухааны чиглэлийн хүн учраас энэ хичээлийн ач холбогдлыг их үнэлдэг.*

*Би өөр мэргэжлийнх болохоор энэ талаар сайн мэдэхгүй байна. Хөндлөнгөөс харахад шинэ мэдээ, материал л хэрэгтэй болов уу гэж бодож байна.*

*Би өөрөө физик, математикийн багш болохоор энэ талаар сайн хэлж мэдэхгүй байна.*

**Дунд сургуулийн хичээлийн эрхлэгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...**

*Манай сургуульд багшид цагийг нь өгдөг. багш оногдсон цагтаа түүхээ, эрх зүйгээ заах нь багшийн хэрэг байдаг. Хичээлийн эрхлэгч тэр бүр мэддэггүй, түүх, эрх зүйн цаг гээд өгчихдөг.*

*Би биологийн багштайгаа хувааж заасан. Улирлын хувьд давхцсан. Сүүлийн бүлгийг тэр багш, би өмнөх бүлгүүдийг заасан. Хүүхдүүд нэг зэрэг 2 эрх зүйн хичээл орохоор гайхаад байдаг. Тодорхой эрхийн талаар би ярьж байхад, нөгөө багш маань маргаан шийдвэрлэх аргын талаар ярих болдог.*

**УБ хотын төрийн болон хувийн өмчийн сургуулийн багш нартай хийсэн бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс**

ЕБС-ийн хүний эрх сургалтын менежменттэй холбоотой гарч буй нийтлэг зөрчлүүдийг дурьдвал:

- Хүний эрх хичээлийн судлах ёстой цагийг дутуу болон хичээлийн цагт нь өөр хичээл оруулах /Ихэвчлэн түүхийн хичээл/
- Хүний эрх хичээлийг тогтвортой, хувьсах агуулгын хэмээн ялгавартай авч үзэж, хэд хэдэн багшаар зэрэг заалгах /энэ тохиолдолд багш нарын уялдаа муу байх/
- Сургалтын менежерүүд журналын хөтлөлтийг шалгах замаар стандартын хангалт, сургалтын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавихгүй байх

### ШИГТГЭЭ

*Зарим сургуулиуд эрх зүйн хичээлийн цагийг тавьж, орж байгаа гэсэн хэдий ч журналд хөтлөлт огт хийгдээгүй /өмнөх улирлын хичээл хөтлөгдөөгүй/ байсан зэрэг дутагдал Хөвд, Баян-Өлгий аймаг, Налайх дүүрэгт ажиллаж байхад тохиолдож байсан.*

**Судлаачийн тэмдэглэлээс...**

Хүний эрхийн сургалтын менежмент нь зөвхөн ЕБС-иас гадна аймаг, нийслэлийн боловсролын газар арга зүйн удирдлагаар хангах, боловсролын хяналтын байгууллага нь стандартын хяналтыг тогтмол хийх гэх мэт удирдлагын



шат шатны тогтолцоо байгаа билээ. Гэтэл эдгээр байгууллагуудын зүгээс ч ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөнд хяналт сул тавьдаг, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангадаггүй болохын тод илрэл энэ юм.

## 2.2 Багшлах боловсон хүчний талаарх зарим асуудал


ЕБС-ийн менежментийн нэг чухал асуудал бол багш, бусад ажилтны мэргэжил дээшлүүлэх ажлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулах явдал билээ. Энэ хүрээнд эрх зүйн хичээл тэр дундаа хүний эрхийн хичээлийг зааж байгаа багш нарыг давтан сургах, бэлтгэх асуудал ямар түвшинд байгааг анхаарч үзэх ёстой. Учир нь ЕБС-ийн эрх зүйн хичээл, сурах бичиг, хичээлийн хөтөлбөр бүхий л зүйлүүд бүрэн шинэчлэгдсэн. Тиймээс энэ хичээлийг заах багшлах боловсон хүчнийг бэлтгэх явдал сургалтын чанар, сурагчдын боловсрол эзэмших эрхээ бүрэн дүүрэн эдлэх нэг чухал нөхцөл юм.

Судалгаанд хамрагдсан багш нарын нас, хүйс, ажилласан жил, мэргэжлийг харуулбал:




## Багш нарын ажилласан жил

Ajilsan\_byleg






## Багш нарын насны бүлэг



## Багш нарын хүйс



Эрх зүйн хичээлийг зааж байгаа багш нарын хувьд ихэвчлэн түүх, нийгмийн ухааны мэргэжлийн багш зааж байгаа хэдий ч сургууль болон багшаас үл шалтгаалан өөр мэргэжлийн багшаар заалгах явдал түгээмэл байна. Түүнчлэн хүний эрхийн хичээлийг зааж байгаа багш нарын дийлэнх хувь нь 11 дээш жил ажилласан багш нар байгаа нь анхаарал татаж байна.

Судалгааны явцад багш нар өөрсөддөө учирдаг нийтлэг бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон юм. Үүнд:

- ✓ Багшийн ном байдаггүй
- ✓ Хүний эрхийн мэдлэг хангалттай биш байна
- ✓ Багш нарт нэмэлт мэдээлэл байхгүй
- ✓ Төрийн өмчийн сургуулийн анги дүүргэлт их байдаг тул идэвхтэй арга ашиглан сургалт зохион байгуулахад хүндрэлтэй
- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүн хомс
- ✓ Багш нар өөрсдөө энэ хичээлийн ач холбогдлыг ойлгохгүй байх
- ✓ Монгол хэл дээр байгаа сурах бичгээр казак хэл дээр хичээл явуулах хүндрэлтэй байдаг

Судалгаанаас харахад хүний эрхийн хичээлийг түүх, нийгмийн ухааны багш нар заах нь илүү үр дүнтэй болох нь харагдаж байна. Харин түүх, нийгмийн ухаанаас өөр мэргэжлийн багшаар заалгахдаа мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлэхгүй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх нэг гол хүчин зүйл болж байна. Мөн багш нар заах арга зүйн чиглэлийн сургалтанд хамрагдсан гэх боловч





ихэвчлэн хагас, бүтэн өдрийн сургалтанд суусан болохоос системтэйгээр хүний эрх хичээлийг заахаар бэлтгэгдээгүй байна.

### **ШИГТГЭЭ 1**

*Эрх зүйн хичээлийг аман хичээл гэдэг утгаар нь дорд үзэх байдал байна. Эрх зүйн багш математик заа гэвэл чадахгүй шүү дээ. Үүнтэй адил дуу, физик, хөдөлмөр зэрэг өөр мэргэжлийн багш эрх зүй заахад хүндрэлтэй, тиймээс эрх зүйн хичээлийг зааж байгаа багш ядаж сургалтанд сууж, гэрчилгээ авсан байх ёстой байх.*

*Гэхдээ тэр бүр нэг багш тодорхой ангийн эрх зүйн хичээлийг тогтмол заагаад байдаггүй. Би энэ жил 5-р анги авлаа гэхэд 5-ийн түүх, эрх зүйг заана, ирэх жил зургаа, дараа жил 7 гээд. Тэгэхлээр 6-р ангийн эрх зүйн хичээлийг энэ жил заагаад дахиад 6-р ангитай болтлоо 8 жил нэг циклтэйгээр нэг заана гэсэн үг. Тийм учраас туршлага хуримтлуулж чадахгүй байна. /Энэ асуудал хувийн сургуульд байхгүй. Нэг багш дагнаж хичээлээ заадаг. Цөөхөн хүүхэдтэй, цөөхөн багштай байдаг./*

*Нэг бүлэгт би өөр багштай хамтарч, энэ хичээлийг 1 улиралд заасан. Би сурах бичгийн дундах нэг бүлгийг нөгөө багшдаа өгөөд, өөрөө 2 бүлгийг авсан. Заримдаа бид 2 нэг сэдвийг зэрэг заачих тохиолдол ч байдаг байсан. Хэдийгээр номынхоо дагуу хувиарлаж авсан ч гэсэн мэргэжлийн биш хүн учраас зарим хичээлийг би заах шаардлагатай болдог. Хичээлээ бүрэн дүүрэн заахын тулд үсчиж давхисаар байгаад таардаг.*

**УБ хотын төрийн болон хувийн эмчийн сургуулийн багш нартай хийсэн бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс...**

Эрх зүйн хичээл тэр дундаа хүний эрхийн хичээлийг зааж байгаа багш нарыг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах явдал хүний эрхийн сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх гол арга замын нэг юм. Үүний тулд аймаг, нийслэлийн боловсролын газарт ажиллаж байгаа нийгмийн ухааны арга зүйч нараар дамжуулан системтэйгээр, тасралтгүй сургалтыг зохион байгуулах цаг болжээ. Түүнчлэн сургуулийн удирдлагууд ч мөн ялгаагүй сургууль дээрээ заах аргазүйн нэгдлийг дэмжих замаар сургалтын чанарыг дээшлүүлэх төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах боломж нээлттэй байгаа хэдий ч санаачилга дутуу ажиллаж байна. Эндээс харахад сургалтын менежер хүлээсэн гол чиг үүргээ биелүүлэх талаар хангалтгүй анхаарал тавьж байгаа нь харагдаж байна. Энэ нь боловсролын стандартыг зөрчиж буйгаас гадна, хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхийг давхар хөсөрдүүлж байгаа явдал мөн.

Хүний эрхийн сургалтын менежментийн гол хүчин зүйл болсон багшийн асуудалд стандартын үүднээс хандах цаг болсон нь судалгааны явцад харагдаж байна. Өөрөөр хэлбэл тухайн хичээлийг заах багш нь ямар мэргэжилтэй, хэдэн жил заасан, захирал, хичээлийн эрхлэгчийн хүсэл зориг зэргээс үл хамаарсан, тухайн хичээлийг заах багшид тавигдах наад захын стандарт, шаардлагыг хангасан байх явдал нь хүний эрхийн боловсролын чанар, үр дүнд нөлөөлөх, дээшлүүлэх хөшүүрэг болох боломжтой юм. Гэвч өнөөдрийн байдлаар хүний эрхийн хичээлийг заах багшид тавих шаардлага, наад захын стандартыг тогтоогоогүй байна.

### **2.3 Сэдвийн дүгнэлт**

ЕБС-д эрх зүйн боловсрол олгох хөтөлбөр 1998-2003 оны хооронд бүрэн шинэчлэгдэж, сурах бичгийг шинэ арга зүйгээр боловсруулж, үүнийг дагалдуулан багшийн номыг гаргасан бөгөөд үүнд хүний эрхийн хичээл багтаж байгаа юм.



Гэсэн хэдий ч хичээлийг тогтоосон цагаар оруулахгүй байх, стандартын эзэмшилт хангалтгүй, сургалтын чанар, үр дүн доогуур түвшинд байгаа нь энэхүү сургалтыг удирдан зохион байгуулах байгууллага, албан тушаалтны ажлын хариуцлагатай салшгүй холбоотой юм.

ЕБС-ийн хувьд боловсролын удирдлагын нэг чухал хэсэг болох сургуулийн ажлыг үнэлэх, багшийг үнэлэх шалгуур нь боловсронгуй биш байгаагаас хичээлүүдэд зэрэглэл тогтоох, зарим хичээлд ач холбогдол өгөхгүй байх зэрэг нийтлэг дутагдал байна.

Энэ хүрээнд байгаа өөр нэг дутагдалтай тал бол аймаг, нийслэлийн боловсролын газрын зүгээс ЕБС-ийн түүх, нийгмийн ухааны боловсролын стандартыг эзэмшүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх ажил хангалтгүй түвшинд байгаа явдал юм. Боловсролын хяналтын байгууллагаас боловсролын стандартын хэрэгжилтэд тавих хяналт сул байгаа нь ч мөн сөргөөр нөлөөлж байна.

Энэ бүхнээс үзэхэд боловсролын удирдлагын менежментийн ур чадвараас сургалтын чанар, үр өгөөж шууд хамаарч байна. Сургалтын менежментийг зөв удирдан явуулахад боловсролын харилцаанд оролцогч талуудыг (боловсролын газар, хяналтын алба, сургуулийн удирдлага) боловсролын удирдахуйн ухаанд сургах хэрэгцээ шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна.

Дээрх дүгнэлтүүдийг хийх болсон бусад үндэслэлүүд нь судалгааны тайлангийн дараагийн хэсгүүдэд тодорхой тусгагдсан болно.

## Гурав. ХҮНИЙ ЭРХ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### 3.1 Хүний эрхийн боловсролын агуулгын тухай товчхон

*“ Боловсрол нь бие хүнийг өв тэгш хүмүүжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой ”*

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалаас...

Дээрх тодорхойлолтыг хүний эрхийн боловсролын талаар өгөгдсөн сонгодог тодорхойлолт хэмээн мэргэжилтнүүд үздэг. Энэхүү тодорхойлолтыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12-р сарын 10-нд баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан бөгөөд энэ цаг үеэс хойш гарсан хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүдэд мөн л боловсролын хэрэгцээ, ач холбогдлыг тусгасаар ирсэн. Тухайлбал:

- Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пакт /2, 13-р зүйл/
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /2-р зүйл/
- Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Конвенци /2, 7-р зүйл/
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци /2,10-р зүйл/
- Хүүхдийн эрхийн тухай Конвенц /4,17,19, 29-р зүйл/
- Эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгийгээр, хүний нэр төрийг лоромжлон харьцахын эсрэг Конвенц /2, 10-р зүйл/



Гэвч 1990-ээд оныг хүртэл хүний эрхийн боловсролыг тууштайгаар хөгжүүлэх асуудал орхигдсоор байсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1995-2004 оныг "Хүний эрхийн боловсролын 10 жил" болгон зарласан нь энэ асуудлыг шинэ шатанд гаргасан. 2004 онд тус 10 жилийн хүрээнд гарсан ололт, амжилт, алдаа оноогоо дүгнэж, улмаар "Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр"-ийг 2005 оноос хэрэгжүүлж эхлэхээр Ерөнхий Ассамблейгаас батлаад байна. Энэ хүрээнд ЕБС-ийн хүний эрхийн боловсролын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх ажлыг улс орнуудын Засгийн газрууд эхлээд байна.

Хувь хүн эрхээ мэддэг, хэрэгжүүлж чаддаг болох нь дэлхий нийтийн энх тайван, хувь хүмүүсийн дээд зэргийн хөгжлийг хангах чухал арга зам болно. Ингэснээр нийгэмдээ эрхээ хэрэгжүүлж чаддаг болж бусдын эрхийг хүндлэнэ, тэгвэл эрх тэгш иргэдийн нийгэм дэх эрхийг хамгаалах үйл явцыг мэдэхийг хүснэ, ингэхийн тулд шийдвэр гаргах үйл явцад хүний идэвхтэй оролцоо шаардагдана. Энэ бүгд мэдлэгийн чанарыг шаардах ба бүрэн хэрэгжилт нь ур чадвараас хамаарна. Эцсийн бүлэгт энэ бүгдийг боловсрол хангана.

Манай улсын ЕБС-ийн тухайд 1-10 ангид судалж буй эрх зүйн сургалтын хүрээнд хүний эрхийн боловсролын агуулга багтаж байна гэж үзэж болохоор байна. Дунд сургуулийн хүний эрхийн боловсролын агуулга, сурах бичгийг МНХ-ийн "Хууль бидний амьдралд" хөтөлбөрийн хүрээнд бүрэн шинэчилсэн бөгөөд хөтөлбөрийг боловсруулахдаа сурагчдад цогц чадамжийг олгоход ихээхэн анхаарсан явдал билээ. Хөтөлбөр нь үндсэндээ бүрэн шинэчлэгдсэн хэмээж буйн учир нь эрх зүйн боловсролыг олгохдоо агуулга, арга зүйг давхар анхаарч үзсэн явдал юм. Нөгөө талаар нь анги тус бүрийн эрх зүйн хичээлийн агуулгад хүний эрхийн боловсролын агуулга ямар нэгэн хэлбэрээр байна хэмээн үзэж болохоор байна.

НҮБХЭДКГ-аас хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан хүний эрхийн боловсролыг эзэмшүүлэхэд чиглэмж өгөх зорилгоор "Хүний эрхийн хичээлийг заах нь"<sup>8</sup> сэдэвтэй гарын авлагыг боловсруулсан бөгөөд тус номд орсон хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүний эрхийн боловсролын агуулга, хийж болох практик үйл ажиллагааны талаар тусгасан хүснэгтийг орууллаа. Үүнийг өөрсдийн орны хүний эрхийн боловсролын агуулга, хөтөлбөртэй харьцуулан үзэж болох юм.

Хүснэгт 5. Хүний эрхийн боловсрол

Түвшин	Зорилго	Түлхүүр ойлголт	Дадлага	Хүний эрхийн тодорхой асуудал	Хүний эрхийн стандарт, тогтолцоо, баримт бичгүүд
3-7 насны хүүхэд	Өөрийгөө хүндэтгэх, эх, нарыгаа хүндэтгэх, Бусдыг хүндэтгэх, Эцэг, багш	Өөрөө Нийгэм Хувийн хариуцлага	Үүрэг Үнэнч, шударга ёс Өөрийгөө илэрхийлэх/сонсох хамтран ажиллах/оролцох Жижиг багаар ажиллах Бие даах ажил Учир шалтгаан, үр нөлөөг ойлгох	Арьс үндсээр алагчлах Хүйсээр алагчлах Шударга бус явдал Гэм хор учруулах /биеийн болон сэтгэл санааны/	Ангийн дүрэм, журам Гэр бүлийн амьдрал Хамт олны хэм хэмжээ ХЭТТ Хүүхдийн эрхийн тухай Конвенц





			Асдчилсан үзэл Зөрчилдөөнийг шийдвэрлэх		
8-11 насны хүүхэд	Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг Иргэний харъяалал Хүслийг хэрэгцээ, эрхээс ялгах	Хувийн эрх Бүлгийн эрх Эрх чөлөө Тэгш байдал Шударга ёс Хууль дээдлэх зарчим Засгийн газар Аюулгүй байдал	Ялгаатай байдлын үнэлэмж Шударга ёс Бодит байдал болон үзэл бодлыг ялгаж салгах Сургууль болон олон нийтийн үйлчилгээг үнэлэх Иргэний оролцоо	Ялгаварлан гадуурхалт/Хууль бус Ядуурал/Өлсгөлөн Шударга бус байдал Гарал үүслээр алагчлах Аминч үзэл Идэвхгүй	Хүний эрхийн түүх Орон нутгийн, үндэсний эрх зүйн систем ОН, Үндэсний хүний эрхийн түүх ЮНЕСКО, ЮНИСЕФ ТББ
12-14 насны хүүхэд	Тодорхой хүний эрхийн талаарх мэдлэг	Олон улсын эрх зүй Дэлхийн энх тайван байдал Дэлхийн хөгжил Дэлхийн улс төрийн эдийн засаг Дэлхийн байгаль орчин	Өөр хандлагын тухай ойлголт Судалгаа хийх/Мэдээлэл цуглуулах Мэдээлэл солилцох	Харанхуй бүдүүлэг байх Ноомой хүлцэнгүй байх Ичгүүргүй эрээ цээргүй байх Улс төрийн хавчлага Колончлол/ Империализм Эдийн засгийн даяаршил Хүрээлэн буй орчны доройтол	НҮБ-ын Пактууд Арьс үндсээр ялгаварлан гадуурхахыг устгах Хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссар Бус нутгийн хүний эрхийн понвенц
15-17 насны хүүхэд	Хүний эрхийн түгээмэл стандарт Хүний эрхийн интеграцлалыг хувийн ухамсар, зан байдал болгох	Ёс суртахууны Ёс суртахууны хариуцлага, бичиг үсэг тайлагдах	Иргэний үйл ажиллагаанд оролцох Иргэний үүргийг биелүүлэх	Төрлөөр үстгах гэмт хэрэг Эрүү шүүлт тулгах Дайны гэмт хэрэг	Женевийн Конвенц Сэдэвчилсэн конвенциуд Хүний эрхийн стандартын хөгжил

### 3.2 Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын агуулга

#### 3.2.1. Хүний эрхийн боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө

Манай улс 1938-1939 оны хичээлийн жилээс эхлэн VII ангид судлах “БНМАУ-ын үндсэн хууль” хичээлийн хүрээнд хүний эрхийн агуулгыг тусган судалж ирсэн түүхтэй. Гэгээрлийн сайдын 1998 оны 100-р тушаалаар батлагдсан ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд эрх зүйн хичээлийг 1-10-р анги хүртэл үзэхээр заасан бөгөөд 6-р ангид “Хүний эрх” хичээлийг бие даалган оруулсан явдал бол хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих ажилд гарсан томоохон дэвшил билээ. Энэхүү сургалтын төлөвлөгөөнд эрх зүйн хичээлийг хувьсах болон тогтвортой агуулгаар судлахаар заасан байна. МННХ-ийн “Хууль бидний амьдралд” хөтөлбөрийн хүрээнд энэхүү хичээлийн хөтөлбөрийг сурах бичгийн хамт бүрэн шинэчилсэн явдал бол хүний эрхийн боловсролын салбарт гарсан том амжилт юм.





Энэ ажлын хүрээнд хүний эрхийн хичээлийн сурах бичгийг шинэчлэн, 2003 оноос эхлэн ЕБС-д ашиглаж эхэлсэн байна.

Харин 2004 онд батлагдсан “Ерөнхий боловсролын стандарт”-д “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-ын хүрээнд хүний эрхийн боловсролын агуулга, үнэлгээний стандартыг тусгаж өгсөн нь хүний эрхийн боловсролыг эзэмшүүлэх ажлыг шинэ шатанд гаргасан ач холбогдолтой юм. Тухайлбал нэг ангийн хүрээнд яригдаад өнгөрдөг байсан хүний эрхийн агуулгыг “ай”-аар дамжуулан боловсролын бүх түвшинд судалж, сурагчдад хүний эрхийн мэдлэг, хандлага, чадварыг төлөвшүүлэхээр оруулсан байна. Энэ нь нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хүний эрхийн тухай ойлголт, агуулгыг хэрхэн хүргэж болох талаар НҮБХЭДКГ-аас гаргасан зөвлөмжид нилээд дөхөж очсон чухал өөрчлөлт болсон. Энэхүү стандарт нь юуг, яаж шинэчилсэн бэ?

**Зорилго, хүлээх үр дүнгийн хувьд:** Хүний эрхийн хичээлээр дамжуулан суралцагчдад хүний эрхийн зохих мэдлэг, өөрийн эрхээ хэрэгжүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар суулгаж, хүний эрхийг хүндэтгэдэг, ялгаатай соёлыг хүндэтгэдэг “ЦОГЦ ЧАДАМЖ”-ийг төлөвшүүлэх нь хүний эрхийн боловсролын зорилго юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлснээр түргэн хурдацтай өөрчлөгдөн хөгжиж, бас шийдвэрлэхийг шаардсан бэрхшээлтэй асуудал улам бүр тулгарч байгаа өнөөгийн XXI зуунд ажиллаж, амьдрах, шийдвэр гаргах арга барил, технологийг эзэмшүүлж, бусадтай хамтран ажилладаг, тэдний соёлыг ойлгон хүндэтгэдэг иргэн болсон төлөвшүүлэх үр дүнд хүрэх билээ.

**Агуулгын хувьд:** Түүх, нийгмийн ухааны боловсролын Эрх зүйн боловсролын агуулгын стандарт нь “Дүрэм, журам, хууль”, “Эрх, үүрэг”, “Төрийн байгуулал”, “Салбар эрх зүй” гэсэн агуулгын айтай. Агуулгын ай нь үндсэн, тогтвортой, энгийнээс нарийн, хөнгөнөөс хүндэд шилжих мэдлэг, ухагдахууныг тээгч бөгөөд анхан, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд анхан шатны болон үндсэн ойлголт нь хэвээр хадгалагдаж, агуулгын хувьд гүнзгийрэн баяжиж байх мэдлэгийн цөм /хүрээ/ юм. Энэ нь судлагдахууны агуулгыг шинжлэх ухааны түүхэн мэдлэгт тулгуурлан сонгон боловсруулж байсан хандлагыг өөрчилж аль болох шинэ зууны иргэнд төлөвшсөн байвал зохих хүний эрхийн мэдлэг бүтээх /K1/, хүний эрхийн мэдлэгээ ашиглан хийж сурах /K2/, амьдарч сурах /K3/, нийгэмшин иргэншиж сурах /K4/ зэрэг цогц чадамжид баримжаалан сонгосноороо боловсролын стандартад орсон цоо шинэ үзэл хандлага билээ.

**“Эрх, үүрэг” агуулгын айн залгамж холбоо, гүнзгийрэлт**

Шатлал	K <sub>1</sub> -ийг эзэмшүүлэх агуулга	K <sub>2</sub> -ийг эзэмшүүлэх агуулга	K <sub>3</sub> -ийг эзэмшүүлэх агуулга	K <sub>4</sub> -ийг эзэмшүүлэх агуулга
Бага боловсрол	Хүүхэд ямар эрх, үүрэгтэй вэ Хүүхдийн эрхийг яаж хамгаалж, баталгаажуулсан байдаг вэ Дүрмийг биелүүлэхгүй байж болох уу	Хүүхдийн эрх хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулах, өөрийн цуглуулсан мэдээ, баримтыг нэгтгэн дүгнэх, танилцуулах Хүүхдийн эрхийн зөрчлийг ялган таниж, түүнийг арилгах, таслан зогсоход хэн, юу хийж болох талаар ярилцах		Өөрийн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад ажиглалт, дүгнэлт хийлгэх



НҮБХЭДИГ-ын гарын баримт 14 тал	Тодорхой хүний эрхийн талаарх мэдлэг Олон улсын эрх зүй Дэлхийн энх тайван байдал Дэлхийн хөгжил Дэлхийн улс төрийн эдийн засаг Дэлхийн байгаль орчин НҮБ-ын Пактууд	Харахнхуй бүдүүлэг байх Ноомой хүлцэнгүй байх Ичгүүргүй эрээ цээргүй байх Улс төрийн хавчлага Колончлол/ Империализм Эдийн засгийн даяаршил Хүрээлэн буй орчны Арьс үндсээр ялгаварлан гадуурхахыг устгах Хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссар Бүс нутгийн хүний эрхийн понвенц	Судалгаа хийх/Мэдээлэл цуглуулах Мэдээлэл солилцох	Өөр хандлагын тухай ойлголт
Суурь боловсрол	Хүний эрх, эрх чөлөө Хувийн, нийгэм, соёлын болон эдийн засгийн, улс төрийн эрх Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүний эрхийг хамгаалах олон улсын механизмын талаарх ойлголт, МУ-ын Үндсэн хууль	Хүний эрх хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулах, өөрийн нэгтгэн дүгнэх, танилцуулах Хүний эрхийн зөрчлийг ялган таньж, түүний арилгах арга замыг дэвшүүлэх, таслан зогсооход хэн, юу хийж болох талаар ярилцах	Зөрчигдсөн эрхийг сэргээхэд хуулийг болон олон улсын механизмыг ашиглах дадлага хийх материалыг бэлтгэх	Бусдын эрхийг хүндэтгэж, өөр үзэл бодлыг /соёлыг/ хүлээн зөвшөөрөх, хүлээцтэй хандлагыг төлөвшүүлэхүйц дадлага ажил бэлтгэх
Бүрэн дүнд боловсрол	Эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг	Эрх зүйн харилцаанд оролцогчдын эрхээ эдлэх боломж, үүргийг биелүүлж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар өөрийн санал, дүгнэлттэй болох боломжийг бүрдүүлэх		Хариуцлага хүлээх чадвартай болж байгаа эсэхийг ажиглах

**Арга зүйн хувьд:** Эрх зүйн сургалтын зарчим, зорилго, агуулгын өөрчлөлт нь энэ хичээлийн арга, аргачлалыг шинэчлэхийг шаардаж байгаа юм. Энэхүү стандартын арга зүйн хөгжлийн үндсээр сургалтын арга зүйн хөгжлийн шинэлэг хандлагыг уламжлалт арга зүйтэй хослуулан бүтээлчээр хэрэгжүүлэхийг багш нарт зөвлөмжилсэн бошно.

**Үнэлгээний хувьд:** Сургалтын зорилго, хүлээх үр дүн нь “ЦОГЦ ЧАДАМЖ” төлөвшүүлэхэд баримжаалсантай холбоотойгоор мэдлэгийг баримжаалж үнэлдэг байсан практикийг өөрчлөх арга замыг эрж хайсан нь энэ стандартын нэгэн шинэлэг тал юм. Энэ хүрээнд “ЦОГЦ ЧАДАМЖ”-ийг үнэлэх шалгуурыг боловсруулсан байна.



Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх, 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хангах зорилгоор батлагдсан БСШУ-ны сайдын “Сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгын үлгэрчилсэн хүрээг турших тухай” 132 тоот тушаалд Нийгмийн ухааны хүрээнд иргэншил хэмээх нэршлээр эрх зүйн хичээлүүд орсон бөгөөд хүний эрх, эрх зүйн агуулгыг 7-р ангид 35 цаг орохоор зааж өгсөн байна. Үүний гол үр дүн нь өмнө нь ойлгомжгүй байсан зохицуулалтыг тодорхой болгож, тогтвортой, хувьсах гэх мэт ялгавартай байдлаар цагийг зохицуулаагүй оруулсан нь ЕБС-ийн хүний эрхийн сургалтанд томоохон хувь нэмэр оруулах нь дамжиггүй юм.

Түүнчлэн түүх, нийгмийн ухааны боловсролын стандартын зөвлөмж, агуулгын үлгэрчилсэн хүрээ зэргийг тогтоосон баримт бичгүүдийг гаргасан нь энэхүү хичээлийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд ихээхэн тустай болжээ.

### 3.2.2. Сурах бичиг, багшийн номны агуулга

МННХ-ийн “Хууль бидний амьдралд” төслийн хүрээнд боловсруулагдсан “Хүний эрх бүх нийтэд” сурах бичиг нь хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, сургалтын шинэ шатанд гаргахад чухал арга хэмжээ болсон. Уг сурах бичгийг Монгол Улсын Гэгээрлийн Яам /хуучин нэрээр/, МННХ-ийн хамтын ажиллагааны меморандумын дагуу 2003 онд хэвлэсэн бөгөөд ерөнхий боловсролын бүхий л сургуульд энэхүү сурах бичгээр хичээллэх боломжтой болсон байна.

Энэхүү сурах бичиг нь хүний эрхийн тухай Үндсэн хуулийн хэмжээнд судалдаг байсан хуучин агуулгаас татгалзсан, хүний эрхийн хичээлийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс сургалтын арга зүйг боловсруулахад анхаарал тавьсан зэргээрээ түүхэн чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн энэхүү сурах бичгийг барьж хичээл заах багшид зориулсан номыг боловсруулж өгсөн нь шинэлэг үйл явдал байсан. Багшийн ном нь “Хүний эрх” хичээлийг заахаар бэлтгэгдэж амжаагүй байсан багш нарт чухал гарын авлага болсон.

Тус сурах бичиг нь нийт 5 бүлэг, хавсралтаас бүрдэж байсан. Үүнд:

#### I бүлэг: Хүний эрхийн тухай ойлголт

- ✓ Хүний эрх гэж юу вэ?
- ✓ ХЭТТ-ын тухай ойлголт
- ✓ Хүний эрх үүргийг яаж ангилдаг вэ?
- ✓ Хүний эрхийн талаар юу сурч мэдсэн бэ?

#### II бүлэг: Ардчилал дахь улс төрийн эрх

- ✓ Төрийн хэрэгт оролцох нь чухал уу?
- ✓ Хүмүүс ардчилсан төрийн үйл ажиллагаанд хэрхэн оролцдог вэ?
- ✓ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө
- ✓ Ардчилал дахь улс төрийн эрхийн тухай юу сурч мэдсэн бэ?

#### III бүлэг: Аюулгүй байдал ба хувийн эрх чөлөө

- ✓ Аюулгүй байдлыг хангахын тулд хүний эрхийг хязгаарлах
- ✓ Халдашгүй чөлөөтэй байх эрх
- ✓ Шүүхийн ажиллагаа шударга байх
- ✓ Шоронгийн нөхцөл ямар байх ёстой вэ?
- ✓ Цаазаар авах ял хэрэгтэй юу?
- ✓ Аюулгүй байдал ба хувийн эрх чөлөөний талаар юу сурч мэдсэн бэ?

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН





#### **IV бүлэг: Нийгэм, эдийн засаг болон соёлын эрх**

- ✓ Нийгэм, эдийн засаг болон соёлын эрх гэж юу вэ?
- ✓ Ялгаварлан гадуурхахын эсрэг эрх
- ✓ Гэр бүлийн эрх ба хамгаалалт
- ✓ Хүн бүрийн боловсрол эзэмших эрх
- ✓ Хоол хүнс, орон байр, эрүүл мэндийг хамгаалах эрхийн тухай
- ✓ Хувийн өмч ба нийтийн хэрэгцээ
- ✓ Хөдөлмөрлөх эрх: хөдөлмөрийн нөхцөл, цалин, маргаан

#### **V бүлэг: Хүний эрх зөрчигдсөн нөхцөлд яах вэ?**

- ✓ Хүч хэрэглэхгүйгээр зөрчлийг шийдэх аргууд
- ✓ Хэлэлцээ хийх
- ✓ Гуравдагч этгээдийг оролцуулан шүүн хэлэлцэх
- ✓ Зуучлах
- ✓ Орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрхийг яаж хамгаалдаг вэ?
- ✓ Хүний эрхийг хамгаалах талаар та юу хийж чадах вэ?

Сурах бичиг нь зөвхөн мэдлэгийн хэсэгт анхаарал тавиад зогсоогүй чадвар эзэмшүүлэх, хандлагыг төлөвшүүлэхэд анхаарснаараа ач холбогдолтой. Түүнчлэн хүний эрх, эрх чөлөө, түүний талаарх ерөнхий ойлголтыг өгөхөөс гадна зарим тодорхой эрхүүд дээр ажиллуулахаар оруулсан нь эрхийн тухай асуудлыг мөн чанараар нь ойлгох, зөрчлийг таньж мэдүүлэхэд тустай болсон. Хамгийн сүүлийн бүлэгт хүний эрхийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, тэр дундаа хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх олон арга замууд, хүний эрхийг хамгаалах тогтолцоо зэргийн талаар оруулж өгснөөрөө нилээд цогц сурах бичиг болсон юм.

Сурах бичигт зөвхөн хичээлүүдээс гадна хүний эрхийн толь бичиг, хүний эрхийн түгээмэл Тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлэг зэргийг багтаасан хавсралтыг оруулсан нь нилээд практик ач холбогдолтой болсон.

Мөн түүнчлэн бүлэг тус бүрт зорилгыг дэвшүүлэн тавьж, түлхүүр үгсийг хийж өгсөн бөгөөд бүлэг бүрийн төгсгөлд дүгнэж ярилцах аргачлалыг оруулж өгсөн зэргээрээ өмнө нь боловсруулагдаж байсан сурах бичгээс ялгаатай юм.

Сурах бичгийн өөр нэг ач холбогдолтой зүйл бол тус номыг ашиглах хүүхдийн нас, сэтгэхүйд тохируулж илүү сонирхолтой, ойлгомжтой хэлбэрээр хэвлэлийн эхийг бэлтгэсэн явдал юм. Үүнд урт үргэлжилсэн үгээс татгалзсан, сэдэв тус бүр дээр гол санааг тусгаж өгсөн, эргэцүүлэн ярилцах асуултыг тавьсан, сургалтын идэвхтэй аргыг хэрэглэхэд зориулж сургалтын зарим хэрэглэгдэхүүнийг номонд тусгаж өгсөн зэргийг нэрлэж болох юм.

#### **ШИГТГЭЭ**

*Энэ номыг бүрэн шинэчлэх хэрэгтэй. Хичээлийн гол зорилго бол иргэнийг төлөвшүүлэхэд чиглэх ёстой. Жишээ баримт нь сургуулийн, гэр орны орчинтой нь холбоотой байх нь илүү ач холбогдолтой.*

*Экспертийн ярилцлагын тэмдэглэлээс...*



### ШИГТГЭЭ

Насны онцлогт нь сурах бичиг арай томдоод байна. Агуулга нь насанд тохирохгүй байна.

Системчлэгдсэн байх хэрэгтэй Тухайлбал хүний эрхийн тухай ойлголт гэсэн бүлэгт хүний эрх, эрх чөлөө гэж тийм зүйлийг хэлнэ гэсэн тодорхойлолт нь байдаггүй.

Уг нь текст бага, хялбар, ойлгомжтой схем, диаграмм, графиктай байвал сонирхолтой байна. Зарим бичвэр нь гадгад хэлнээс муу орчуулсан юм шиг хүүхдүүдэд ойлгомжгүй байдаг. Авсан тохиолдол нь их хийсвэр санагддаг 6-р ангийнханд аль болох бодитой тохиолдол байвал зүгээр Тухайлбал, цагдаа ба оршин суугчдын хийсэн хэлцэл гэхэд хүүхэд битгий хэл бид ойлгоход хэцүү, уг хэллэг хүнд байдаг Сансар, одхон гаригтай жишээ л хамгийн зүгээр нь.

Баригдмал, редактораасаа эмээсэн шинжтэй бичигдсэн санагддаг. Жишээ нь, хүч хэрэглэлгүйгээр маргаан шийдвэрлэх арга гээд 3 арга жагсаасан байдаг. Тэгэхлээр номон дээр бичсэнээр бол ийм л 3 арга байдаг юм байна гэж ойлгохоор байдаг. Гэтэл, уг нь зөрчил гэж ийм юм байдаг, хүч хэрэглэлгүйгээр ингэж шийдэж болдог гэх маягаар тайлбарлахгүй л бол 3 хан л арга байдаг юм байна гэж буруу ойлгож болохоор байдаг. 12-13 настай хүүхдүүдийн хувьд шорон цагдаа, хэдэн орон цаазаар авах ялттай тухай заах нь төдийлөн тохиромжтой биш. Дүрд тоглоно гэхээр шоронгийн хоригдол болгох, зураг зуруулах гэхээр шоронгийн зураг зуруулах жишээтэй Бараг хүүхдэд сөргөөр нөлөөлөхүйц байдаг.

Сурах бичигт 6-р ангийн хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон жишээнүүд тэр бүр орж чадаагүй. Хамт ширээнд сууж байгаа хүүхдүүд бие биенийхээ эд зүйлийг зөвшөөрөлгүй авах нь халдашгүй эрхийн асуудал гэдгийг л ойлгуулах хэрэгтэй байхад шоронгийн талаар сайн мэдэхгүй хүүхдээр шоронгийн хоригдол болгож жүжигчилсэн тоглолт хийлгэнэ гэдэг бол утгагүй хэрэг. Хүүхдүүд бас зааж байгаа зүйлийг буруугаар хүлээж авах хандлагатай байдаг. Сургуулийнхаа сандал ширээгээ эвдэж эсэргүүцэл илэрхийлж байгаа нь бойкотлож байгаа юм уу, эрхээ хамгаалж байгаа юм уу гэж асууж байх жишээтэй. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх гарын авлагуудын сонирхолтой, ойлгомжтой байдлыг дуурайвал зохистой.

**Багш нарын бүлэгтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...**

Судалгааны хүрээнд сурах бичгийн агуулгыг үнэлэх асуултуудыг ганцаарчилсан, бүлгийн, экспертийн ярилцлага, анкетын арга зэргийн хүрээнд тавьсан.

### ШИГТГЭЭ

Бараг байхгүй дээ Гэхдээ нэг юм байдаг. Ном нь жаахан ойлгомжгүй. Заримд нь бид нарын IQ хүрэхгүй юм байдаг (Зарим хүүхдүүд боломжийн ш дээ гэж байлаа.) Илүү тайлбарлавал гоё. Бас ийм зузаан бол гоё. Ном хүрэлцээтэй, хүн бүрт нэг байдаг. Асуудал шийдвэрлэх дээрээ байдаг. Асуулт нь тодорхой биш байдаг, салаа утгатай байдаг. Нэг юм асуугаад тэр нь арай өөрөөр явчихсан байдаг. Байдаг, гэхдээ арай цөөхөн байдаг.

ХЭТТ, жишээ, тохиолдол, асуулт бүгдийг нь ойлгодог. Зураг нь таалагдсан. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж байгаа дүрийг харуулсан, усанд оруулдаггүй зураг таалагдаагүй, ялгаварлаж байгаа нь таалагдаагүй. Сурах бичгийн тохиолдлын дагуу ашиглавал гоё. Сурах бичгээс товчилсон үгийг нь ойлгодоггүй. Бусад нь ойлгомжтой. Монгол хэл дээр сурах бичиг ашиглаж чадах боловч казак хэл дээр байвал илүү сайн ойлгоно. Эдгээр хүүхдүүдтэй орчуулгатай ярилцсан болно.

**Сурагчдын бүлэгтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...**

"Хүний эрх бүх нийтэд" сурах бичиг нь бүхэлдээ шинэлэг арга зүйгээр боловсруулагдсан сайн сурах бичиг болсон, хүний эрхийн сургалтыг шинэ түвшинд гаргахад чухал түлхэц өгсөн хэдий ч сайжруулах, шинэчлэн боловсруулах, ингэхдээ тухайн насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:

1. Сурах бичгийн бүтэц, агуулгын талаар:



- а) Бүлгүүд нь нилээд системтэйгээр тодорхойлогдсон хэдий ч эрхийн гурван үеийн хүрээнд авч үзэх нь олон улсын хүний эрхийн нийтлэг ангилалтай ижил байх талаасаа ач холбогдолтой. Хүүхдүүдэд ч мөн олон янзын тодорхойлолтыг өгснөөс илүү агуулгыг хүргэх боломжтой болно. 3 дахь үеийн эрхийн тухай асуудал, энэ дотроо хүрээлэн буй орчин, байгаль орчин, хөгжих эрхийн талаар оруулж өгөх хэрэгтэй юм.
- б) Бүлэг тус бүрийн сэдвийг сонгохдоо анхаарч үзээгүй. Жишээ нь, 2-р бүлгийн хувьд төрийн хэрэгт оролцох нь чухал уу гэсэн хэсгээс ардчилал дахь оролцоо, сургуулийн ардчилал гэх мэт сэдвийг оруулах нь илүү чухал байж болох 3-р бүлгийн хүрээнд нэр төр, бие махбодь, хувийн орон зай халдашгүй байх тухай асуудал мөн сургууль дээр бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ? гэх мэт асуудлыг хөндөх нь тухайн ангиллын хүрээнд багтах эрхийн мөн чанарыг ойлгож, мэдэх, хандлага төлөвшихөд илүү хэрэгтэй. 4-р бүлгийн хүрээнд Ялгаварлан гадуурхахын эсрэг эрхийг энэ бүлэгт оруулсан нь логикийн алдаанд хүргэсэн. Ялгаварлан гадуурхахгүй байх тухай зарчим бол хүний эрхийн суурь зарчмын нэг тул илүү 1-р бүлэгт оруулж авч үзэх шаардлагатай. 5-р бүлгийн тухайд хүний эрхийн зөрчлийг шийдэж болох олон арга замуудаас сонгон авсан, үр дүнтэй, цаг хугацаа хэмнэсэн арга замууд гэх мэт ерөнхий тайлбар байхгүй, ингэснээр эдгээр аргын ач холбогдлыг сайн гаргаж чадаагүй. Хүний эрхийг хамгаалах орон нутаг, үндэсний механизмын талаарх хэсэг ойлгомж муутай, ач холбогдол багатай. Жишээ нь шүүх хүний эрхийг хамгаалахад ямар үүрэгтэй вэ гэх мэт тус бүрээр нь гаргаж ирэх нь ойлгомжтой байна. Олон улсын Засгийн газрын байгууллага хэмээх тодорхойлолтод НҮБ-ын системийн байгууллагуудыг оруулж тайлбарласан нь мөн л ач холбогдол багатай. Хүүхдүүд, багшийн хувьд НҮБ хэмээх нэршил нь илүү ойлгомжтой байж болох, нөгөө талаасаа Хүний эрхийн хороо гэх мэт байгууллагууд нь илүү хувь хүний бие даасан, мэргэшсэн байдлаар ажилладаг тул, тэдний талаар буруу ташаа ойлголт төрүүлж болохуйц байна.
- в) Бүлэг тус бүрт эрхүүдийг сонгон авахдаа тухайн эрхийн хүрээнд яригддаг гол, ерөнхий зүйлийг авсан болохоос, тухайн эрхийн мөн чанар, ач холбогдлыг гаргаж ирж чадаагүй байна. Үүний улмаас тухайн эрхийн тухай үзсэн хүүхдүүд эрхийн хүрээнд гарч байгаа зөрчлийг хүний эрхийн зөрчил хэмээн олж харах чадвар хөгжөөгүй байна.
2. Сурах бичиг нь хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголтыг цогцоор нь өгөхөд илүүтэй анхаарал тавьснаас бус энэхүү хичээлийг заах бүлгийнхээ нас,








сэтгэхүйн онцлогийг харгалзан үзээгүй.

- a. Тодорхой эрхийн хүрээнд авч байгаа жишээ тохиолдол нь 12-13 насны хүүхдийн хувьд танин мэдэж амжаагүй, мэдэх боломжгүй зүйлийн талаар байна. Жишээ нь: Халдашгүй эрх-Шоронгийн нөхцөл гэх мэт Үүний оронд сургууль, гэр бүлийн хүрээнд жишээ авах
  - b. Тухайн эрхийн талаар илүү хуулийн хэллэгээр, ерөнхий тайлбарууд оруулсан. Үүний оронд тухайн эрхийн мөн чанар, яагаад хүнд энэ эрхийг заавал эдлүүлэх ёстой байдаг тухай тайлбарлах нь хүүхдүүдэд илүү ач холбогдолтой.
  - c. Тодорхой эрхийг зааж байхдаа тухайн эрхийг эдлэхдээ хүлээж байгаа үүргийн талаарх хэсгийг зайлшгүй оруулах нь бусдын эрхэд хүндэтгэлтэй хандах хандлагыг төлөвшүүлэх ач холбогдолтой. Жишээ нь: Боловсрол эзэмших эрх-Боловсролын байгууллагын тавьж буй шаардлагыг биелүүлэх, суурь боловсролын заавал эзэмших гэх мэт
3. Багшийн ном нь сурах бичгийн дагуу хичээлийг заахад мэдлэгийг олгох, хандлагыг төлөвшүүлэхэд хангалттай тусламж болж чадахгүй байна. Судалгаанд хамрагдсан багш нарын дунд багшийн номтой багш тун ховор байсан. Түүнээс гадна багш нарын хүний эрхийн боловсрол өндөр биш байгаа өнөө үед багшийн ном нь зөвхөн сурах бичгийн хичээлийг дагалдаж яваа болохоос хүний эрхийн тухай онолын, цэгцтэй, системтэй мэдлэг олгох агуулгыг багтааж чадаагүй байна. Багш нарын тухайд хүүхдэд зааж байгаа тухайн сэдвээ мэдэхээс илүүтэй, хүний эрхийн системтэй мэдлэг, чадвар, хандлагатай байж хичээлийг чанартай, үр өгөөжтэй явуулах боломж бүрдэнэ.



Багш нар хүний эрхийн хичээлийг заахдаа сурах бичиг гол гарын авлага болдог бөгөөд 81% нь агуулгын хувьд тусламж болж чаддаг хэмээн дүгнэсэн юм.

### 3.2.3. ЕБС-ийн хүний эрхийн сургалтын агуулга өнөөгийн түвшинд

Ерөнхий боловсролд зааж буй "Хүний эрх" хичээл нь бүлэг тус бүртээ зорилгыг дэвшүүлэн тавьсан бөгөөд энэхүү зорилгод чиглэсэн агуулгыг боловсруулсан нь шинэ алхам юм. Гэсэн хэдий ч зорилгодоо хүрэхийн тулд сурах бичигт тавьсан сэдвүүдийг хэрхэн сонгож, ямар арга зүйгээр явуулах вэ гэдэг нь өөрөө маш чухал асуудал мөн.



Судалгааны хүрээнд нийт 108 сургуулийн 256 журналд ажиглалт хийж, хүний эрхийн хичээлийн хүрээнд заасан сэдэвт дүгнэлт хийсэн болно. Хүний эрх хичээлийг 1 улиралд 9 цаг заасан орон нутгийн сургуулиудад ихэвчлэн "Хүний эрхийн тухай ойлголт", "ХЭТТ", "Эрх, үүргийг ангилах нь", "Улс төрийн эрх", "Аюулгүй байдлыг хангахын тулд хүний эрхийг хязгаарлах нь", "Халдашгүй эрх", "Шүүхийн үйл ажиллагаа шударга байх нь" зэрэг сэдвүүдийг сонгож заасан нь нийтлэг байна. Мөн цөөн сургуульд "Сурч боловсрох эрх", "Нийгэм, эдийн засаг, соёлын эрх", "Хүч хэрэглэхгүйгээр маргаан шийдвэрлэх аргууд", "Хүний эрх зөрчигдсөн тохиолдолд яах вэ" зэрэг хичээлүүдийг орсон байна. Орхон аймгийн 7-р сургууль, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын дунд сургууль, Хэнтий аймгийн Хан Хэнтий цогцолбор сургуулиудад 6-р ангийн "Хүний эрх, бүх нийтэд" сурах бичгийн агуулгаас огт өөр буюу иргэний үндсэн эрх, үүрэг харъяалал, хүүхдийн эрх гэх мэт нэлээд ерөнхий сэдвүүдийг заасан байна.

Хүний эрх хичээлийг 1 улиралд 9 цаг заадаг УБ хотын сургуулиудад орон нутгийн сургуулиудын нэг адил "Хүний эрхийн тухай ойлголт", "ХЭТТ", "Эрх, үүргийг ангилах нь", "Улс төрийн эрх", "Аюулгүй байдлыг хангахын тулд хүний эрхийг хязгаарлах нь" сэдвүүдийг заасан байна. БГД-ийн 54-р сургуульд хүний эрхийн асуудалтай огт холбоогүй буюу эрүүл ахуйн сэдэвтэй хичээлүүдийг үзсэн нь тэмдэглэгджээ. Мөн "Олонлог" сургуульд Хүний эрх бүх нийтэд номын агуулгыг илүү хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчилж, "Хүний эрхийн тухай ойлголт", "Хүүхдийн эрх", "МУ-д хүний эрхийн хэрхэн хамгаалдаг вэ", "Сурагч хүний эрх, үүрэг" сэдэвт хичээлүүд 4-р улиралд 5 цаг орсон байна.

Хүний эрх хичээлийг 18 цаг заадаг сургуулиудад "Хүний эрхийн тухай ойлголт", "ХЭТТ", "Эрх, үүргийг ангилах нь", "Улс төрийн эрх", "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө", "Аюулгүй байдлыг хангахын тулд хүний эрхийг хязгаарлах нь", "Халдашгүй эрх", "Шүүхийн үйл ажиллагаа шударга байх нь", "Цаазаар авах ял", "Нийгэм, соёлын эрх", "Гэр бүлийн эрх ба хамгаалалт", "Ялгаварлан гадуурхахын эсрэг эрх", "Боловсрол эзэмших эрх", "Эрүүл мэндээ хамгаалуулах эрх" гэсэн сэдвүүдийг нийтлэг үзсэн байна. Энэ байдал хот, хөдөөгийн сургуулиуд дээр онцын ялгаагүй байлаа. Харин "Хүч хэрэглэхгүйгээр маргаан шийдвэрлэх нь" хичээлийг 1 сургуульд, "Хүний эрхийг хамгаалах ОУ-ын, үндэсний болон орон нутгийн байгууллагууд" хичээлийг 2 сургуульд л үзсэн байна. Мөн номын агуулгад байгаагаас өөр сэдвүүдийг Увс аймгийн 5-р сургууль, Сэлэнгэ аймгийн 2-р сургууль, Өмнөговь аймгийн 1-р сургуулийн 6д, 6б, 6в ангиудад үзсэн байна.

СБД-ийн 58-р сургууль, Өмнөговь аймгийн 1-р сургууль зэрэг зарим сургуулийн 6-р ангиудад үзсэн сэдэв ялгаатай байна. Зарим ангид номын сэдвүүдийн дагуу орсон байхад зарим ангид хуучин номны дагуу "Иргэний эрх, үүрэг", "Хуулийн этгээд", "Өмчийн эрх зүй", "Үндсэн хууль", "Хүүхдийн эрх" зэрэг сэдвүүд оржээ.

Хүний эрх хичээлийг 27 цагаар үздэг сургуулиудын хувьд номын агуулгад заасан орох ёстой хичээлүүдийг ерөнхийд заасан гэж үзэж болох боловч бүх сэдвийг заасан сургууль хөдөөд 8, хотод 3 байна. Мөн БГД-ийн 56-р сургууль, ХУД-ийн 10-р сургууль, Налайх дүүргийн Чандмань цогцолбор зэрэг сургуулиуд номын агуулгаас зарим сэдвийг орж, бусад цагтаа "Гэм хорын тухай ойлголт", "Өрхийн төсөв ба зарцуулалт", "Яаж ажил хэрэгч хүн болох вэ", "ХЭАА ба компани" зэрэг сэдвүүд орсон байна.

Мөн Улаанбаатар хотын 2 сургуульд хүний эрх хичээлийг 4 улирал буюу 36 цагаар орсон байх бөгөөд сэдвийн дэлгэрэнгүй хөтлөлт хийгдсэн 11-р сургуульд номын агуулгад заасан сэдвүүдийг зааж дуусаад дахин эхлэж заасан байна.


ЕБС-иудын журналын ажиглалтад дүгнэлт хийж үзэхэд 9 цаг орж байгаа сургуулиудын хувьд номны 1, 2-р бүлгээс л түүвэрлэн зааж байхад, 18 цаг үздэг сургуулиуд 1-4 бүлгээс түүвэрлэн заасан байх жишээтэй, харин 27 цаг үздэг сургуулиуд л сурах бичгийн хүрээнд сэдвүүдийг цогцоор нь зааж чадсан байна. Багш нарыг хичээл сонголтоо хэрхэн хийдгийг сонирхоход ямар нэгэн баримталдаг зарчим гэхээс илүүтэй өөрийнхөө хувьд чухал гэж үзсэн сэдвийг заадаг тухай ярьж байсан.

Энэ нь нөгөө талаасаа “Хүний эрх” хичээл өөрөө шинэ, энэхүү хичээлийг заах арга зүй нь мөн шинэлэг, багш нар төдийлөн зааж дадаагүй байдаг зэрэг олон шалтгааны улмаас өөртөө заахад хялбар хичээлийг илүү сонгож заахад хүрдэг байж болох юм. Түүнчлэн энэ хичээлийг хоёр багш зэрэг заах тохиолдол гарахад багш нар сэдвийг давхцуулан заах, нэг улиралд хамт зааж байгаа тохиолдолд 2 өөр бүлгийг зэрэг заах гэх мэт байж боломгүй зөрчлүүд гарч байсан. Энэ бүхнээс үүсч байгаа сөрөг үр дагавар бол хүүхдүүдийн хүний эрхийн боловсрол эзэмших эрх ноцтойгоор зөрчигдөхөд л хүрнэ. Хичээлийн агуулга, заах сэдвийг багшид нэг бүрчлэн заах шаардлагагүй боловч, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, сургалтыг стандарт, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах ёстой сургалтын менежерийн ажлын хариуцлага сул байгаатай энэ асуудал шууд холбоотой юм.

Багшийн ном, сурах бичиг нь гарсан, орох ёстой цагийг тогтоосон хичээлийн орсон байдал ийм их ялгавартай байгаа нь сургалтын менежмент, багш нарын мэдлэг, чадвар, хүний эрхийн сургалтанд хандах хайнга хандлага зэрэгтэй холбоотой болох нь өмнөх бүлэгт тодорхой авч үзсэн.


Хүний эрхийн сургалтын агуулгыг хүргэх багш нарын мэдлэг, хандлага, сурагчдын олж авсан мэдлэг, хүний эрхийн хандлагыг тогтоох зорилгоор сурах бичгийн хүрээнд сорил бэлтгэж хүний эрх хичээлийг зааж байгаа нийт 184 багш, энэ хичээлд бүрэн суусан 6, 7-р ангийн 1202 сурагчаас сорил авсан. Энэхүү сорилын ажлыг засахад багш нарын чанар 0,01 хувь, амжилт 0,26 хувь, хүүхдүүдийн чанар 0,01 хувь, хүүхдүүдийн амжилт 0,11 хувь /1165 сурагчийн сорилоос, 41 сорил дутуу/ байсан. Сорил нь мэдлэг шалгах болон хандлагыг тогтоох зорилготой. Мэдлэг шалгах асуултад багтсан хүний эрх, эрх чөлөөний тухай, ангилал, тухайн эрхийн мөн чанар, түүнийг хангах, хамгаалах механизм, хүний эрхийн зөрчил зэргийн талаарх багш нарын мэдлэг хангалтгүй байгаа нь сурагчдын хүний эрхийн сургалтын стандартын эзэмшилт хангалтгүй байх гол шалтгаан болж байна.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал хэзээ батлагдсан бэ? /багшийн тест/







Монгол улсын иргэнийг өөр улсад шилжүүлэн өгч болох уу? /багшийн тест/



Хандлага тогтоох зорилгоор ялгаварлан гадуурхсан тохиолдол оруулж, ялгаварлан гадуурхалт мөн үү хэмээсэн асуулт оруулахад багш нарын 59,2 хувь, сурагчдын 62,7 хувь нь ялгаварлан гадуурхалт биш, багш нарын 5,6 хувь, сурагчдын 18,9 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Эндээс хүний эрхийн суурь зарчмуудын нэг болох ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын мөн чанарыг багш нарын 64,8 хувь, сурагчдын 81,6 хувь нь мэдэхгүй байгаа нь харагдаж байна.



Мөн сурагчдаас “Буруутай сурагчийг багш цохиж шийтгэх нь зөв үү” хэмээх хандлагын асуулт тавихад нийт сурагчдын 47,7 хувь нь зөв, 28,6 хувь нь огт буруу, 6 хувь нь мэдэхгүй, 17,8 хувь нь эргэлзэж байна хэмээн хариулсан. Эндээс дүгнэхэд хүний эрхийн боловсролын чанар ЕБС-ийн хувьд хангалтгүй байгаагийн илрэл юм.





### 3.3 Сэдвийн дүгнэлт

Ерөнхий боловсролын стандарт шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 6-р ангид орж байсан "Хүний эрх" хичээл нь "ай"-гаар дамжуулагдан боловсролын түвшин бүрт орох болсон, хичээлийн нэршлийг тодорхой болгосон, өмнөх шигээ хувьсах, тогтвортой хэмээн ялгаагүй зэрэг сайн талууд байгаа нь амжилттай хэрэгжвэл хүний эрхийн боловсролын стандартын хангалтанд сайнаар нөлөөлөх боломжтой хэмээн үзэж байна.

Сурах бичгийн тухайд энэ номыг дахин шинэчилж, боловсруулах хэрэгтэй болохыг судалгааны дүнгүүд харуулж байна. Гол нь энэхүү хичээлийн агуулга нь тухайн ангийн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт төдийлөн тохиромжтой бус байгаа болох нь судалгаанаас харагдаж байна. Тиймээс энэ номын агуулгыг шинэчлэх хэрэгтэй юм. Багшийн номын тухайд багш нарт хүний эрхийн ерөнхий ойлголт өгч чадахуйц асуудлыг багтаасан тусгай бүлгийг номонд оруулах хэрэгтэй байна.

ЕБС-ийн хүний эрхийн хичээл нь орж буй цагаасаа хамаараад хичээлийн агуулга мөн ялгаагүй янз бүр байдаг тал ажиглагдаж байсан. Мөн түүнчлэн тус хичээлийг зааж байгаа багш нарын хүний эрхийн мэдлэг, чадвар, хандлага доогуур түвшинд байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Зорилго нь зөвхөн мэдлэг биш, хандлага, чадвар зэрэг цогц чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн байгаа тул сургалтыг идэвхтэй аргаар явуулахгүйгээр энэ зорилгод хүрэх боломжгүй юм. Тайлангийн дараах хэсэгт арга зүйн тухай авч үзсэн болно.

## Дөрөв. ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТЫН ОРЧИН

### 4.1 ЕБС дахь хүний эрхийн сургалтын технологийн дүр төрх

ЕБС дахь хүний эрхийн сургалтын технологийн дүр төрхийг тодорхойлох нь "Хүний эрхийн боловсрол- ЕБС-д" судалгааны нэг үндсэн зорилго юм. Учир нь хүний эрхийн боловсрол олгох сургалт нь ЕБС-д судлагдаж байгаа бусад хичээлээс ялгагдах арга зүйн онцлогтой байдаг бөгөөд энэхүү онцлогийг тусгах нь тухайн судлагдахууныг судалснаар сурагчдын хүрэх үр дүнд ихээхэн нөлөөтэй юм. Хүний эрхийн сургалтын арга зүйн онцлог нь дараах хүчин зүйлтэй холбоотой. Үүнд:

- Хүний эрх нь мөн чанарынхаа хувьд түгээмэл, зайлшгүй, тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх, эрхэм зэргийг хүндэтгэх зарчимтай тул мөн л тийм зарчим дээр үндэслэсэн сургалт явуулах хэрэгтэй болдог.
- Хүний эрхийн хичээлийн уур амьсгал нь сургалтанд оролцогчид бие биеэ ойлгосон, хүндэтгэсэн, хүлээн зөвшөөрсөн өөрөөр хэлбэл ардчилсан байх шаардлагатай байдаг.
- Хүний эрхийн сургалт нь оролцогчдод үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бүлэг, хамт олныг төлөөлөх, шийдвэр гаргах, үндэслэл нотолгоо дэвшүүлэх, бусдыг сонсох, санал нийлэхгүй ч гэсэн тэдний санал бодлыг хүндэтгэх, бусдын соёлыг хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллах, хүлээцтэй байх зэрэг иргэний ардчилсан нийгмийн үнэт чадваруудыг төлөвшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг.
- Хүний эрхийн боловсрол нь тухайн хичээлээс гадна анги хамт олон, сургууль, гэр бүл, найз нөхөд зэрэг хүүхдийг хүрээлэн буй нийгмийн бичил орчноор дамжин олгогддог.

Дээрх онцлогийг харгалзсан сургалтын технологи нь оролцоонд тулгуурлах зарчимд суурилах явдал юм.

#### **4.2 Хүний эрхийн сургалтын технологийг боловсронгуй болгох, шинэчлэх талаар хийгдсэн зарим ажил**

Сургалтын технологи гэдэг нь мэдлэг олгох, чадвар, хандлага төлөвшүүлэх үйлийг илүү үр дүнтэй болгох нарийн үйл явц, түүнд оролцогч талуудын үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулах аргачлал юм. Бид ямар технологийг өнөөдөр шинэчлэгдсэн, шаардлага хангасан гэж үзэж байна вэ? Энэ бол прагматчилагдсан боловсролын технологи юм.

Боловсролын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээг ахуй амьдрал, ажил үйлдвэрлэлтэй холбон суралцагчдын хэрэгцээ сонирхол, дадлага туршлагад түшиглэх үндсэн дээр ажиллаж, амьдрахад нь хэрэгцээтэй мэдлэг эзэмшүүлэх, энэ мэдлэгээ аливаа асуудлыг шийдвэрлэхэд бүтээлчээр хэрэглэх цогц чадамжтай болгон төлөвшүүлэхэд шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд прагматчилахын гол утга санаа оршиж байдаг.

ЕБС-ийн хүний эрхийн сургалтын технологийг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр МНХ (Соросын сан)-ийн “Хууль бидний амьдралд” хөтөлбөрийн хүрээнд 1998-2003 онуудад хийгдсэн үйл ажиллагаа нь нилээн цогц шинжтэй хэрэгжсэн байна. Эрх зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэхдээ хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролд ихээхэн анхаарал тавьсан бөгөөд анги тус бүрийн хичээлийн агуулгад хүний эрхийн асуудлыг тусгахыг хичээснээс гадна 6-р ангид “Хүний эрх” хичээлийг судлахаар боловсруулсан байна. Шинэчилсэн хөтөлбөрийн дагуу 2003 оноос орж эхэлсэн хүний эрхийн хичээлийн зорилго бол сурагчдыг хүний эрх, эрх чөлөөний талаар мэддэг, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх арга замыг ашиглаж чаддаг, бусдын эрхэд хүндэтгэлтэй ханддаг болгон төлөвшүүлэх явдал юм. Энэхүү цогц чадамжийг сурагчдад олгоход сургалтыг уламжлалт аргаар явуулах нь хангалттай биш бөгөөд багш нар сургалтын олон арга техникийг хэрхэн хэрэглэж байгаа болон сургуулийн удирдлага, хамт олны зүгээс сургуулийн байр, анги танхимд хүний эрхийн орчинг хэрхэн бүрдүүлсэн бэ? зэрэг олон хүчин зүйлээс хамаарах болоод байна.

“Хууль Бидний Амьдралд” хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн сургалтыг прагматчилах нөхцөлүүдийг бий болгох чиглэлээр хийгдсэн олон ажлын нэг нь арга зүйн шинэчлэл юм. Хөтөлбөрийн энэ хэсгээр багш нарын арга зүйн шинэчлэл нь сурагчдад чанартай мэдлэг, хэрэгцээтэй чадварыг эзэмшүүлэх үндсэн нөхцөл гэж үзсэний дээр сургалтын олон талт үйл ажиллагаа явагдсан байна. Энэ шинэчлэлийг арга зүйн шинэ үзэл баримтлалыг таниулах, ойлгуулах сургалт, үүнийг түгээн дэлгэрүүлэх чадвар бүхий үндэсний боловсон хүчин бэлтгэх сургалт, сургалтын материал сурах бичиг боловсруулах сургалт, эрх зүйн мэдлэг чадварын үнэлгээний сургалтуудаар дамжуулан хийсэн байна.

Эрх зүйн сургалтын арга зүй өөрчлөгдсөнөөр анги танхимд ардчилсан уур амьсгал бүрдүүлж, багш сурагчийн харилцаа тэгш, нээлттэй, хамтын ажиллагааны хэлбэртэй болох ба суралцагчдын бие даасан, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхийн сацуу, хувь хүний өөрийн байр суурь, өөрийн хандлагыг бий болгох, түүнийгээ нотлох, хамгаалах, хамтран ажиллах чадвар төлөвшүүлэх боломжийг нээж өгөх юм.





Дээрх хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдаж 2003 онд хэвлэгдсэн “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн багшийн номонд нийт 24 сэдвийн заах арга зүйг боловсруулан оруулсан байна.

“Хууль бидний амьдралд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан туршлага, сурах бичиг, гарын авлага нь боловсролын шинэчилсэн стандарт боловсруулахад чухал хэрэглэгдэхүүн болжээ.

2004 онд батлагдсан “Ерөнхий боловсролын шинэ стандарт”-д “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-ын хүрээнд хүний эрхийн боловсролын стандартыг тусгаж өгсөн нь хүний эрхийн боловсролыг шинэ шатанд гаргасан ач холбогдолтой юм.

Ерөнхий боловсролын стандартад түүх, нийгмийн ухаан (ТНУ)-ны түүний дотор хүний эрхийн боловсролыг олгох арга зүйн хөгжлийн үндсийг зааж өгсөн байна. ТНУ-ны сургалтын зарчим, зорилго, агуулгын өөрчлөлт нь энэ хичээлийн арга, аргачлалыг шинэчлэхийг шаардсан бөгөөд стандартын арга зүйн хөгжлийн үндэс хэсэгт арга зүйн үндсэн зарчмуудыг зааж өгсөн байна.

**Боломжийг тэнцүү олгох зарчим**

*Хариуцлагатай сонголтыг оновчтой хийх*

*Чөлөөт өрсөлдөөнд шударгаар оролцох*

*Боловсоржих боломжийг тэнцүү олгох*

• Мэдээлэл харилцаа давамгайлсан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд ажиллаж, амьдрах иргэнд боловсрох боломжийг тэнцүү олгож буй нь хүмүүнлэг, ардчилсан ёс болно.

• Боловсрол эзэмших боломжийг тэнцүү олгох, иргэдэд аливаа сонголтыг оновчтой хийх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд шударгаар оролцох, тухайлбал, ашгийн төлөө өрсөлдөх, ажил олох, ашигтай мэдээллийг аль болох богино хугацаанд олж боловсруулах, түүнийг хүч болгон хэрэглэх, бүтээлчээр ажиллах болон таатай амьдрахын оюуны хүч, баялагийн үндэс болох цогц чадамжийг төлөвшүүлнэ

*ТНУ-ны боловсролыг хүн бүр олж болохын биологи, физиологи, танин мэдэхүйн үндэслэл*

Суралцагчдын нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн байдал болон үндэстэн, ястны хэл, соёл, шашин, арьс өнгөний ялгааг үл харгалзан тэдэнд ТНУ-ны боловсролыг эзэмших боломжийг тэнцүү олгох явдал нь аливаа түвшний ТНУ-ны кирриключийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэх ажилд баримтлах үндсэн зарчим болно

**Судлах агуулгыг сонгох зарчим**

Судлах агуулгыг сонгохдоо кирриключ өөрчлөлтөд инвариант байх, хувь хүний боломж, хэрэгцээнд тулгуурлах, нийгмийн болон бүлгийн хэрэгцээ, сонирхлыг харгалзах, шинжлэх ухаанч байх зарчмыг тус тус баримтлана



### Багшлахуйн зарчим

Багшийн үйл ажиллагаа болон шийдэл нь боловсролын бодлого, философи, психологи, эпистемологи, антропологи, эрх зүй, менежментийн үндэслэлтэй ТНУ-ны дидактикийн зарчимд тулгуурласан байна.

### Суралцахуйн зарчим

ТНУ-нд суралцахуй нь эзэмшихүйн зүй тогтлын дагуу суралцагчдын бүтээлч үйл ажиллагаагаар мэдлэгээ зохиомжлон бүтээх зарчимд тулгуурласан байна.

### Технологийн зарчим

- *ТНУ-ны боловсрол олгоход технологийг ашиглах*
- *Мэдээлэл харилцааны технологийг ТНУ-нд хэрэглэх*

Энэхүү зарчмыг багшлахуйд баримтласнаар суралцагчдад ТНУ-ны боловсрол олгоход технологийг ашиглах, мөн тэднийг мэдээлэл харилцааны технологид суралцахад бэлтгэх нь ТНУ-ны кирриклүмийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх болон хөгжүүлэх ажилд баримтлах үндсэн зарчим мөн.

/ТНУ-ны боловсролын стандартаас/

ЕБС-ийн хүний эрхийн сургалтын технологи, арга зүйг боловсронгуй болгох талаар сүүлийн жилүүдэд багагүй ажил хийсэн байна. Гэвч судалгааны дүнгээс харахад дараах зүйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Үүнд:

- Тодорхой хэмжээний цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулж хийсэн ажлын үр дүнг тогтворжуулах, эерэг үр дүнг авч үлдэх талаар холбогдох байгууллагаас зохистой менежмент хийх шаардлагатай. Сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын сургуульд хэрэгжсэн томоохон төслүүдийн дүр дүн замхран арилах явдлаас урьдчилан сэргийлж, дээрх менежментийг хийх нь санхүү, хүний нөөцийн ихээхэн хэмнэлтийг хийх боломжийг олгох юм.

### 4.3 Хүний эрхийн сургалтын технологи, арга зүйн талаар хийсэн судалгааны дүн

ХЭҮК-оос хийсэн “Хүний эрхийн боловсрол- ЕБС-д” сэдэвт судалгааны нэг үндсэн зорилго нь дунд сургуулийн хүний эрхийн сургалтын технологи, арга зүйн өнөөгийн дүр төрхийг тодорхойлох явдал байсан юм. Уг зорилгын хүрээнд нийт **66** багш, **276** сурагчдын ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, асуулгад хичээлийн заах аргатай холбоотой асуултыг оруулан судалсан билээ.

#### **Багштай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын асуултаас:**

- Энэ хичээлийг заахад танд ямар бэрхшээл тулгардаг вэ? /агуулгын хувьд-мэдлэг, арга зүйн хувьд/
- Хүний эрхийн тухай мэдлээлэл танд хэрэгтэй юу?
- Сурах бичгийн /багшийн номны/ арга зүйгээр хичээл явуулах боломжтой эсэх?, Та багшийн номыг яаж ашигладаг вэ?
- Танд хичээл заах бэлтгэл хир хангагдсан гэж үзэж байна вэ?, Сургалтад хамрагдсан уу?

#### **Сурагчтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын асуултаас:**

- Хичээл дээр багш тань тантай хамтарч ажилладаг уу, эсвэл даалгавар өгөөд дараа нь шалгадаг уу?
- Хичээл дээр бие, биентэйгээ ярилцаж, маргалдаж мэтгэлцдэг үү? Хэрэв мэтгэлцдэг бол яаж?
- Та хүний эрхийн хичээл дээрээ юв юв хийдэг вэ? Хамгийн таалагдсан зүйл нь юв байсан бэ?



Сурагчидтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын “**Та нар хүний эрхийн хичээл дээрээ юу юу хийдэг вэ? Хамгийн таалагдсан зүйл нь юу байсан бэ?**” гэсэн асуултад сурагчид дараах байдлаар хариулсан байна.

- Товчилж бичих, унших, асуултад хариулах, хааяа ярилцах, тохиолдол шинжлэх ажил хийдэг хэмээн хариулсан. Тохиолдол шинжлэх, ярилцах нь гоё байсан. Манай анги олон хүүхэдтэй болохоор тэр бүр яриад байх боломжгүй. Ангиуд 53,40 гаруй гэх мэт хүүхдүүдтэй.
- Хааяа л баг болдог. Зурагт үзүүлэн нэг их ашигладаггүй, сайн оролцсон хүүхэд дүн авдаг, бүлгээрээ сайн байвал оноо авдаг.
- Уншаад товчлол хийх, багшийн асуултад хариулах. Ихэвчлэн асуултад хариулж, унших ажил хийдэг.
- Багш өөрөө тайлбарлаж, яриад, даалгавар өгдөг, шалгадаг. Бидний санал бодлыг бичүүлдэг. Номноос уншаад ойлгосон зүйлээ багшид буцааж ярьдаг. Номноос бичүүлдэг. Ихэнх тохиолдолд бичүүлдэг, хааяа л багаар ажилладаг. Гол санааны тэмдэглэгээг дэвтэр дээрээ бичиж, тохиолдол дээр ажилладаг. Манай ангид эрх зүйн хичээлийг нөхөж ордог. **/АР/**
- Багш нар бид нартай байнга хамтран ажилладаг. Багштайгаа илэн далангүй харилцдаг. **/ДА/**
- Багш хичээлээ илэн далангүй, чөлөөтэй заадаг. Гэвч хүүхдүүд багшийн үгэнд орохгүй, хичээл үймүүлэх зэргээс болоод багшийн урам хугарч, шууд бичүүлдэг. Энэ нь үймүүлсэн хүүхдүүдээс болж бусад хүүхдүүд хичээлийг сонирхолтой орох боломжоо алдаж, хохирдог. **/ӨГ/**
- Хамгийн их хийдэг зүйл бол багш бичүүлдэг, асуултанд хариулдаг, ярилцдаг, зохион бичлэг хийдэг. **/ХО, БӨ/**
- Багш нь муу байсан болохоор сайн ойлгоогүй. Багш нь таалагддаггүй, хичээл сонирхолгүй, бас ойлгомжгүй учраас цаг нөгцөөх байдлаар ханддаг байсан. Уг нь сонирхолтой хичээлийг сайн зааж болох л байсан, багш нь цаг нөгцөөх хандлагатай байсан, энэ талын мэдлэг хангалтгүй.
- Хамтарч ажилладаг. Баг болно, салаагаараа асуултанд хариулна, жүжигчилсэн тоглолт хийнэ. Мэтгэлцээн хийнэ. Асуудал шийдвэрлэнэ. Хариулсан тестэн дээр бид нар бичсэн байгаа. Үзүүлдэг. Доороо юм бичсэн зурагнууд үзүүлдэг. Хүүхдүүд багштайгаа чөлөөтэй л байх хэрэгтэй шүү дээ. Бусад ангийн зааж байгаа хичээлд сууж үзээгүй.
- Даалгавар өгөөд гараад явдаг. Хааяа л багаар ажилладаг. Төдийлөн хамтраад байдаггүй. Хамтарч ажиллахад хэцүү.
- Ердийн бусад хичээл шиг л ордог. Бие даалт их өгдөг, тулж ажиллаж, сайн тайлбарлаж өгдөггүй. Бид нар өөрсдөө уншиж ойлгохыг л хичээдэг. Хичээл нь гоё заавал сонирхолтой. **/ӨГ-Х/**
- Ихэвчлэн багш юм ярьж, бид бичдэг. Өөр бусад бол багаар ажиллах, чадахгүй юмаа хийх, номоо унших, багшаас лавлаж асуух, багшийн асуултад хариулах, хүний эрх зөрчигдөж байгаа асуудлаар харилцан ярилцах. Хичээлийг сонирхолтой болгохын тулд хооронд нь уралдуулах, хүснэгтэлсэн байдлаар заах зэрэг нь зүгээр санагддаг. **/ХО-ЭБ/**
- Багш эхэлж бичүүлээд дараа нь ярилцдаг. **/БӨ-Т/**

Сургалтын технологи гэдэг нь мэдлэг олгох, чадвар, үнэт зүйлийн баримжаа олох үйлийг илүү үр дүнтэй болгох нарийн **үйл явц**, түүнд оролцогч талуудын үйл ажиллагааг үр ашигтай **удирдан зохион** байгуулах арга, аргачлал гэдгийг дээр авч үзсэн билээ. Сурагчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд хүний эрхийн хичээлийн технологийн удирдлага алдагдсан шинжтэй “Багш хичээлээ илэн далангүй, чөлөөтэй заадаг. Гэвч хүүхдүүд багшийн үгэнд орохгүй, хичээл







үймүүлэх зэргээс болоод багшийн урам хугарч, шууд бичүүлдэг. Энэ нь үймүүлсэн хүүхдүүдээс болж бусад хүүхдүүд хичээлийг сонирхолтой орох боломжоо алдаж, хохирдог. /ӨГ/”, ихэнхдээ идэвхгүй үйл ажиллагаа зонхилдог болох нь харагдаж байна /уншдаг, бичдэг, бичүүлдэг, асуултанд хариулдаг, шалгадаг гэх мэт/.

Хүний эрхийн сургалтын технологийн энэ байдал нь багш, сурагчдаас авсан социологийн асуулгын дүнгээр мөн батлагдаж байна. Хүний эрхийн хичээл дээр ямар арга ашигладаг, хичээл дээр юуг илүү хийдэг талаар багш сурагчдын санаа бодол өөр өөр байгаа нь бидний анхаарлыг татаж байна.

Хүний эрхийн хичээл дээр хийгддэг үйл ажиллагаа-багаар ажиллах




Хүний эрхийн хичээл дээр хийгддэг үйл ажиллагаа-дүрд тоглох



## Хүний эрхийн хичээл дээр хийгддэг үйл ажиллагаа-асуудал шийдвэрлэх

БАГШ


СУРАГЧ



## Хүний эрхийн хичээл дээр хийгддэг үйл ажиллагаа-жишээ тохиолдол дээр ажиллах

БАГШ


СУРАГЧ



## Хүний эрхийн хичээл дээр хийгддэг үйл ажиллагаа-гадны зочин урьж оролцуулах

БАГШ

СУРАГЧ



Хичээл дээр заримдаа "багаар ажилладаг" талаар багш, сурагчдын санал 0.9 хувийн зөрүүтэй байгаа нь энэхүү үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар хийдэг болох талаар тэдний санал нэг байна гэсэн үг юм. Харамсалтай нь бусад бараг



бүх үйл ажиллагааны талаар багш, сурагчид хэтэрхий санал зөрүүтэй байна. Тухайлбал, багш сурагчдын санал дээд тал нь 30 гаруй хувиар зөрж байгаа нь дээр хийсэн дүгнэлтийг батлаж байна.

Арга зүйд сөргөөр нөлөөлж байгаа бас нэг хүчин зүйл нь багш зааж байгаа зүйлийнхээ агуулгыг сурагчдад хүргэх хэмжээгээр мэдэхгүй, багш нарын хүний эрхийн суурь боловсрол сул байгаа явдал гэдгийг дунд сургуульд хүний эрхийн хичээл орж байгаа багш нар болон сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлага харуулж байна. Тухайлбал, ярилцлагын асуулгад сургуулийн удирдлага, багш нар дараах байдлаар хариулсан байна. Агуулгаа бүрэн таниагүй багш нар арга зүйг сонгоход бэрхшээлтэй байх нь мэдээжийн хэрэг юм.

#### **Энэ хичээлийг заадаг багш нарт ямар бэрхшээл тулгардаг вэ? /удирдлага/**

- Багш бэлтгэгдээгүй, багш нарын өөрсдийнх нь хүний эрхийн суурь мэдлэг дутагдалтай тааруу, доогуур. Багш нарт мэдэхгүй зүйл их гарна. Тухайлбал, эрт төгссөн түүхийн багш нар энэ талаар юу ч заалгаагүй гарсан шүү дээ.

#### **Энэ хичээлийг заахад танд ямар бэрхшээл тулгардаг вэ? /багш/**

- Хүний эрхийн онолын мэдлэг хангалттай биш, сурах бичиг /сурагчийн ном/ онолын материал бага орсон. Зарим тохиолдол дээр ажиллахад онолын мэдлэг дутдаг.
- Сургалтын хэрэглэгдэхүүний сурах бичгээс өөр зүйл байхгүй, багшийн номыг үзээгүй
- Багш нарт хэрэгтэй байгаа зүйл: хүний эрхийн талаар системтэй мэдээлэл, сүүлийн үеийн гарын авлага, арга зүйн зөвөлгөө

Дунд сургуулийн хүний эрхийн хичээл зааж байгаа багш нарыг хөгжүүлэх, тэдэнд удирдлага, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх явдал туйлын хангалтгүй байна.

Идэвхтэй стратегиар зохион байгуулж байгаа хичээлд менежмент хийх ур чадвар багш нарт дутагдалтай байна. Тухайлбал жижиг багийн ажлыг зохион байгуулахдаа багийн гишүүдийг жигд оролцуулах, баг хоорондын болон багаас багштай харилцах харилцааг зохион байгуулах ур чадвар дутагдалтай.

Багшийн заах арга зүйд нөлөөлж байгаа нэг томоохон хүчин зүйл бол багшид хүний эрхийн системтэй боловсрол дутагдаж байгаа явдал юм. Ийм тохиолдолд сурагчдын үйл ажиллагааг эцсийн үр дүнд чиглүүлэх, тэдний дунд идэвхтэй оролцоог бий болгох үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг хааж байгаа юм.

Судалгааны хүрээнд нийтдээ 29 багшийн хичээлд сууж анализ хийсэн бөгөөд хангалттай сайн 5 буюу 17,2 хувь, дунд зэрэг 17 буюу 58,6, хангалтгүй 7 буюу 24,1 хувийн үзүүлэлттэй хичээлүүд заагджээ. Суралцагчид багшид болон бие биедээ асуулт тавьсан эсэх үзүүлэлт дээр 23 хичээл хасах үнэлгээ авсан байна.

#### **4.4 Сэдвийн дүгнэлт**

Судалгаанаас харахад дунд сургуулийн хүний эрхийн хичээлийн сургалтын технологи нь тухайн сургалтын зорилго, агуулга, арга зүйн нийцэхүйц хэмжээнд хүрч чадаагүй, уламжлалт болон идэвхгүй арга зонхилсон шинжтэй байгаа нь харагдаж байна. Багш нар жижиг багаар ажиллах зэрэг идэвхтэй аргыг хэрэглэдэг





боловч тэрхүү аргын агуулга, мөн чанарыг чухалчилахаас илүү хэдэн хүүхдийг ширээ тойруулан суулгах, хэн дургайг нь яриулах зэрэг хэлбэрийн талыг хэт барьдаг нь тухайн аргаар заасан хичээлийн үр дүнд нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. /Тестийн дүн/ Агуулгагүй хэлбэрдэл дунд боловсролд газар авах аюул “нүүрлэх” эх үндэс тавигдах вий.

Хүний эрхийн сургалтын технологийг хөгжилд дараах хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнд:

- Багш нарын агуулгын мэдлэг хомс байдал
- Багш нарын сургалтын идэвхтэй арга зүйг эзэмшсэн байдал, тэдний хичээлийн менежментийг хийх ур чадвар
- Шат, шатны удирдлага, мэргэжил, арга зүйн туслалцаа хангалтгүй байдал
- Багшийн гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хомсдол
- Нэг ангид суралцах сурагчийн тоо

## Тав. ХҮНИЙ ЭРХ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

### 5.1 ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн хичээлийн сурах бичиг

1998 оны Гэгээрлийн сайдын 100-р тушаалаар ЕБС-ийн 6-р ангид эрх зүй хичээлийг 3 улирал 27 цагаар орохоор зааж, мөн оноос Д.Дашцэдэн, О.Пүрэв нарын зохиогчтой “Эрх зүй” номыг сургалтанд хэрэглэх болжээ. 2003 оноос ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн хичээлийн сургалтад “Хэрэглээний эрх зүй” төслийн хүрээнд боловсруулагдсан “Хүний эрх бүх нийтэд” номыг хэрэглэж эхлэсэн бөгөөд өнөөг хүртэл сургалт тус номын дагуу явагдаж байна.

“Хүний эрх бүх нийтэд” сурах бичиг нь багшийн болон сурагчийн номтойгоор боловсруулагджээ. “Хүний эрх бүх нийтэд” сурагчийн ном нь 6-р ангийн эрх зүйн хичээлийн хүрээнд сурагчдын мэдвэл зохих сэдвүүдийн бичвэр, дасгал даалгаврыг багтааж, холбогдох зарим эх сурвалжийг хавсаргасан бол багшийн ном нь тус хичээлийг заах багшид номонд орсон сэдвүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хичээлийг явуулах арга зүйн чиглэмж болох зорилгоор бүтээгдсэн байна.

Сурах бичиг нь “Хүний эрхийн тухай ойлголт”, “Ардчилал дахь улс төрийн эрх”, “Аюулгүй байдал ба хувийн эрх чөлөө”, “Нийгэм, эдийн засаг болон соёлын эрх”, “Хүний эрх зөрчигдсөн нөхцөлд яах вэ” гэсэн 5 бүлэгтэй бөгөөд бүлэг тус бүрдээ 4-7 дэд сэдвийг багтаасан буюу нийт 24 дэд сэдэвтэйгээр боловсруулагджээ.

#### 5.1.1 Сурах бичгийн хүртээмж, түгээлт


“Хүний эрхийн боловсрол-ЕБС-д” судалгааны хүрээнд ЕБС-иудын 6-р ангийн эрх зүйн хичээлийг заах сурах бичгийн хүртээмжийн талаар судаллаа.

#### Сурагчийн ном:

Сурагчидтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаас харахад сурагчийн номын хүртээмж сургуулиудад харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн 6-р ангийн сурагчидтай хийсэн ярилцлагад ихэвчлэн “*ном хүртээмжтэй байдаг*” гэсэн байхад сумдын сургуулийн сурагчид “*ном хангалтгүй байдаг*” гэжээ. /Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Баян-Өлгий аймгийн Толбо сум, Архангай аймгийн Ихтамир сум/

Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн **184** багшаас авсан тоон судалгааны дүнгээс харахад “Танай сургуульд 6-р ангийн эрх зүйн сурагчийн сурах бичиг хүрэлцээтэй байдаг уу?” гэсэн асуултанд **58%** нь **хүрэлцээтэй**, **8.8%** нь **хүрэлцээтэй боловч хэрэглэх нь ховор**, **11.6%** нь **хүрэлцээ тааруу боловч олж хэрэглэдэг**, **21.6%** нь **хүрэлцээгүй** гэж хариулсан байна.

Танай сургуульд 6-р ангийн эрх зүйн сурагчийн сурах бичиг хүрэлцээтэй байдаг уу?




Судалгааны хүрээнд Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн 200 ЕБС-ийн сургуулиуд<sup>9</sup>-ын номын санд бүртгэлтэй “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн багш, сурагчийн номын тоог авсан юм.

Сурах бичгийн хүртээмж:

	Өмчийн харъяалал	6-р ангийн сурагчийн тоо	Сурагчийн ном	Багшийн ном	С/номын хүртээмж
Улаанбаатар хотод:					
	Төрийн	13301	11745	193	88.3%
	Хувийн	1104	646	17	58.5%
Хөдөө орон нутагт:					
	Төрийн	13353	11267	82	84.3%
	Хувийн	90	42	3	46.6%

Хуудсанд тэмдэглэгдсэнээр ажиглалтад хамрагдсан сургуулиудад 2004-2005 оны хичээлийн жилд нийт **27848** 6-р ангийн сурагч, **23700** ширхэг сурагчийн ном байлаа. Эдгээр сургуулиуд дахь сурагчийн номын хүртээмжийг номын тоог нийт сурагчдын тоонд харьцуулан гаргавал **85.1%** байна.

<sup>9</sup> Ажиглалтад Улаанбаатар хотын 6 дүүргийн төрийн өмчийн 85, хувийн өмчийн 31 нийт 116 ЕБС, 21 аймгийн төвийн төрийн өмчийн 75 ЕБС, хувийн өмчийн 3 ЕБС, Архангай аймгийн Ихтамир сум, Баян-Өлгий аймгийн Толбо сум, Дархан-Уул аймгийн Хөтөл сум, Өмнөговь аймгийн Хүрмэн сум, Сүхбаатар аймгийн Онгон сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумдын 6 ЕБС нийт 84 ЕБС хамрагдлаа.



Номын хүртээмж хот, хөдөөгийн төрийн болон хувийн өмчийн сургуулиудад ялгаатай байна.

Улаанбаатар хотын ЕБС-иудад:

Ажиглалтад хамрагдсан Улаанбаатар хотын төрийн өмчийн ЕБС-иудад нийт **13301** 6-р ангийн сурагч суралцаж байна. Сургуулиудын номын сангийн бүртгэлд тэмдэглэгдсэнээр тэдгээр сургуулиудад нийт **11745** сурагчийн ном байна. Сурагчийн номын хүртээмж Улаанбаатар хотын төрийн өмчийн ЕБС-иудын хувьд **88.3%**-тай байлаа.

Хувийн өмчийн сургуулиудад нийт **1104** 6-р ангийн сурагч байгаа бөгөөд **646** ширхэг сурагчийн ном байгаа тухай тэмдэглэгдсэн байна. Хувийн өмчийн сургуулиудад сурагчийн номын хүртээмж **58.5%**-тай байна.

Сурах бичгийн хүртээмж Улаанбаатар хотын ЕБС-иудад:

Дүүрэг	Өмчийн харъяалал	Сурагчийн тоо	Сурагчийн ном	Багшийн ном	С/номын хүртээмж
1. Баянгол	Төрийн	4091	3313	64	80.9%
	Хувийн	360	360	6	100%
2. Баянзүрх	Төрийн	2828	2710	10	95.8%
	Хувийн	504	70	1	13.8%
3. Хан-Уул	Төрийн	1025	937	6	91.4%
	Хувийн	0	0	0	-
4. Сонгинохайрхан	Төрийн	3008	2349	8	78.09%
	Хувийн	88	65	1	73.8%
5. Сүхбаатар	Төрийн	1769	1788	14 <sup>10</sup>	101.07%
	Хувийн	136	131	9	96.3%
6. Налайх	Төрийн	580	648	1	111.7%
	Хувийн	16	20	1	125%

Хөдөө орон нутгийн ЕБС-иудад:

Ажиглалтад хамрагдсан хөдөө орон нутгийн төрийн өмчийн ЕБС-иудад нийт **13353** 6-р ангийн сурагч суралцаж байна. Сургуулиудын номын сангийн бүртгэлд тэмдэглэгдсэнээр тэдгээр сургуулиудад нийт **11267** сурагчийн ном байна. Сурагчийн номын хүртээмж **84.3%**-тай байлаа.

<sup>10</sup> Сүхбаатар зэрэг зарим дүүргийн ажиглах хуудсанд багшийн номын тоог "багш бүрт нэг" гэж тэмдэглэсэн байлаа. Сургууль хичээн багштайг тогтоох боломжгүй байсан тул уг тэмдэглэлийг тооцоонд оруулаагүй болно.



Ажиглалтад хөдөө орон нутгийн хувийн өмчийн 3 ЕБС хамрагдлаа<sup>11</sup>. Эдгээр сургуулиудад нийт **90** 6-р ангийн сурагч суралцаж байсан бөгөөд **42** ширхэг сурагчийн ном тоологдсон байна. Сурагчийн номын хүртээмж **46.6%**-тай байна.

Сурах бичгийн хүртээмж хөдөө, орон нутгийн ЕБС-уудад:


	Аймаг	Өмчийн харъяалал	Сурагчийн тоо	Сурагчийн ном	Багшийн ном	С/номын хүртээмж
1.	Архангай	Төрийн	732	566	8	77.3%
2.	Баянхонгор	Төрийн	899	911	1	101.3%
		Хувийн	20	32	2	160%
3.	Баян-Өлгий	Төрийн	971	1004	3	103.3%
4.	Булган	Төрийн	362	322	2	88.9%
5.	Говь-Алтай	Төрийн	452	360	8	79.6%
6.	Говьсүмбэр	Төрийн	248	224	0	90.3%
7.	Дархан-Уул	Төрийн	619	637	4	102.9%
8.	Дорнод	Төрийн	734	846	3	115.2%
9.	Дундговь	Төрийн	420	339	4	80.7%
10.	Дорноговь	Төрийн	322	182	10	56.5%
11.	Завхан	Төрийн	508	384	2	75.5%
		Хувийн	10	10	0	100%
12.	Орхон	Төрийн	952	617	5	64.8%
13.	Өмнөговь	Төрийн	559	470	4	84%
14.	Өвөрхангай	Төрийн	778	655	1	84.1%
15.	Сэлэнгэ	Төрийн	641	633	5	98.7%
16.	Сүхбаатар	Төрийн	537	471	0	87.7%
17.	Төв	Төрийн	349	407	3	116.6%
18.	Хөвсгөл	Төрийн	1023	700	4	68.4%
19.	Хэнтий	Төрийн	457	423	10	92.5%
20.	Ховд	Төрийн	883	906	1	102.6%
		Хувийн	60	0	1	0%
21.	Увс	Төрийн	907	985	6	108.5%

Дээрх үзүүлэлтүүдийг графикаар харуулбал:


Төрийн өмчийн ЕБС-ийн 6-р ангийн сурагч, номын тоог харьцуулсан нь



<sup>11</sup> Баянхонгор аймгийн Тольт, Завхан аймгийн Тэгш хэм, Ховд аймгийн Прогресс сургууль



Графикуудаас харахад сургуулиудын номын санд байгаа сурагчийн номын тоо Улаанбаатар хотын сургуулиудын хувьд харьцангуй дээгүүр байна. Түүнчлэн, төрийн өмчийн ЕБС дэх сурагчийн номын тоо хот, хөдөөгийн алинд ч илүү байгаа нь харагдаж байна.



"Хүний эрх бүх нийтэд" сурагчийн номын хүртээмжийн зэрэгцээгээр түгээлтийн байдал анхаарал татаж байлаа. Тухайлбал, зарим сургууль хүүхдийн тооноосоо хэт олон номтой байхад зарим сургууль огт номгүй байна. Жишээ нь 247 6-р ангийн сурагчтай Ховд аймгийн төвийн Цаст-Алтай сургуульд 124 ширхэг сурагчийн ном байхад 216 сурагчтай мөн аймгийн төвийн 1-р сургуульд 301 ширхэг сурагчийн номтой байна. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15-р сургууль 6-р ангийн 171 сурагчтай бөгөөд нэг ч сурах бичиггүй байна. Гэтэл мөн дүүргийн 150 6-р ангийн сурагчтай 34-р сургуульд 219 ширхэг сурагчийн ном байгаа тухай тоо авагдсан байна.

Урьд өмнөх жилийн 6-р ангийн тооноос хамаарч сурах бичгийн тоо одоо 6-р ангид сурч байгаа сурагчдын тооноос илүү гарах, дутуудах зэрэг зөрүү гарч болох ч сургалтыг чанартай, өгөөжтэй явуулах үүднээс үр ашигтай хувиарладаг тогтолцоо бий болгох талаар анхаарах нь зүйтэй байна.

Түүнчлэн, чанарын судалгааны үеэр Баян-Өлгий аймгийн Толбо, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Архангай аймгийн Ихтамир сумдын сурагчид номын тоо хангалтгүй талаар ярьж байсан боловч ажиглалтаар номын санд байгаа номын тоо нь тэдгээр сургуулиудад номын хүртээмж хангалтай байж болохуйц байгаа нь харагдсан юм.

**Сурагчидтай хийсэн бүлгийн ярилцлагаас:**

...Сургуулиас ном тарааж өгөөгүй, харин зарим хүүхдүүд номын сангаас авсан байсан.  
*/Архангай аймгийн Ихтамир сум/*

...Ном хүрэлцээтэй биш...  
*/Баян-Өлгий аймгийн Толбо сум/*

...Ном байхгүй ...  
*/Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум/*

**Тэмдэглэл:**

Ажиглалтын хуудсанаас харахад 104 6-р ангийн сурагчтай Архангай аймгийн Ихтамир сумын сургуульд 103 ширхэг, 62 6-р ангийн сурагчтай Толбо сумын сургуульд 85 ширхэг, 62 6-р ангийн сурагчтай Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд 68 ширхэг сурагчийн ном номын сангийн бүртгэлд тэмдэглэгдсэн байна.

Сургуулиудын номын санд ном байгаа боловч сурагчдийн гар дээр очихгүй байгаагийн шалтгаан нь сурагчид сурах бичгийг хэрэглэх мөнгөө төлөөгүй учраас нэг ч ангид ном хувиарлахгүй байх, эсвэл сурагчид номоо гамгүй эдэлдэг гэх шалтгаанаар цөөн тооны номыг тараадагтай холбоотой байна.

Миний өмнөх багш номгүй заасан учраас хүүхдүүд номгүй байсан. Ангийн багш нар нь тараах ёстой боловч, хичээлийн жилийн эхнээс ордоггүй зарим хичээлийн сурах бичгийн тараалт хангалтгүй байдаг. Хичээл зааж байгаа багшаас ч бас болж байгаа.

*/Ховд аймгийн Цаст-Алтай сургуулийн багш Х-тэй хийсэн ярилцлагаас.../*

Зарим сургуульд үнэхээр ном нь хүрэлцдэггүй, зарим нь номын санд ном байгаа боловч өөрийн биш номонд сурагчид гамгүй ханддаг учраас цөөн тооны ном тарааж, бусдыг нь тараадаггүй сургууль ч байв.

*/Архангай аймгийн Их тамир сум судлаачийн тэмдэглэлээс.../*

**Багшийн ном:**

ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн хичээлийн багшийн номын хүртээмж хангалтгүй байна.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 174 багшаар авсан тоон судалгааны дүнгээс харахад “Танай сургуульд 6-р ангийн эрх зүйн багшийн гарын авлага байдаг уу?” гэсэн асуултад 37.4% нь байдаг, 62.1% нь байдаггүй гэж хариулжээ.

Танай сургуульд 6-р ангийн эрх зүйн багшийн гарын авлага байдаг уу?







Судалгааны хүрээнд багш нартай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үеэр "багшийн ном байдаггүй, байдаг тухай мэдэх боловч барааг нь ч хараагүй, байдаг гэдгийг ч мэдэхгүй" гэх нь олонтаа тохиолдож байсан юм. Улаанбаатар хотын 6 дүүргийн хувийн болох төрийн өмчийн сургуулийн багш нарын бүлгийн ярилцлагад оролцсон 11 багшийн нэг ч багшийн номгүй, 1 багш хувилж аваад хэрэглэж байгаа, 1 сургуульд номын санд бүртгэлтэй байдаг боловч багш нарын гар дээр ирдэггүй гэж байлаа.

Ажиглалтад хамрагдсан 200 ЕБС-д нийт 295 ширхэг багшийн ном байгаа тухай тоо авагдсан байна. Багшийн номын хүртээмж харилцан адилгүй байгаа бөгөөд ажиглалтад хамрагдсан 200 сургуулийн 80 нь (Орон нутгийн 84 сургуулиас 36 нь буюу **42.8%**, Улаанбаатар хотын 116 сургуулиас 44 нь буюу **37.9%**) багшийн номгүй байна.

Гэтэл Улаанбаатар хотын 51-р сургууль 14 ширхэг, 13-р сургууль 10 ширхэг, 77-р сургууль 9 ширхэг, Хобби сургууль 8 ширхэг, 96-р сургууль 7 ширхэг багшийн номтой тухай тэмдэглэгджээ. Дорноговь аймгийн 1-р сургуульд 6 ширхэг, 2-р сургууль 4 ширхэг багшийн номтой гэсэн байхад Баян-Өлгий, Сүхбаатар, Говьсүмбэр зэрэг аймгийн нэг ч сургуульд багшийн ном ирээгүй байна.

Багшийн номтой гэж тэмдэглэгдсэн сургуулиудын багш нартай хийсэн ярилцлагын үеэр сургуульд нь багшийн ном байгааг тухайн хичээлийг заадаг багш огт мэдэхгүй байсан тохиолдол нэлээд байлаа. Энэ нь ганц нэг тоотой ирсэн багшийн номыг өмнөх жилд эрх зүйн хичээл заасан багш ашиглаж байгаад номын санд буцааж өгдөггүй, мөн хэд хэдэн багшийн дунд нэг ном ашиглагдаж байгаад үрэгдэж алга болсонтой холбоотой байлаа.

## 5.2 ЕБС-иудын номын сан дахь хүний эрхийн холбогдолтой ном, гарын авлагын байдал

Судалгааны хүрээнд ЕБС-иудын номын санд байгаа сурах бичгээс бусад хүний эрх, эрх зүйн холбогдолтой ном, товхимолын хүртээмж, хангалтын байдалд ажиглалт хийлээ. Ажиглалтад хамрагдсан нийт сургуулиудын 67.5% нь сурах бичгээс бусад хүний эрх, эрх зүйн ном гарын авлагаар хангагдаагүй байна.

Ажиглалтад Улаанбаатар хотын төрийн ба хувийн өмчийн 166 сургууль хамрагдсанаас 83 сургуульд буюу 60.3%-д нь, хөдөө, орон нутгийн 84 сургууль хамрагдсанаас 52 сургуульд буюу 61%-д нь хүний эрхийн холбогдолтой нэмэгдэл ном, материал байхгүй байлаа.

Ном, гарын авлагаар хангагдсан байдлыг сургуулиудын өмчийн харъяалалаар нь ялган үзүүлбэл:

ҮЗҮҮЛЭЛТ	Улаанбаатар хот		Хөдөө, орон нутаг	
	Төрийн	Хувийн	Төрийн	Хувийн
Ажиглалтад хамрагдсан сургуулиуд	85	31	81	3
Ном, гарын авлагаар хангагдаагүй сургуулиуд	47	23	50	2
Хүртээмжгүй байдал	55.2%	74.1%	61.7%	66.6%



Номын гарын авлагын хүртээмжгүй байдлыг графикаар үзүүлбэл:



Ажиглалтаас харахад ЕБС-иудад хамгийн элбэг олдоцтой гарын авлага нь МУ-ын Үндсэн хууль, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал байна. Түүнчлэн “Хүний эрх” сэтгүүл, Хүүхдийн эрхтэй холбоотой хуулийн эмхтгэл, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Хөдөлмөрлөх эрхийн гарын авлага, Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл, Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг илтгэл, Эмэгтэйчүүдийн эрх алхам алхмаар, Эрх зүй ёс суртахуун зэрэг номууд цөөн хувиар байна. Сурах бичгээс бусад хүний эрхийн холбогдолтой гарын авлагын хүртээмж туйлын хангалтгүй байгаа бөгөөд дээр дурдсан номнууд сургуулиудад ихэвчлэн 1 ширхэг, ховор тохиолдолд 4-5 байх ажээ.

Түүнчлэн, ихэнх ЕБС-иудын номын сан дахь нийгмийн ухааны холбогдолтой номууд нэлээд хуучирсан байна. Тухайлбал, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын сургуулийн номын санд сурах бичгээс гадна Марксизм, Ленинизмтэй холбоотой номнууд л байна.

Баян-Өлгий аймгийн 4-р сургууль зэрэг сургуулиуд МУ-ын Үндсэн хуулийн 2-р бүлгийн казак хэлнээ орчуулж сургуулийн номын санд цөөн хувиар тавьсан байна.

Сүүлийн жилүүдэд төсөв хөрөнгө байхгүй гэх шалтгаанаар ЕБС-иудын номын сангуудын номын фондыг шинэчлэх ажил бараг хийгдээгүй нь багш, сурагчдад сурах бичгийн хүрээнээс илүү мэдээлэл хүлээн авах боломжийг хязгаарлаж, сургалт зөвхөн сурах бичгийн хүрээнд л явагдахад хүргэж байна.

Багшийн санал асуулгын ЕБС-иудын хүний эрхийн сургалтанд тулгамдаж байгаа гол асуудлыг бичнэ үү гэсэн асуултанд нийт багш нарын дийлэнх нь ном, гарын авлага дутмаг байдаг гэж хариулсан байна. Энэ нь бусад бэрхшээлүүдээс нэлээд өндөр хувьтай байна.

### 5.3 Эрх зүйн кабинет

“ЕБС-ийн хичээлийн кабинетын ерөнхий заавар” Монгол улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдын 1996 оны 7-р сарын 26-ны өдрийн 253-р тушаалаар батлагджээ. Тус зааврын 3.1-р зүйлд “ЕБС нь бага анги, монгол хэл, уран зохиол, математик, физик, одон орон, хими, биологи, газар зүй, түүх нийгмийн тухай мэдлэг, гадаад хэл, дуу хөгжим, хөдөлмөрийн хичээлийн кабинеттай байна.” гэж заасан бөгөөд тухайн сургууль хэдэн кабинеттай байхыг сургуулийн сурган-хүмүүжлийн зөвлөлөөр хэлэлцэн тогтож, сургуулийн бүтэц, хэв шинж, хүүхдийн




тоо, анги бүлэг, барилгын хүчин чадлаас хамааруулан сургуулийн захиралын тушаалаар байгуулах ажээ. ЕБС-ийн хичээлийн кабинетэд шинжлэх ухааны, физиологи-эрүүл ахуйн, хөдөлмөр хамгаалал-аюулгүй ажиллагааны, гоо зүйн болон эдийн засгийн шаардлагууд тавигддаг байна.

Түүнчлэн кабинетын эрхлэгчийг заах аргын нэгдлийн хамт олны саналыг үндэслэн захиралын тушаалаар томилох бөгөөд кабинетаа баталгаажуулан орчин үеийн сургалтын шаардлагын хэмжээнд ажиллуулж, сургалтын үр дүнг дээшлүүлж байгаа багшид зохих нэмэгдэл хөлсийг олгож байхаар тус зааварт заасан байна.

Энэхүү судалгааны хүрээнд ЕБС-ийн 200 сургуулийн эрх зүйн анги, кабинетын байдалд ажиглалт хийсэн юм. Эрх зүйн кабинет байгуулсан байдал Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн төрийн болон хувийн өмчийн сургуулиудад ялгаагүй, маш хангалтгүй байна.

Ажиглалтад хамрагдсан 200 сургуулийн 45 нь (УБ хотын 17 сургууль, хөдөө, орон нутгийн 28 сургууль байлаа.) эрх зүйн кабинеттай, 58-д нь огт эрх зүйн кабинет байхгүй байсан бөгөөд үлдсэн сургуулиудад эрх зүйн кабинет байдаг болон байдаггүй тухай хуудсанд тэмдэглэгдээгүй байна.



Эрх зүйн кабинет байгуулсан байдал хувийн сургуулиуд дээр хангалтгүй байгаа байдал анхаарал татаж байлаа. Тухайлбал, хөдөө орон нутгийн хувийн аль ч сургууль эрх зүйн кабинетгүй байсан бөгөөд Улаанбаатар хотод ердөө 2 хувийн өмчийн ЕБС эрх зүйн кабинет байгуулжээ.

Улаанбаатар хотын 17 сургуулийн 15 нь, хөдөө орон нутгийн 27 сургуулийн 5 нь биеэ даасан эрх зүйн кабинеттай байна. Хот, хөдөөгийн 24 сургуулийн хувьд эрх зүйн бие даасан кабинетгүй боловч түүх, нийгмийн ухааны кабинеттай хавсарга байдлаар байдаг гэсэн байна. Тухайлбал, Завхан аймгийн 1-р сургуульд эрх зүйн кабинет байхгүй ч сургуулийн эцэг эхийн зөвлөл, төгсөгчдөөс хамтран байгуулсан "Хүний эрхийн сургалт сурталчилгааны төв" ажиллаж байгаа тухай тэмдэглэгдсэн байна. Ховд аймгийн 1-р сургуульд эрх зүйн кабинет байхгүй ч анги бүрт хуулийн булан байдаг гэжээ.

Ажиглалтад хамрагдсан эрх зүйн кабинетуудын тохижилт ерөнхийдөө хангалтгүй байна. Харин Булган аймгийн 2-р 10 жилийн сургуулийн эрх зүйн кабинетыг сурагчдын хичээллэх таатай орчинг бүрэн хангасан, хүссэн мэдээллээ авч чадахуйц байна гэж судлаач дүгнэжээ.





Эрх зүйн кабинетуудад Монгол улсын хууль тогтоомжоор төрөлжсөн самбарууд болон хэвлэмэл плакатуудыг байрлуулсан нь нийтлэг ажиглагдаж байлаа. Гэсэн хэдий ханын самбарын 90 орчим хувь нь хүний эрхийн асуудал төдийлөн шууд холбогдолгүй, засаглал хувиарлах онол болон салбар эрх зүйн чиглэлээр хийгдсэн байлаа. Самбарыг тогтмол ажиллуулах, шинэчлэх ажил бараг хийгддэггүй нь ажиглагдаж байсан бөгөөд самбарыг тодорхой хугацаанд шинэчилдэг гэж 2 сургуульд л тэмдэглэгдсэн байна.

Эрх зүйн кабинетууд хэрэглэгдэхүүн, тараах материалын хувьд хангалтгүй байлаа. Ялангуяа, багшийн хичээл заах арга зүйтэй холбогдолтой хэрэглэгдэхүүн бараг байхгүй байна. Харин “Хууль бидний амьдралд” төслийн туршилт хичээлд хамрагдсан зарим нэг багшийн байгуулсан кабинетэд хичээл заахад ашиглаж болохуйц арга зүйн материал байсан. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, МУ-ын Үндсэн хуулийн 2-р бүлгийг хувилж, хичээл дээр тарааж хэрэглүүлдэг 4 сургууль байна. Мөн Соросын сангийн мэтгэлцээн хөтөлбөрийн хүрээнд тараагдсан эсвэл нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролтой холбоотой материалууд байгаа нь хүний эрх хичээлийг заах хэрэглэгдэхүүн болж чадахгүй байна.

Ажиглалтад хамрагдсан 45 кабинетын 63%-д нь сурагчдын бүтээл огт байхгүй байсан бөгөөд үлдсэн сургуулиудад хүүхдүүдийн хийсэн ханын сонин, реферат, бяцхан номнууд цөөн тоотой байлаа. Гэсэн хэдий ч нийслэлийн 13-р сургууль зэрэг сургуулиудад өнгөрсөн жилүүдэд хийсэн олон тооны сурагчдын бүтээл байсан авч энэ хичээлийн жилд хийсэн сурагчдын бүтээл гэхээр зүйл бараг байхгүй байлаа.

Судалгааны хүрээнд хийгдсэн удирдлагын болон багш нарын бүлгийн, ганцаарчилсан ярилцлагын үеэр ЕБС-ийн эрх зүйн хичээлийг заах орчин нөхцөл, сургалтын анги, кабинетын талаарх санаа бодлыг нь сонссон юм. Ярилцлагаас сургуулийн удирдлага болон багш нарын дийлэнх нь хүний эрхийн сургалт явуулах материаллаг орчинг хангалтгүй гэж үзсэн байна. Түүнчлэн ЕБС-иудын сурагчдын тооны хэт ачаалал нь сургалтын үйл ажиллагааг зохих ёсоор явуулахад хүндрэл учруулж байна. Тухайлбал, төрийн өмчийн ЕБС-иудын 6-р ангийн анги дүүргэлт дунджаар 40-45 байгаа бөгөөд кабинет сэлгэн ороход хэтэрхий олон тооны сурагчтэй учраас боломжгүй байдаг тухай багш нар ярьж байлаа.

Кабинет байдаг боловч ганц нэг самбар, үзүүлэн, гэрчилгээ л байдаг. Тэрийг тэр бүр ашиглах боломжгүй. Кабинетэд жижиг номын сан байдаг боловч түлхүүр нь зөвхөн кабинетын эрхлэгч багшид л байна. Номнуудыг ашиглах боломжгүй...

Кабинетийн гэрчилгээ нь ганц л хүний өмч байдаг...

Хувийн сургуулиудад кабинет байдаг, кабинетийн системээр хичээл орох харьцангуй боломжтой. Харин улсын сургуульд бол хүүхдүүд анги, ангидаа л хичээлээ үзэхээс өөр аргагүй...

*/УБ хотын багш нарын бүлгийн ярилцлагаас.../*

Багш нарын ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан сургуулиудын 2 нь л энэ чиглэлийн танхим байгуулах эхлэл тавигдсан гэж үзжээ. Багш нарын хувийн ивэвх санаачлага, бэл бэнчингээс шалтгаалж сургалтын орчин бүрдэх болдог байна.

*/Судлаачийн тэмдэглэлээс.../*



#### 5.4 Хэрэглэгдэхүүн ба менежмент

Судалгааны хүрээнд ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн хичээлийн хэрэглэгдэхүүнтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтын дараах асуудлууд анхаарал татаж байна. Үүнд:

- Судалгаанаас “Хүний эрх ба бүх нийтэд” сурах бичгийн багшийн номын хүртээмж муу байгаа нь харагдаж байна. Ихэвчлэн эрх зүйч бус мэргэжилтэй багш нар зааж байгаа энэ хичээлийг явуулахад багшийн ном мэдлэг, арга зүйн гол удирдамж болж байх учиртай юм. Иймээс асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нэн хэрэгцээтэй номын хүртээмжийг хангалтай байлгах тал дээр анхаарч, нарийн тодорхой статистик тооцооны үндсэн дээр номын хэвлэх тоо, ширхэгийг тогтоож байх шаардлагатай байна.
- Судалгаанаас харахад ЕБС-иудад 6-р ангийн эрх зүйн сурах бичгийн сурагчийн номны илүүдэл хомсдол аль аль нь байна. Сурагчид номны мөнгийг төлөөгүй, хувийн биш номоо гамгүй эдлэдэг зэрэг шалтгаанаар, эвсэл анги удирдсан багшийн хайхрамж, хариуцлагагүй байдлаас болж сурагчдын гар дээр ном очиж чадахгүйд хүрч байна. Иймээс сурах бичгийг оновчтой хувиарлах тал дээр ангийн багш, сургуулийн удирдлага болон аймаг, нийслэлийн боловсролын байгууллага төдийгүй төрийн захиргааны төв байгууллага анхаарч, сурах бичгийг хувиарлах болон хүртээмжийг хянах оновчтой механизм бий болгох тал дээр анхаарах шаардлагатай байна. “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн багшийн ном ЕБС-иудад угаас цөөн тоотой, хүртээмж муутай байдгийн дээр ганц нэг ширхэг байдаг ном сургуулийн номын санчийн тооцоо, хяналт сул, багш нарын хариуцлага муугаас бусад багш нар хэрэглэх боломжгүй болоход хүрч байна. Өөрөөр хэлбэл, энэхүү судалгааны ажиглалтын хуудсанд “багшийн номтой” гэж тэмдэглэгдсэн сургуулиудын багш нартай хийсэн ярилцлагын үеэр сургуульд нь багшийн ном байгааг тухайн хичээлийг заадаг багш огт мэдэхгүй байсан тохиолдол нэлээд байлаа. Энэ нь багшийн номыг өмнөх жилд эрх зүйн хичээл заасан багш ашиглаж байгаад номын санд буцааж өгдөггүй, мөн хэд хэдэн багшийн дунд нэг ном ашиглагдаж байгаад үрэгдэж алга болсонтой холбоотой байлаа. Иймээс ЕБС-үүдийн удирдлагын зүгээс номын ашиглалтанд тавих үр дүнтэй хяналтын тогтолцоо бий болгох шаардлагатай байна.
- Үндэсний цөөнх оршин суудаг орон нутгийн онцлогтой холбоотой Баян-Өлгий аймгийн сурагчдад эрх зүйн хичээлийн сурах бичгийг хэрэглэх тал дээр хэлний бэрхшээл тохиолддог нь судалгааны явцад харагдсан юм. Тус аймгийн ихэнх сургуулиуд казак хэл дээр сургалтаа явуулдаг байхад сурах бичиг нь монгол хэл дээр байдаг байна. Ялангуяа 6-7-р ангийн сурагчдийн монгол хэлний мэдлэг хангалтгүй учир багш нь сурах бичгээ орчуулж 2 дахин ачаалалтай ажиллах болдог байна. Иймээс олон улсын гэрээ, конвенц, МУ-ын хууль тогтоомжид заасан үндэсний цөөнхийн эрх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангах тал дээр асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зүгээс тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.
- ЕБС-иудын номын сангуудын номын фондууд нэлээд хуучирсан, сүүлийн жилүүдэд сурах бичгээс бусад төрлийн шинэ номоор баяжигдаагүй нь судалгааны явцад ажиглагдсан юм. Ялангуяа эрх зүйн болон нийгмийн шинжлэх ухааны онол, үзэл номлол цаг үеэ даган амархан хувьсаж өөрчлөгддөг учраас сурах бичгийг мөн төдий хугацаанд өөрчлөх

шаардлагатай байдаг. Түүнчлэн сурагч нэлээд олон тооны эх сурвалжийг харьцуулан үзсэний эцэст тухайн асуудлын талаар тодорхой ойлголт, оновчтой мэдлэгийг эзэмших боломжтой болдог учраас ном, сурах бичиг, гарын авлагын хэрэгцээ эрх зүй, нийгмийн ухааны хичээлийг судлахад нэлээд өндөр байдаг. Гэтэл төсөв, хөрөнгө байхгүй гэх шалтгаанаар ЕБС-иудын номын фондын баяжилт хийгдэхгүй байгаа нь сурагчдын эрх хангагдахгүй байхад хүргэж байна. Иймээс төрийн эрх бүхий байгууллагын зүгээс энэ асуудлыг анхааралдаа авч төсөв хөрөнгийг аль болох зөв зохистой хувиарлах, ялангуяа номын фондыг арвижуулахад зориулан тодорхой хэмжээний төсвийг ЕБС-иудад хувиарлаж байх шаардлагатай байна.

- ЕБС-иудын эрх зүйн кабинет байгуулсан, тэдгээрийг ашглаж байгаа байдал туйлын хангалтгүй байна. Энэ нь нэг талаас 1996 онд батлагдсан “ЕБС-ийн хичээлийн кабинетын ерөнхий заавар”-т *“ЕБС нь ... түүх нийгмийн тухай мэдлэг хичээлийн кабинеттай байна...”* гэж заасантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл тус зааварт ЕБС нь эрх зүйн кабинет гэх тусдаа кабинет байгуулах талаар огт заагдаагүй бөгөөд зааврын дагуу байгуулсан түүх-нийгмийн ухааны кабинетэд эрх зүйн ялангуяа хүний эрхийн хичээлийг заах орчин нөхцөл ямар хэмжээнд бүрдэх нь ойлгомжтой. Нөгөө талаас сургуулийн удирдлагын зүгээс эрх зүйн хичээлд тодорхой ач холбогдол өгөхгүй, бусад хичээлийн дайвар маягаар үзэх хандлага байдаг нь эрх зүйн кабинетын тоо цөөхөн байхад нөлөөлж байна. Учир нь тухайн сургууль хэдэн кабинеттай байхыг сургуулийн сурган-хүмүүжлийн зөвлөлөөр хэлэлцэн тогтож, захиралын тушаалаар байгуулдаг журам дээрх заавраар батлагдсан юм. Судалгаанд хамрагдсан сургуулиудаас цөөхөн тооны сургуулиуд эрх зүйн кабинеттай гэсэн боловч кабинетын шинэчлэл, баяжуулалт, ашиглалтын байдал огт хангалтгүй байна. Эрх зүйн кабинетэд сурагчид хичээллэх, кабинетын ном, гарын авлагыг тухайн кабинетын эрхлэгчээс бусад багш нар ашиглах боломж хязгаарлагдмал байна. Энэ нь нэг талаас сургуулийн хүүхдийн тооны хэт илүүдэл, нөгөө талаас кабинетыг зохистой ашиглах талаар сургуулийн удирдлагын оновчтой зохион байгуулалт дутагдалтай байгаагаас үүдэлтэй юм. Түүнчлэн кабинетийн эрхлэгчийн ажлын үзүүлэлтийг дүгнэхдээ “ЕБС-ийн хичээлийн кабинетын ерөнхий заавар”-т заагдсан “кабинетаа баталгаажуулан орчин үеийн сургалтын шаардлагын хэмжээнд ажиллуулж, сургалтын үр дүнг дээшлүүлж байгаа” гэх шалгуур дээр кабинетыг зөв зохистой ашиглуулах тал дээр санаачлага гарган ажилласан, зохион байгуулсан гэх шалгуурыг нэмэх нь кабинет зохих түвшинд ажиллаж, үр өгөөжөө өгөхөд нөлөөлөх болно. Кабинетын үзүүлэн, тараах материалыг шинэчлэх, баяжуулах тал дээр шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг гаргах тал дээр асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон болон нутгийн байгууллага анхаарал тавих шаардлагатай байна.

## 5.5 Сэдвийн дүгнэлт

“Хүний эрхийн боловсрол-ЕБС” судалгааны хүрээнд ЕБС-иудын хүний эрхийн хичээлийг заах хэрэглэгдэхүүний байдлыг судаллаа. Хүний эрх хичээлийг хэрэглэгдэхүүний хүрээнд тус хичээлийн сурах бичиг, ЕБС-иудын номын санд байгаа хүний эрхийн холбогдолтой бусад ном, гарын авлага болон эрх зүйн кабинетыг хамруулан судласан болно. Судалгааны дүнд дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:





1. ЕБС-ийн 6-р ангийн эрх зүйн сурах бичгийн сурагчийн номын хүртээмж боломжийн түвшинд байна. Гэсэн хэдий ч уг сурах бичгийг хувиарлах түгээх тал дээр нэлээд дутагдалтай байгаагаас болж зарим ЕБС-иудад сурагчийн ном хомсдолтой байна. Түүнчлэн хувийн өмчийн ЕБС-д сурагчийн номын хүртээмж төрийн өмчийн сургуультай харьцуулахад нэлээд доогуур хувьтай байгаа нь ажиглагдлаа. “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн багшийн номын нийт ЕБС-ийн хэмжээнд нэлээд дутагдалтай байна. Түүнчлэн, багшийн номыг хувиарлах тал дээр мөн нь тодорхой бодлого дутагдсан нь илэрхий байна. Тухайлбал, зарим аймгийн сургуулиудад нэлээд олон тооны багшийн ном байдаг тухай тоо авагдсан байхад зарим аймагт огт багшийн ном байхгүй байна.
2. “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн сурагчийн ном өмнөх сурах бичигтэй харьцуулахад нэлээд шинэлэг хэлбэрээр боловсруулагдсан боловч тус сурах бичигт орсон зарим сэдвүүд ЕБС-ийн 6-р ангийн сурагчдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт төдийлөн тохирохгүй байна. Түүнчлэн тус номонд орсон тохиолдол жишээнүүдийг амьдралд нэлээд ойртуулах шаардлагатай байна. Судалгааны хамрагдсан багш нарын дийлэнх нь сурах бичгийн өөрчлөх нь зүйтэй гэсэн саналтай байлаа. Баян-Өлгий аймгийн казак хэл дээр сургалтаа явуулдаг ЕБС-иудын сурагчдын хувьд “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийг ойлгох, хэрэглэхэд хүндрэл бэрхшээл учирдаг байна.
3. Судалгаанд хамрагдсан сургуулиудын номын сан дахь хүний эрхийн бусад ном гарын авлагын хангамж туйлын доогуур байна. Ихэнх ЕБС-ийн номын сангууд сурах бичгээс өөр хүний эрхийн асуудалтай холбоотой ном гарын авлага байхгүй байсан бөгөөд сүүлийн жилүүдэд номын фондын баяжуулалт хийгдээгүй, номнууд нэлээд хуучирсан байлаа. Цөөн тооны сургууль сурах бичгээс гадна “МУ-ын Үндсэн хууль”, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Хүүхдийн эрхийн тухай хууль” гэх мэт нэр төрөл, тоо ширхэг цөөн нэмэлт, материалуудыг үзүүлж байлаа. Номын фондын арвижуулах, сэлбэх төсөв хөрөнгө сургуулиудад байхгүйгээс энэ бэрхшээл үүсч байна.
4. ЕБС-иудад эрх зүйн кабинетыг байгуулсан тохиолдол маш цөөн байна. Энэ нь 1996 онд батлагдсан “ЕБС-ийн хичээлийн кабинетын ерөнхий заавар”-т эрх зүйн кабинет байгуулж болно гэсэн заалт байхгүйтэй холбоотой. Түүнчлэн кабинет байгуулах эрх олгодог албан тушаалтны эрх зүй, хүний эрхийн хичээлийн ач холбогдлын талаарх ойлголт доогуур байна. Ажиглалтад хамрагдсан сургуулиудад цөөн тооны эрх зүйн кабинет байгаа боловч зориулалтын дагуу ашиглагдаж чадахгүй байна. Энэ нь ЕБС-ийн хүүхдийн тоо хүчин чадлаасаа хэд дахин хэтэрсэнтэй холбоотой. Мөн кабинетын эрхлэгчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлж, кабинетыг зориулалтын дагуу ажиллуулсан байдлын шалгуурт тооцох нь зүйтэй байна. Кабинет эрхлэгчийн ажлыг хэлбэрийн төдий дүгнэдэг байдлыг таслан зогсоох шаардлагатай байна. Түүнчлэн, эрх зүйн кабинетын үзүүлэн, тараах материалыг шинэчлэн тал дээр сургууль, Боловсрол төв болон холбогдох бусад байгууллагуудын зүгээс дэмжлэг үзүүлэх нь зүйтэй байна.

## **Зургаа. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ОРЧИН**

### **6.1 Ерөнхий боловсролын хүний эрхийн орчны тухай ойлголт**

НҮБ-ын “Хүний эрхийн боловсрол” хөтөлбөрт: “Хүүхдийн боловсрол, хөгжлийн газар болох сургууль нь өөрийн үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэсэн орчинг бүрдүүлэх хэрэгтэй” хэмээн заажээ.

Хүн өөрийн оршиж буй орчноос ихийг сурч мэдэрдэг ба тухайн хүний зан төлөв ч тухайн орчноос хамааран төлөвшдөг тул сургуулийн хүний эрхийн орчин нь боловсролын системийн үнэт зүйл байх ёстой. Иймд бид “Хүний эрхийн боловсрол”-ын тухай ярихдаа “хүний эрхийн орчин”-ы асуудлыг орхигдуулж үл болно.

Сургууль нэг бүр дээр хүүхдэд сургалтын үйл ажиллагаа, орчинг бүрдүүлэх, хүүхдүүд сэтгэл хангалуун суралцах, хөгжих материаллаг болон материаллаг бус сэтгэл зүйн таатай орчинг бий болгох нь сургуулийн гол үзэл санаа байх ёстой.

**“Хүний эрхийн боловсролын хөтөлбөрт”:**

- ✓ сургуулийн удирдлага, багш нарын хүний эрхийн боловсрол, хандлага төлөвшсөн байх
- ✓ сургуулийн дотоод дүрэм журам нь хүний эрхийн зарчимд суурилсан байх
- ✓ ёс зүйн хэм хэмжээг дээдлэн харилцааны өндөр соёлтой байх
- ✓ шудрага ёсыг эрхэмлэх
- ✓ аливаа хэлбэрийг алагчлалыг үл тэвчих
- ✓ аливаа төрлийн дарамт, хүчирхийллээс ангид байх
- ✓ оролцоог хангах зэрэг хүүхдэд ээлтэй, сурах таатай орчныг бүрдүүлэх нь хүний эрхийн материаллаг бус орчны амин сүнс хэмээн тэмдэглэсэн ба чухамхүү эдгээр шалгуур үзүүлэлтээр хүний эрхийн материаллаг орчныг дүгнэхдээ гол анхаарлаа хандуулах нь чухал хэмээн тусгасан байна.

2000 оны дэлхийн дээд хэмжээний уулзалтаар баталсан “Мянганы хөгжлийн зорилт” мөн онд “Бүх нийтийн боловсролын дээд хэмжээний уулзалт”-аар баталсан Бүх нийтийн боловсролын Дакарын үйл ажилагааны хүрээнд хүүхэд, боловсролын талаар дэвшүүлсэн зорилт, үйл ажилагааг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улс “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийг 2004 оны 5-р сард баталсан билээ. Энэхүү бодлого нь хүүхдэд ээлтэй, “хүүхэд төвтэй, сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх болох “хүүхдэд ээлтэй сургуулийг үнэлэх үзүүлэлтүүдийн талаар нарийн тусгасан ихээхэн ач холбогдолтой баримт бичиг болсон.

**“Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх” бодлого дахь сургуулийг үнэлэх нийтлэг шалгуур үзүүлэлт:**

- ✓ Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашиг
- ✓ Сургалтын агуулга, хөтөлбөр, арга, зүй
- ✓ Багшийн мэргэжлийн болон харилцааны үр чадвар
- ✓ Олон нийт, хүүхдийн оролцоо
- ✓ Хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүйсийн тэгш байдал ба адил тэгш эрхийн хангалт



**“Хүүхдэд ээлтэй сургууль хөгжүүлэх бодлого”-д**

- ✓ Сургуулийн орчинг аюулгүй, эрүүл мэнд, ариун цэврийн хэвийн шаардлага хангасан байхаар өөрчлөн сайжруулахад сургуулиудад дэмжлэг үзүүлэх
- ✓ Сургууль дээр хүүхдэд ээлтэй нийгэм, сэтгэл зүйн харилцааны орчинг бий болгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах
- ✓ Сургалтыг багш хүүхдүүдийн таатай харилцаанд тулгуурласан /хүүхдүүд багш аа хүндэтгэж, багш нь хүүхдээ энэрсэн/ байдлаар зохион байгуулах арга зүйг нэвтрүүлэх
- ✓ Хүүхдийн сурах эрхийг адил тэгш хангах, тэнцвэртэй, тэгш, чанартай боловсрол олгох
- ✓ Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхэд бүрт хүртээмжтэй, тэднийг хөгжүүлэх, сургалтыг сонирхолтой хэлбэрээр явуулах боломжийг хангасан байх.
- ✓ Сургууль бүр өөрийн сургалтын орчин, үйл ажиллагааг олон нийт, эцэг эх, багш, хүүхдийн өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлж, тэдний оролцоог шийдвэр гаргах түвшиндээ бүрэн хангаж байх зэрэг материаллаг болон материаллаг бус таатай орчин бүрдүүлэх талаар тусгасан байна.

Тэгвэл судалгаанд оролцогчид хүний эрхийн орчныг юу гэж ойлгох хэрэгтэй талаар:

- ✓ Сурах бичиг болон сургалт хүмүүжил явуулах орчинтой байх
- ✓ Багшлах боловсон хүчнээр хангагдсан байх
- ✓ Хичээл дээр чөлөөтэй байж, санал бодлоо илэрхийлэх
- ✓ Тухайн сургуулийн дотоод харилцааг харах хэрэгтэй байх. Тухайн сургалтанд оролцогч талын харилцаа эрүүл саруул байж л хүний эрхийн орчин бүрдэнэ
- ✓ Тухайн сургуулийн үйл ажиллагаандаа баримталж, мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг үзэх хэрэгтэй. Сургуулийн дотоод дүрэм, сурагчдын дүрэм, хөдөлмөрийн гэрээ гэх мэт

**Сургуулийн удирдах албан тушаалтантай хийсэн ярилцлагаас**

- ✓ Сургуулийн хүний эрхийн орчинг хангахад удирдсан багш нар, нийгмийн ажилтнууд чухал үүрэгтэй
- ✓ Сургууль дарамтгүй байх, сургалтад оролцогчдын харилцаа илэн далангүй нэгийгээ сонсдог
- ✓ Мэдээлэлтэй байх
- ✓ Сургуулийн үйл ажиллагаа журамчлагдсан байх
- ✓ Хүний эрхийн мэдлэгтэй байх

**Сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас**

**6.2 МУ-ын ЕБС-ийн хүний эрхийн орчны өнөөгийн нөхцөл байдал**

ЕБС-ийн орчинг:

**Материаллаг орчин** – сургуулийн эрүүл аюулгүй орчин, эрүүл мэнд, ариун цэвэр, хэрэглэгдэхүүн зэрэг нүдэнд харагдаж, гарт баригдах эд зүйлсийг багтаадаг ба сургуулийн сургалтын орчин нөхцлийн талаар асуудлыг агуулдаг.

**Материаллаг бус орчин** – нийгэм, сэтгэл зүйн харилцааны болон сургуулийн ардчилсан уур амьсгалыг хэмжиж байдаг маш эмзэг орчин юм.





Өнөөдрийн байдлаар манай улсын ЕБС-иудын удирдлага, багш нарын зүгээс сургуулийн хүний эрхийн орчныг материаллаг талаас нь илүүтэй харж байгаа болох нь ХЭҮК-ын явуулсан судалгааны дүнгээс харагдсан.

**ШИГТГЭЭ**

*Өвөл хүйтний улиралд манай сургуулийн нөхцөл халаалт дулаан, халуун, хүйтэн уснаас авахуулаад хэцүү. Байр хүйтэн, чийгтэй, засвар ороогүй удаж байна*

*Сургалтын материаллаг орчин бүрдүүлэх, мэргэжлийн кабинет байгуулах Ном, сурах бичиг, гарын авлагаар хангах*

**Сургуулийн удирдлага, багш нартай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс...**

Үнэхээр манай сургуулиудад материаллаг орчин эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хүндхэн байдаг нь үнэн. Жишээ нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох, эрүүл ахуйн эрхүүд ч зөрчигдөж байдаг нь хэдийгээр судалгааны гол судлах асуудлуудад ороогүй ч ажиглагдаж байсан.

**ШИГТГЭЭ**

*Сүхбаатар дүүргийн 31-р дунд сургуулийн хашаанд сургуулийн биеийн тамирын талбай дээр барилга барих зориулалтаар газар ухаж, хамгаалалтгүй орхиод 1 жил гаруй болж байна.*

*Баянзүрх дүүргийн 84-р дунд сургуулийн үүдийг таглан Монголын эсперанто хэлний төвийн барилгыг барих зориулалтаар хашаа барьсан байв.*

**Судлаачийн тэмдэглэлээс**

*Манай сургууль гадаа бие засах газартай тул хүндрэл их байдаг. Ариун цэвэр гэх мэт эрүүл ахуйн асуудлаас гадна хүүхдүүд бие засах газар орох гэж яваад дээрэмдүүлэх асуудал их гардаг. Иймд нэн тэргүүнд энэ асуудлыг бид шийдэх нь хүний эрхийн орчны нэг хэсэг гэж бодож байна. Энэ тал дээр ч дээд газрууд маань анхаарал тавих хэрэгтэй болов уу*

**Сургуулийн удирдлагатай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас**

Сургуулийн хүний эрхийн орчны асуудалд ширээ сандал, ном сурах бичиг, хашаа, ногоон зүлэг гэх мэт материаллаг үзүүлэлтүүд хэдий чухал ч бид судалгааныхаа хүрээнд материаллаг бус буюу сэтгэл зүйн орчны тухай илүүтэй хөндөж судалсан юм.

МУ-ын ЕБС-иудын хүний эрхийн материаллаг бус орчинг НҮБ-ын “Хүний эрхийн боловсролын хөтөлбөр”-т үндэслэн үнэлбэл:

✓ **Сургуулийн удирдлага, багш нарын хүний эрхийн боловсрол, хандлага төлөвшсөн байх**

Судалгаагаар багш нарын хүний эрхийн мэдлэг, чадвар, хандлага тааруу гэж ихэнх удирдлага үнэлсэн байна. Зарим багш нар хүний эрхийн мөн чанарыг жинхэнэ утгаар нь ойлгож, мэдрэх нь дутмаг байна.



**ШИГТГЭЭ**

Багш нарын мэдлэг, хандлага огт хангалтгүй, шаардлага хангахгүй байна

... Багш нарт хүний эрхийн ойлголтыг өгөх ингэснээр сургууль дээр хүний эрхтэй холбоотой зөрчлүүдийг арилгана.

Хүний эрхийн тухай их ярьж байгаа учир багш нар ч харьцангуй энэ талаар дуулсан, мэдсэн юм ихтэй. Гэхдээ яг амьдрал дээр, өөрийн хөрсөн дээр буулгаж тэр болгон ойлгодоггүй

Сургуулийн удирдлагатай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

✓ **Ёс зүйн хэм хэмжээг дээдлэн харилцааны өндөр соёлтой байх**

Судалгааны явцад сургууль дээр хүүхдүүд бие биенээ хэл амаар доромжлох, нэр хоч өгөх асуудал түгээмэл байдаг нь харагдсан.

**ШИГТГЭЭ**

Хоч өгдөг, энэ нь нэр хүндэд халдаж, эрх зөрчиж байгаа хэлбэр


Хэл амаар доромжлох нь их байдаг. Хоч их өгдөг. Бүгд хочтой...

Хочлох асуудал маш их. Ялангуяа бие махбодиор нь их шоолдог. Үүнд дургуй... Бага дээр нь зогсоохгүй бол даамжраад дээрэлхэх, зодох асуудал үүснэ. Хоч өгдөг энэ нь их дарамттай

Дооглох, шоолуулах асуудлаас болоод зарим хүүхдүүд сургуульдаа явах сонирхолгүй болдог

Сурагчдын бүлгийн ярилцлагаас


**Үг хэлээр доромжлох, нэр хоч өгөх**



Энэхүү асуудлыг хэрхэн шийдэх талаар сурагчдаас асуухад “нэр, хоч өгөх асуудал түгээмэл, зуршил болчихсон тул хэрхэн яаж шийдэхээ мэдэхгүй хэмээн хариулж байсан нь туйлын хангалтгүй юм.

Түүнчлэн сурган хүмүүжүүлэгч багш нарын зүгээс ч нэр, хоч өгөх, хэл амаар доромжлох дарамт ихээхэн байдаг нь сурагчидтай хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаас илэрч байв.

**Үг хэлээр доромжлох, нэр хоч өгөх –багшийн зүгээс**



**ШИГТГЭЭ**

...Багш нар янз бүрийн үгээр их хараадаг бас доромжилдог  
 ...Багш нар нэр, хоч их өгдөг “тамхи зардаг авгай шиг”, янхан, гичий” гэх мэт  
 ...Багш нар хэл амаар доромжлох нь их, мөн элдэв нэр хоч их өгдөг “ангалзсан гичий” гэх мэт  
 ...Үг хэл амаар их доромжилдог ш дээ, зарим багш нар, “тэнэг, долир, солир” гээд л

**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**

✓ **Шудрага ёсыг эрхэмлэх**

Аливаа хэлбэрийн уралдаан тэмцээн, олимпиадын үеэр шудрага бус үнэлж, дүгнэх зэргээр хүүхдүүдийн урам зоргийг мохоох асуудлууд гарч байна.

**ШИГТГЭЭ**

Нийгмийн ажилтан “Н” миний оронд монгол хэлний сумын олимпиадад надаас их алдсан хүүхдээ хүрэл медальт байранд оруулсан байсан, энд би их гомдсон боловч хэнд хандахаа мэдээгүй. Урам их хугарсан. Хичээлийн эрхлэгчид хэлсэн боловч өнгөрсөн хойно нь хэл ам таталлаа гэсэн. “Н” багш дандаа ингэдэг. Өөрөө монгол хэлний багш, өөрөө олимпиадын материалыг боловсруулж, өөрөө шалгасан

**Сурагчийн ганцаарчилсан ярилцлагаас**


✓ **Аливаа хэлбэрийн алагчлалыг үл тэвчих**

Багш нарын зүгээс хүүхдүүдийг амьдарлын нөхцөл байдлын ялгаа болон сурлагын амжилтын үр дүнгээр нь ялгаварлах, зарим тохиолдолд боловсролын үйлчилгээнд адил тэгш оролцох боломж хүүхэд бүрийн хувьд хангалттайгаар хэрэгжихгүй байх, **үл хайхрах хүчирхийлэлд** хүүхдүүд багш сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс өртдөг нь судалгаагаар харагдаж байлаа.






**Гадаад өнгө үзэмж харах**



**Зарим хүүхдүүдтэй харьцахгүй хайхрахгүй байх**



**ШИГТГЭЭ**

...Багш нар зарим хүүхдийг хайхардаггүй, ер нь бол муу сурдаг, муу нэртэй хүүхдүүдийг

Хойгуур суудаг хүүхдүүдийг хайхардаггүй... Ялгаварлан гадуурхах байдал түгээмэл, зиндаа, сул дорой, сурлаагаар болон үндэстэнээр монгол, казак гэх мэт


Багш нар хүүхдүүдийг сурагчдыг ялгаж үздэг сурлага, хувцас, баян ядуу гэх мэт. Хүүхдүүдэд хөгжих ямар ч нөхцөл байдаггүй. Шилжиж ирсэн хүүхдүүдийг үндсэн ангитай хольдоггүй бүгдийг нь 6 Д бүлэгт нийлүүлж оруулсан нь ялгаварлан гадуурхалт гэж бид үздэг

Багш нар зарим зүйл дээр илт ялгаварладаг. Жишээ нь сайн сурдаг хүүхдүүдээ илүү анхаарч, дандаа өргөж, чадлаараа хийсэн хүүхдийг дэмждэггүй, хамаг анхаарлаа өөрсдийн сайн гэсэн хүүхэддээ тавьж, тэднийг уралдаан тэмцээнд бэлддэг. Үүнээс болоод хүүхдүүд хоорондоо зөрчилддөг

**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**

✓ **Аливаа төрлийн дарамт, хүчирхийллээс ангид байх**

Багш нар хүүхдүүдийг цохиж, зодож цээрлүүлэх асуудал ч түгээмэл байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа.



**ШИГТГЭЭ**

...Сурагчид бага зэргийн үйлдэл хийхэд багш нар уурлаад, хүүхдүүд үгэнд нь орохгүй болохоор бүүр уурлаад өөрийгөө зогсоож чадахаа больдог. Уураа дараа дараагийн ангидаа гаргадаг. Багш нар хүүхдийг цус нөжийг нь гартал зоддог. Ингэж зодохын оронд багш учирлаад, уучлалт гуй гэвэл тэр хүүхэд уучлалт гуйж болно

...Багш нар доромжилж, дарамталдаг. Жишээ нь толгойг чинь цоо цохиод, нусыг чинь суга алгадаад, цонхоор шиднэ шүү гэх мэтээр айлган сүрдүүлж, зоддог. Сургууль, багш нар үзвэрийн билет хүчээр тулгаж тарааж, зардаг, авахгүй гэхээр загнадаг


**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**

Түүнчлэн сургуулийн орчинд багш нар согтууруулах ундаа хэрэглэж, хүүхдүүдийг зодох, нэр төрийг нь доромжлох гэх мэтээр зүй бус авирладаг болох нь судалгааны явцад харагдсан.

**ШИГТГЭЭ**

Биеийн тамир, хөдөлмөрийн багш нар хичээлийн үеэр байнга согтуу байдаг. Хүүхдүүдээс архи, тамхи нэхдэг, байхгүй бол цохиж, зоддог. Ялангуяа согтуу үедээ хайр найргүй цохиж, дарамталдаг. Хөдөлмөрийн багш хөвгүүдийг их зоддог учраас тэд айгаад хичээлээ их тасалдаг. Хэлэхлээр дахиад л зоддог, дүнгээр боолгуулдаг... Даалгавар хийгээгүй ирэхлээр төмөр бүсээр шавхуурддаг. Хөдөлмөрийн багш Чингис болоод бид нарыг Чингисийн цэрэг гээд элдвээр зоддог. Хичээл ер ордоггүй, дандаа өөр юм хийлгэж анги цэвэрлүүлдэг. Бидний юмыг хурааж авч зардаг

**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**





**Улсын тэргүүний сургууль** гэгдэх Архангай аймгийн 10 жилийн 1-р дунд сургуулийн нэр бүхий багш сурагчдыг хичээл дээр нь хүчээр чимхэж байгаад цамцыг нь тайлуулж шалдан суулгадаг, мөн элдэв шалиг хөдөлгөөн үзүүлэх зэрэг тохиолдол гарсан байсан нь сэтгэл түгшмээр бөгөөд энэ тухай сургуулийн удирдлагад анхааруулахад: “Хүүхдүүд юу ч гэж хэлж мэднэ”, “Энэ багш удахгүй тэтгэвэрт гарах гэж байгаа”, “Биднийг шаардлага тавьбал бидэнд агсан тавьж, хүүхдүүдийг улам зодож, дүнгээр бооно” хэмээн хаацайлан сууж байсан нь хачирхалтай.

**ШИГТГЭЭ**


“Б” багш охидыг хувцсаа тайл, цагаан цамцаа тайл гэж загнадаг. Тайлахгүй бол чимхэдэг. Манай ангийн нэг охиныг дээд талын бүх хувцасыг нь чимхэж байгаад тайлуулаад, хичээл дээр шалдан суулгасан. Хөдөлмөрийн багш “С” хичээл дээр эвгүй хөдөлгөөн хийдэг бүжиглээд ч байгаа юм шиг, охидууд боолт хөвгүүд эрэг нийлээд их гоё юм болдог та нар мэдэх үү гээд учир нь ойлгогдохгүй юм ярьдаг

Сурагчдын бүлгийн ярилцлагаас

✓ **Оролцоог хангах**

Сургуулийн удирдлага багш, ажилчдын болон сурагчид, эцэг эхийн оролцоог хэрхэн хангаж, санаа бодлыг нь шийдвэр гаргахдаа хэрхэн тусгадаг зэргээр нь НҮБ-ын “Хүний эрхийн боловсрол” хөтөлбөрийн хүний эрхийн орчинг дүгнэх нэг гол шалгуур болдог байна. Тэгвэл судалгаанд хамрагдсан ихэнх багш нарын хувьд ялангуяа хувийн сургуулийн багш нар оролцоог харьцангуй боломжтой гэж үзсэн байна.

**Санал хүсэлтээ удирдлагадаа тавьсан тохиолдолд шийдвэрлэгдэх хэр магадлалтай вэ?**



**ШИГТГЭЭ**

...Гайгүй асуудаг. Ялангуяа багш нарын оролцоог чухалчилдаг. Сурагчдын саналыг ерөнхийдөө багш нар нь төлөөлдөг. Гэхдээ сурагчдаар үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзсэн асуудлуудыг бол хийлгэдэг

Сурагчид бидэнд саналаа чөлөөтэй хэлэх бололцоо нээлттэй байдаг. Хүүхдүүдээс багш нарын ажлыг дүгнэхэд хүртэл санал асуулга авдаг.

Сургуулийн удирдлагатай хийсэн ярилцлагаас



Судалгаанд оролцсон сургуулийн удирдах албан тушаалтнууд оролцоог хангах талаар дэвшилттэй арга хэмжээ авч байгаа нь үнэлүүштэй.

### ШИГТГЭЭ

Болдоггүй гэж хэлэхгүй, удирдлагууд харилцан адилгүй л байдаг. Зарим багш нарыг эрхлэгч хүлээж авдаггүй...

Захирал удахгүй тэтгэвэрт гарах гэж байгаа болохоор шийдвэр гаргахдаа тааруухан. Гэхдээ багш нарын саналыг авах зүйл дээрээ авнаа.


Чөлөөтэй уулзах боломжтой. Сурагчдыг ч гэсэн чөлөөтэй хүлээн авч, санаа бодлыг сонсдог. Сурагчдын хүсэлтийг хүлээн авах самбар гаргадаг. Асуулга бөглүүлдэг. Ярицлага зарлаад сурагчдын төлөөллийг хүлээн авч уулзан санаа бодлыг нь сонсдог

Сургуулийн удирдлагаас шийдвэр гаргахдаа багш нарын санал бодлыг харьцангуй сонсдог, гэхдээ сурагчдын санал бодлыг ер тусгаж, сонсохгүй байгаа юм шиг санагддаг.


**Сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас**

Сурагчдын хувьд төрийн өмчийн ихэнх сурагчид багш, нийгмийн ажилтан, мөн сурагчдын өөрөө удирдах зөвлөлөөрөө дамжуулан санаа бодлоо илэрхийлдэг гэсэн ба сургуулийн удирдлагад өөрөө санаа бодлоо илэрхийлэх боломж муу, загнаж, зэмлүүлэхээсээ эмээдэг гэж хариулж байлаа.


*Захиралтай чөлөөтэй уулзах, санал бодлоо илэрхийлэх боломж байдаггүй*



*Хичээлийн эрхлэгчтэй чөлөөтэй уулзах, санал бодлоо илэрхийлэх боломж байдаггүй*



*Багштай чөлөөтэй уулзах, санал бодлоо илэрхийлэх боломж байдаггүй*





### **ШИГТГЭЭ**

*Багш нар асуудлыг тоодоггүй. Зарим үед хэлэхлээр уурлаж шийтгэдэг.*

*Захиралтай уулзаж ярьж гэхээр уурладаг. Ангийн багштай л уулздаг. Хичээлийн эрхлэгч гэж ямар хүн байдгийг мэдэхгүй. Бид нарыг санаа бодлоо хэлэх гэхээр захирал та нар яасан их юм ярьдаг юм бэ, хэний том толгойтой хүүхэд вэ гэж загнадаг.*

*Чөлөөтэй уулзаж чадахгүй, загнах байх гэж айдаг.*

*Багш, хичээлийн эрхлэгч, захиралтай уулздаг. Хүсч байгаа зүйлээ багшдаа л хэлдэг. Нийгмийн ажилтан хүүхдүүдийн санал бодлыг тэр бүр авах ажлыг зохион байгуулдаггүй. Захирал, хичээлийн эрхлэгч яахыг мэдэхгүй байна.*

**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**

Харин хувийн өмчийн сургуулийн хүүхдүүд сургуулийнхаа удирдлагатай чөлөөтэй уулзаж санаа бодлоо илэрхийлэх боломж байдаг, хэдийгээр уулзах шаардлага гарч байгаагүй ч уулзвал нааштай шийдэж өгөх байх гэсэн итгэлтэй байгаагаа дурьдаж байлаа.

Гэсэн хэдий ч хүүхдүүд шүүмжлэлтэй хандах асуудал мэр сэр гарч байлаа.

### **ШИГТГЭЭ**

*Уулзахыг хүсдэггүй, үүрэг даалгавар өгчихөөд л гараад явдаг. Багшид хэлэхлээр “хичээлийн эрхлэгчид хэл” гэдэг бид айгаад хэлж чаддаггүй. Бид нар 350 ам.доллар төлдөг. Самбар гялаагаад юм харагддаггүй, гэтэл самбараа ч авч чаддаггүй яах юм. Бид нарыг хажууд байдаг хогийн савыг цэвэрлэж гэдэг. Бид нар хог цэвэрлэх гэж ирдэг юм уу, хичээлд сууж юм сурах гэж ирдэг юм уу. Энд хогийн машин ер ирдэггүй байхаа. Хамгийн адаглаад халдварт өвчин гарна шүү дээ. Хувцсаа ч солихгүй цэвэрлэгээнд гараад байхдаа яахав дээ. Бидний үгийг тийм ч их сонсдоггүй...*

**Сурагчдын бүлгийн ярилцлагаас**

### **6.3 ЕБС-д хүний эрхийн орчинг бүрдүүлэхэд анхаарах зүйлс:**

*“Хүнтэй ажилладаг хүн бусдын өдрийг харанхуй давчуу болон аймшигтай, аль эсвэл гэрэл гэгээтэй, өөдрөг болгодог”*

Ёоханнэс Меллехаве

1. Холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлагууд нь боловсрол эзэмших эрхийг хангах чиглэлээр гаргаж буй бодлого, хөтөлбөртөө материаллаг орчноос гадна материаллаг бус орчны тухай нарийвчлан тусгах замаар хүний эрхийн орчинг бүрдүүлэхэд анхаарах
2. “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх
3. “Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлого”-д ЕБС-ийн хүний эрхийн материаллаг бус орчинг бүрдүүлэх, үнэлэх талаар нарийвчлан тусгаж өгөх



4. Бодлогын хэрэгжилтийг үндэсний болон орон нутгийн түвшинд жил бүр үнэлж, хэвших
5. Нийслэл, орон нутгийн боловсрол соёлын газрууд өөрийн нутаг дэвсгэрт сургуулийн хүний эрхийн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулж, шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэгийг үзүүлэх
6. БСШУЯ-ны сайдын 321 тоот тушаалаар батлагдсан "ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдэд" хүний эрхийн хандлага болон хэрхэн хамгаалж, хүндэлж буй талаар тусгагдаагүй бөгөөд өнөөдрийн байдлаар сургуулийн орчинг дүн, ирц, сурлагын амжилт гэх мэт зүйлээр дүгнэж үнэлж байна. Тус дүгнэлт үнэлгээнд ЕБС-ийн хүний эрхийн орчныг хэрхэн бүрдүүлж буйг хэмжих шалгуурыг тогтоох
7. Боловсролын мэргэжлийн хяналтын газраас боловсролын стандарт, хөтөлбөр, сургуулийн хүний эрхийн орчинд тавих хяналтыг өндөржүүлэх
8. Сургууль өөрийн хүний эрхийн орчинг хангах үйл ажиллагааг сургуулийн удирдлага олон нийт, эцэг эх, багш, хүүхдүүдийн өөрсдийнх нь оролцоотойгоор хэрэгжүүлж, үнэлж хэвших
9. Сургуулийн дотоод харилцааг зохицуулсан баримт бичигт сургуулийн хүний эрхийн орчны талаарх асуудлууд хэрхэн тусгагдсан талаар нарийвчилсан судалгааг хийх
10. Багшлах боловсон хүчинг бэлтгэж буй бүх сургуулиудад заавал судлах хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг оруулах, багш нарыг энэ чиглэлээр давтан сургах шаардлагатай байна. Нөгөө талаас хүний эрхийн тухай ярихдаа ёс зүй, ёс суртахууны асуудлыг бас анхаарч авч үзэх
11. Сурч боловсрох таатай, хүнлэг орчин бүрдэхэд ангийн багшаас гадна, нийгмийн ажилтан чухал үүрэг гүйцэтгэж сургуулийн хүний эрхийн ШҮХЭР болж явдаг гэдгийг мартаж болохгүй. Иймд сургуулийн нийгмийн ажилтанг мэргэшүүлж, мэргэжлийн ур чадварыг нь ахиулах
12. Сургуулийн орчинд сурагчдын санал, үзэл бодлоо гол төлөв нийгмийн ажилтнаараа дамжуулан илэрхийлдэг тул тус албыг хашиж буй хүн хүүхдийн баярлах, уурлаж бухимдах зэргийг анхаарч, мэдэрч хүүхэдтэй харилцах нарийн мэдрэмжтэй байх.





## ДҮГНЭЛТ

- Ерөнхий боловсролын стандарт, Гэгээрлийн сайдын 100 тоот тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хүний эрх хичээлийг төлөвлөсөн цагаар оруулдаггүй, зарим сургуулиуд хүний эрх хичээлийг сургалтын төлөвлөгөөндөө тусгахгүй явж ирсэн байна. Иймээс боловсролын стандартад заасан хүний эрх хичээлийг төрийн болон хувийн өмчийн аль ч сургуульд бүтэн цагаар оруулах талаар боловсролын байгууллагууд анхаарах ёстой. Энэ хичээлд тавих боловсролын хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна. Хүний эрх хичээлийг бусад хичээлүүдтэй адил түвшинд авч үздэг байвал зохино.
- 2004 онд батлагдсан Ерөнхий боловсролын стандартад хүний эрхийн боловсролын агуулга, үнэлгээний стандартыг тусган өгсөн нь НҮБ-ын ХЭДКГ-аас гаргасан зөвлөмж чиглэлтэй үндсэндээ нийцсэн байна. Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх 11 жилийн сургалтын шинэ тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хангах зорилгоор батлагдсан БСШУ-ны сайдын 132-р тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөнд хүний эрх хичээлийг 7-р ангид 35 цагаар орохоор заасан нь сургууль бүр энэ хичээлийг ялгавартай байдлаар ордог байсан дутагдлыг арилгах чухал заалт болсон гэж үзэж байна.
- МННХ(Соросын сан)-ийн “Хууль бидний амьдралд” төслийн хүрээнд боловсруулагдсан “Хүний эрх бүх нийтэд” сурах бичиг нь багшийн номын хамт хийгдсэн учраас уг хичээлийг ороход ихээхэн ач холбогдолтой болсон боловч илүү сайжруулах, ялангуяа тухайн насны хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал; шоронгийн нөхцөл байдал, цаазаар авах ял хэрэгтэй юу, аюулгүй байдлыг хангахын тулд хүний эрхийг хязгаарлах нь зэрэг сэдвүүд 6, 7-р ангийн хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохироогүй гэсэн дүгнэлт гарсан байна. Сурах бичигт багтсан сэдвүүдийг дахин хянаж үзэх нь зүйтэй.
- ЕБС-иуд хүний эрх хичээлийг орж буй цагаасаа шалтгаалан хичээлийн агуулга нь янз бүр байна. Зарим сургуулиуд хүний эрх хичээлийг цөөн цагаар орж байгаагаас сурагчдад хүний эрхийн цогц мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлж чадахгүй байна.
- Хүний эрхийн хичээлийн сургалтын технологи нь сургалтын зорилго, агуулга, арга зүйд нийцэхүйц хэмжээнд хүрч чадаагүй, уламжлалт болон идэвхгүй арга зонхилсон хэвээр байна. Хүний эрхийн хичээлийн сургалтын технологийн хөгжилд багш нарын агуулгын мэдлэгийн хомсдол, заах арга зүйн менежментийн дутагдал, сургуулийн удирдлагын мэргэжил арга зүйн туслалцааны хоцрогдол, нэг ангийн сурагчдын тооны хэт илүүдэл сөргөөр нөлөөлж байна.
- ЕБС-ийн хүний эрхийн хичээлийн сурах бичгийн ерөнхий хүртээмж муу биш байгаа боловч зарим сургуулиудын сурах бичгийн хангамж доогуур байна. Сурах бичгийг хувиарлах, түгээх тал дээр учир дутагдалтай байна. Ялангуяа хувийн өмчийн сургуулиудад сурах бичгийн хангамж төрийн өмчийн сургуулиас харьцангуй доогуур байна. Багшийн номын хувиарлалт ч мөн нэгэн адил байна. ЕБС-иуд сурах бичгээс өөр хүний эрхийн холбогдолтой ном, сэтгүүл, гарын авлагагүй байна. Сургуулиуд шинэ ном, зохиол сэтгүүлээр хангагдахгүй байна. Иймээс багш сурагчид сурах бичгээс гадуур



мэдлэг олох боломж хомс байна. Бараг ихэнх сургуулиуд эрх зүй болон хүний эрхийн кабинетгүй байна. Эрх зүйн болон хүний эрхийн кабинет байгуулж хүний эрхийн хичээлийн ач холбогдол, үнэлэмжийг дээшлүүлэх, уг кабинетийг хүний эрхийн ном сэтгүүл гарын авлагаар хангах шаардлагатай байна.

- ЕБС-ийн хүний эрхийн хичээлийн хөтөлбөр, сурах бичиг нь тавигдаж буй шаардлагад нийцсэн боловч энэ хичээлийг заах багшийг бэлтгэх, багшид тавигдах шаардлага боловсруулагдаагүй байгаа хүний эрхийн хичээлийн шинэ стандартыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ хичээлийг хүний эрхийн чиглэлээр мэргэшээгүй, өөр мэргэжилтэй багш нар орж байгаагаас хичээлийн ач холбогдол буурч, хэлбэрийн төдий сургалт явагдаж байна. Иймээс хүний эрхийн хичээл заах багшид тавигдах шаардлагыг боловсруулах, энэ хичээлийг заах багшийг бэлтгэх чиглэлээр бодлого чиглэл боловсруулж хэрэгжүүлэх, хүний эрхийн хичээл зааж буй багш нарын мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах шаардлагатай. Судалгаанаас харахад энэ хичээлийг ихэвчлэн түүх-нийгэм судлалын мэргэжилтэй багш орж байгаа ба уг хичээл эрх зүйн сургалтын хүрээнд хамаарч байгаагаас үзэхэд энэ мэргэжлийн багш орох нь илүү дөхөмтэй байж болохоор байна. Иймээс энэ хичээлийг зөвхөн нийгэм-эрх зүйн болон түүх-нийгмийн ухааны багшаар заалгах чиглэлийг баримтлаж, тэднийг давтан сургах шаардлагатай юм.
- Судалгааны дүнд ЕБС-иудын хүний эрхийн орчин төдийлөн сайн биш байгаа нь харагдсан. ЕБС-ийн хүний эрхийн хичээлийн чанар, нөлөө, үр өгөөж нь сургуулийн хүний эрхийн орчинтой зайлшгүй холбоотой. Сургуулийн удирдлага, багш нарын зүгээс сурагчдад нэр хоч өгөх, хүч хэрэглэх, ам хэлээр доромжлох, тэднийг ямар нэгэн байдлаар алагчлах, сурагчдын санал бодлыг сонсохгүй байх, өнгө үзэмж харах зэрэг зөрчил багагүй байна. БСШУ-ын сайдын тушаалаар баталсан ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдэд сургуулийн хүний эрхийн орчны тухай асуудлуудыг оруулж, сургуулийн удирдлага болон багш нарын ажлыг үнэлэх, дүгнэх, шагнаж урамшуулах, дэвшүүлэхдээ хүний эрхийг хүндэтгэх хамгаалах чадварыг харгалзан үздэг журам тогтоох шаардлагатай байна.



## СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ӨГСӨН ШИНЖЭЭЧДИЙН ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ  
КОМИССЫН ДАРГА С.ЦЭРЭНДОРЖ ТАНАА

Судалгааны тайланд санал  
өгөх тухай

ЮНЕСКО-гийн санхүүжилтээр БСШУЯ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс хамтран явуулсан “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” судалгааны урьдчилсан тайлантай танилцлаа.

Энэхүү судалгаа нь Хүүхдэд ээлтэй дэлхий өртөнцийг байгуулахаар зорьж буй манай орны хувьд, Хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх бодлогоо тодорхойлон олон арга хэмжээ авч хэрэгжүүлж буй БСШУЯ-ны хувьд чухал ач холбогдолтой судалгаа болж байна.

Түүнчлэн Хүүхдийн эрхийн конвенцийн 44 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын өргөн барьсан хоёрдугаар илтгэлийг энэ 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газар Олон Улсын Хүүхдийн эрхийн хороонд тайлагнасан билээ. Хүүхдийн эрхийн хорооноос тус улсын илтгэлтэй холбогдуулан гаргасан зөвлөмжид хүний эрхийн боловсрол олгох талаар авч буй арга хэмжээгээ иж бүрэн, тасралтгүй байлгах талаар анхаарах хэрэгтэй байгаа тухай зөвлөсөн байна. Иймд энэхүү судалгаа нь цаг үеэ олсон судалгаа болсныг онцлон тэмдэглэж байна.

Судалгааны тайлангаас харахад ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын өнөөгийн байдлын талаар баримтад тулгуурласан, түүвэр, төлөөллийг нилээд сайн тооцоолж, судалгааны арга зүйн зохих түвшнийг хангасан байдлаар зохион байгуулагдсан судалгаа болжээ гэж үзэж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн цаашид ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн орчныг дэмжих чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулах нь талаар төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй.

Олон улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын чиглэлээр баримталж буй чиг хандлага, туршлагаас судалгааны оршил хэсэгт оруулах нь зүйтэй юм.

Г.Батболд

БСШУЯ-ны Ерөнхий  
боловсролын хэлтсийн дарга





## “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” төслийн судалгааны тайлангийн тухай санал, дүгнэлт

XXI зуунд хүний хөгжлийг бүх үнэт зүйлийн хэмжүүр хэмээн тодорхой улс, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч, тэр хөгжлийн төвд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хэрэгжүүлэх асуудлыг тал бүрээс нь онцгойлон анхаарч байна

Ийм нөхцөлд Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссоос дээрх сэдэвт судалгааг урьдчилсан байдлаар хийсэн нь хүүхэд, залуучууд хийгээд сургууль, соёлын байгууллага, багшлах боловсон хүчний эрх зүйн хэрэгцээг тодорхойлох, хангахад чухал ач холбогдолтой, цаг үеэ олсон, ирээдүйгээ харсан ажил болсон байна.

Учир нь тус улсын Үндсэн хуулинд тунхагласан Монгол улсад хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх, хангах үйл явц нь гэр бүл, ясли, цэцэрлэг, бага, дунд сургууль дахь хүний эрхийн, хүүхдийн эрхийн боловсролын чанар, түвшингээс, эдгээрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт хүмүүсийн хүний эрхийн соёлоос шууд хамаарах билээ. Ийм учраас энэхүү сэдэвт төслийн судалгааны урьдчилсан тайланд судалгааныхаа үндэслэл, арга зүй, ЕБС дахь “Хүний эрх” хичээлийн удирдлага, зохион байгуулалт, агуулга, технологи, сурах бичиг, энэ сургалтын хэрэглэгдэхүүн, тэрчлэн ЕБ-ын сургуулийн хүний эрхийн орчны асуудлыг нэлээд өргөн хүрээтэй, холбогдох ажиглалт, судалгаа, баримт, үнэлэлтэйгээр авч үзсэн нь сайшаалтай бөгөөд сонирхол татаж байна.

Тайланд Монголын ЕБС дахь хүний эрхийн боловсрол, сургалтын өнөөгийн байдлыг 6-р ангид үздэг “Хүний эрх” хичээлийн жишээн дээр судалсан аргачлал, явц, үр дүнг тодорхойлжээ. Энэ судалгаанд манай орны хөгжлийн тодорхой бүсүүдийг төлөөлөх Архангай, Баян-Өлгий, Дархан уул, Өмнөговь, Сүхбаатар, Ховд гэсэн 6 аймаг, эдгээрийн нэр бүхий 12 сум /тайлангийн 6-р тал. Хүснэгт 1/, Нийслэлийн 6 дүүрэг дэх хүний эрхийн боловсрол, хичээл-сургалтын асуудлыг 1206 сурагч, 184 багшийг хамруулан судлаж, мөн сэдвээр нийслэлийн болон 21 аймгийн төв, хөдөөгийн 6 сумын бүгд 175 сургуульд ажиглалт хийсэн нь нийт ЕБС-ийн 25 орчим хувийг эзлэж буй нь зохих төлөөлөл мөн.

Эл судалгаанаас үзвэл, “Хүний эрх” хичээлийг ажиглалт, судалгаанд хамрагдсан нийслэлийн 53 сургуулийн 39,6%-д нь 18 цагаар, 37,7%-д нь 27 цагаар, 18,8%-д нь 9 цагаар, хөдөөгийн 56 сургуулийн 33,9%-д нь 27 цагаар, 28,5%-д нь 18 цагаар, 37,5%-д нь 9 цагаар /тайлангийн 13-р тал/ зааж байгаа юм байна. Гэтэл “Хүний эрх” хичээл нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн 13 хувийн сургуульд, мөн 6-р ангигүй 4 сургуульд тус тус заагдаагүй байна. /Тайлангийн 12-р тал/

Түүнчлэн тайланд Хүний эрх хичээл зааж байгаа багш нарын мэргэжлийн бүрэлдэхүүн, ажилласан жил, хүйс, туршлага, ур чадвар, мэргэшилт, тэдний үйл ажиллагаанд илэрч буй нийтлэг бэрхшээл хийгээд Хүний эрх хичээлийн агуулга, шинэ стандарт, тэдгээрийн бүтэц, хөгжлийг өөрийн орны болон олон улсын түвшинд харьцуулан авч үзсэн байна. Бас “Хүний эрх бүх нийтэд” сурах бичгийн /УБ, 2003/ бүтэц, агуулга, арга зүйд дүн шинжилгээ хийж, түүний ололттой болон дутагдалтай талыг хэрэглэгчийн санал бодлын судалгааны дүнд тулгуурлан тодорхойлсон байна.

Мөн Хүний эрх хичээлийн сэдвүүдийн заагдсан байдал, түүний үр дүн, сурагчийн болон багшийн хүний эрхийн мэдлэг, чадварыг боловсролын тестээр



судлахад сонирхолтой, бас ч чамлалттай хариу гарсаныг тайланд тусган харуулжээ. /28,29-р тал/ Тухайлбал, Хүний эрх хичээл зааж байгаа багш нар хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн ангилал, тухайн эрхийн мөн чанар, тодорхой эрхийг хангах, хамгаалах механизм, хүний эрхийн зөрчил зэрэг үндсэн суурь ойлголтуудыг хангалтгүй эзэмшсэн нь илэрчээ.

Үүний сацуу тайлангийн "Хүний эрхийн сургалтын орчин" хэсэгт хүний эрхийн хичээл-сургалтын арга зүй, технологи, тэдгээрийн бүтцийг багаар ажиллах, дүрд тоглох, асуудал шийдвэрлэх, жишээ тохиолдолд ажиллах, зочин урих /тайлангийн 35-36-р тал/ зэрэг үйл, үйлдлээр багш, сурагчийн санал бодлын үндсэн дээр судалсан дүн хийгээд "Хүний эрхийн бүх нийтэд" сурах бичгийн хангамж, хүртээмж /85.1%-тай, тайлангийн 39, 40-р тал/, ашиглалт болон хүний эрхийн сэдэвт багшийн ном, бусад гарын авлага, материал, хэрэглэгдэхүүн, эрх зүйн кабинет, сургуулийн номын сан дахь нийгмийн ухааны номын төрөл зэргийн талаархи тодорхой баримт, судлагаануудыг авч үзсэн байна.

Тайлангийн төгсгөлд өнөөгийн манай улсын ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн, хүүхдийн эрхийн орчин хэр зэрэг бүрдсэн болон энэ талаархи зэрэг болон сөрөг жишээ тохиолдол, хүчин зүйл, үйлдлүүдийг /хүүхдийг доромжлох, нэр хоч өгөх, шударга бус хандах, алагчлах, хайхрамжгүй хандах, дарамтлах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, оролцоог хязгаарлах г.м. тайлангийн 54-59-р тал/ зохих судалгаагаар тодруулан гаргаж тавьсан байна.

Дээр дурдсанаас үзвэл, уг тайлан нь судалгааныхаа зорилго, зорилтыг хангасан, ЕБС дахь хүний эрх хичээлийн сургалт, хүний эрхийн боловсролын үндсэн болон нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудлуудыг нэлээд цогц, тодорхой хөндсөн, бодит баримт, үндэслэлтэй, ажил хэрэгч, сайн тайлан болсон байна гэж дүгнэлээ.

Төслийн судалгаа болон тайланг цаашид боловсронгуй болгох, гүнзгийрүүлэхэд дараах зарим нэг зүйлийг анхаарах нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Тайлангийн судалгааны объектыг "Судалгааны түүвэрт хамрагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн ЕБС-ийн багш, сурагч, мөн өмнө гарсан баримт бичгүүд зэрэг хоёрдогч эх үүсвэр материалыг үзэж судлав" гэсэн байдлаар тодорхойлсон нь /1.1.3. 5-р тал/ шинжлэх ухааны судалгааны үүднээс судлах объектоо /судлах зүйлээ/ хараахан оновчтой сонгож чадаагүй тал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, судалгааны предметийг судлагдахуун, судалгааны объектыг судлах зүйл хэмээн нэр томъёо, ойлголтын хувьд тогтсон байдаг болохоор энэ төслийн судалгааны объект нь "Монголын ЕБС дахь Хүний эрхийн боловсролын сургалтын бүх цогц үйл явц, хүчин зүйл" гэвэл илүү оновчтой тодорхойлогдоно. Харин судлагдахуун нь "ЕБС-ийн 6-р ангийн хүний эрхийн боловсролын сургалтын зорилго, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ, үр дүн /сурагчийн мэдлэг, чадвар, хандлага, багшийн ур чадвар г.м./ " юм. Судлагдахууныг судалгааны судлах зүйл /1.1.2./ гэж оновчгүй нэрлэсэн боловч агуулгыг нь үндсэндээ зөв тодорхойлжээ. Цаашдын судалгаандаа энэ мэт зүйлийг дахин анхаарч залруулах бүрэн боломжтой билээ.
2. Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын асуултууд, аргачлалыг бүрэн эхээр нь эсвэл хэсэгчлэн хавсаргаж өгвөл судалгааны нотолгоо, үнэмшил улам өндөрждөгийг анхаарахад илүүдэх юун.
3. Агуулга /1-р тал/-ын бүтэц болон уг тайлангийн эх бичгүүдийн гарчиг хоорондоо зөрж байгааг анхаарах. Жишээ нь, Агуулгад 2. Судалгааны хураангуй гэсэн нь орхигдсон, тайлангийн эх бичигт Нэг. Судалгааны



арга зүй, аргачлал г.м.-ээр зөрчилтэй байгаа нь техникийн алдаа болов уу.

Дээр дурдсан зарим зүйл нь эл тайлангийн олон талын өндөр ач холбогдлыг огтхон ч бууруулахгүй бөгөөд ялангуяа ЕБС дахь удирдлага, багш, суралцагч, хүний эрхийн орчин болон боловсрол, сургалтын бүх салбар дахь хүний эрх, хүний эрхийн боловсролын талаар энэхүү тайлан, түүний дүгнэлтэд дэвшүүлсэн зүйлүүдийг амьдралд хэрэгжүүлэх, төслийн судалгааг улам өргөтгөхийн тулд ХЭҮК, боловсрол, сургалт, судалгааны бүх түвшний байгууллагын ажилтнууд тусгайлан анхаарч, ажиллах хэрэгтэй байгааг тэмдэглэн хэлэхэд илүүдэхгүй болов уу.

О.Пүрэв

Доктор (Sc.D), профессор  
Боловсролын Хүрээлэнгийн ахлах ажилтан  
2005.ҮИИ.30

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН





## **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮНИЙ ЭРХ ХИЧЭЭЛИЙГ ЗААХ БАГШ НАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Хүний эрхийн сургалтын агуулга, арга зүй нь ерөнхий боловсролын сургуульд судлагдаж буй бусад хичээлээс ялгагдах өвөрмөц онцлогтой:

- Хүний эрх нь мөн: чанарынхаа хувьд түгээмэл, зайлшгүй, тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх, эрхэм зэргийг хүндэтгэх зарчимд тулгуурладаг тул эдгээр зарчимд нийцсэн сургалт явуулах хэрэгтэй болдог.
- Хүний эрхийн хичээлийн уур амьсгал нь сургалтанд оролцогчид бие биеэ ойлгосон, хүндэтгэсэн, хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл ардчилсан байх шаардлагатай байдаг.
- Хүний эрхийн сургалт нь оролцогчдод үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бүлэг, хамт олныг төлөөлөх, шийдвэр гаргах, үндэслэл нотолгоо дэвшүүлэх, бусдыг сонсох, ялгаатай үзэл бодол болон соёлыг хүлээн зөвшөөрөх, хүлээцтэй хандах, хүндэтгэх, хамтран ажиллах зэрэг үнэт чадваруудыг төлөвшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг.
- Хүний эрхийн боловсрол нь тухайн хичээлээс гадна анги хамт олон, сургууль, гэр бүл, найз нөхөд зэрэг хүүхдийг хүрээлэн буй нийгмийн бичил орчноор дамжин олгогддог.

Дээрх онцлогоос үүдэн хүний эрхийн хичээлийг заах багш нар нь тодорхой шалгуурыг хангасан байхыг шаарддаг. Энэхүү жишиг хэмжээг Хүний эрх хичээлийг зааж буй багш нар сургалтандаа мөрдөхөөс гадна уг хичээлийг заах багшийг сонгох, багшийн ажлыг үнэлэхэд баримтална.

### **Нэг: Багшлахуйн цогц чадамжийг эзэмшсэн байх**

**Шаардлага 1. Хүний эрхийн мөн чанар, агуулгыг эзэмшиж, түүнийг сурагчдад эзэмшүүлэх дидактик боловсруулалтыг хийх онол, арга зүйг эзэмшсэн байх**

Энэхүү шаардлага нь дараах агуулгыг илэрхийлнэ.

- ✓ Хүний эрхийн тухай ойлголт, түүний түүхэн хөгжил, хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчлийг шийдвэрлүүлэх олон улсын болон үндэсний механизмын талаар цогц мэдлэгийг эзэмшсэн байх;
- ✓ Хүний эрхийн хичээлийн менежментийг хийх, агуулгыг хялбаршуулах, заах арга зүйг сонгох, боловсруулах мэдлэгтэй байх;

**Шаардлага 2. Хүний эрхийн хичээлийг удирдан зохион байгуулах ур чадвартай байх**

Энэхүү шаардлага нь дараах агуулгыг илэрхийлнэ.

- ✓ Хичээлийн агуулгад тохируулан бодит амьдралын жишээ тохиолдлыг сонгох, боловсруулах зэргээр дидактик хэрэглэгдэхүүнийг бэлтгэж чаддаг байх;



- ✓ Сурах, сургах үйл явцад оролцогчдын үйл ажиллагаа, харилцааг тэгш оролцооны зарчимд нийцүүлэн зохион байгуулж, анги танхимд ардчилсан уур амьсгалыг бүрдүүлэх сургалтын арга, аргачлалыг хэрэглэж чаддаг байх;

### **Шаардлага 3. Соёл-хүмүүнлигийн болон харилцааны цогц чадамж эзэмшсэн байх**

Энэхүү шаардлага нь дараах агуулгыг илэрхийлнэ.

- ✓ Иргэншсэн чанар, соёлыг түгээх, хүмүүнлигийн үзэл санаагаар үйлчлэх, хүний үнэт чанарыг эрхэмлэн дээдлэх хандлага, үнэлэмжтэй байх;
- ✓ Хүний эрхийн хичээлийн соёлыг бүрдүүлж тэрхүү бичил соёлоор дамжуулан сурагчдад хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чин эрмэлзлэлтэй байх;
- ✓ Шавиа болон бусдыг ойлгох, хүндэтгэх, үлгэр дууриал үзүүлэх, өөрийн үзэл бодол, байр суурийг оновчтой илэрхийлэх, зөвшилцөх, сөргөлдөөнтэй асуудлыг шийдвэрлэх, бусадтай хамтран ажиллах, бусдаас суралцах, бусдад туслах, дэмжлэг үзүүлэх, хорших, түншлэх гэх мэт цогц чадамжийг эзэмшсэн байх;

### **Хоёр: Сургалтанд хүний эрхийн зарчмыг баримтлах**

### **Шаардлага 4. Сургалтанд тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үүднээс хандаж чаддаг байх**

Хүн бүрийн төрөлхийн эрхэм зэргийг хүндэтгэн үзэх, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд хүнийхээ хувьд бүгд адил тэгш эрх, үүрэгтэй бөгөөд тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр сууриас үл хамааран тэгш, ялгаварлан гадуурхахгүй харьцахад энэхүү зарчмын мөн чанар оршино.

Энэхүү шаардлага нь дараах агуулгыг илэрхийлнэ.

- ✓ Хичээлийн агуулга нь дээрх зарчимд нийцсэн байх, тухайлбал хичээлийн агуулга болон хэрэглэгдэхүүн, жишээ, тохиолдол, зураг, үзүүлэн гэх мэт нь хүйс, нас, мэргэжил, албан тушаал зэрэг аливаа нэг ялгаварлан гадуурхалт болон тэгш бус байдлыг ил ба далд хэлбэрээр хөхиүлэн дэмжээгүй байх;
- ✓ Сурагчдад хичээлийн үйл ажиллагаанд ялгаварлагдахгүй, тэгш оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;
- ✓ Сургалтыг зохион байгуулах болон сурагчдыг үнэлэх үйл явц нь сурлага, гэр бүлийн байдал, хөрөнгө чинээ, эцэг эхийн албан тушаал, гадаад төрх, хүүхдийн итгэл үнэмшил зэргээс үл хамаарсан шударга, бодитой, тэгш эрхийн зарчимд үндэслэсэн байх;

### **Шаардлага 5. Сургалтанд хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчмын үүднээс хандах**

Нас, соёл, итгэл үнэмшил, арьс үндэс, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, тахир дутуугийн байдал эсвэл нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн бүрт хүндэтгэлтэй хандах ёстой.

Сургалтанд энэ зарчмыг баримтлах гэдэг нь дараах зүйлүүдээс бүрдэнэ.

- ✓ Хичээлийн агуулга нь энэ зарчимд нийцсэн байх, тухайлбал, хичээлийн хэрэглэгдэхүүн, жишээ, тохиолдол, зураг, үзүүлэн гэх мэт;



- ✓ Хичээлийн явцад тухайн суралцагчийн хувь хүний гадаад төрх, зан байдал, үйл хөдлөлд хүндэтгэлтэй хандах;
- ✓ Хичээлийг удирдан зохион байгуулахдаа сурагч бүр өөрийн эрхэм зэргийг мэдэрч, түүгээрээ бахархах орчныг бүрдүүлэх, улмаар бусдын эрхэм зэргийг хүндэтгэх төлөвшлийг бий болгоход тэмүүлэх;

#### **Шаардлага 6. Сургалтанд хүний эрхийн түгээмэл зарчмын үүднээс хандах**

Ёс зүйн зарим үнэт зүйлс дэлхийн аль ч бүс нутагт адилхан оршиж байдаг бөгөөд засгийн газрууд, нийгэм тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжиж байх ёстой. Хүний эрхийн хувьд энэхүү зарчмын үүднээс тайлбар хийвэл дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүс аливаа эрхийн талаар нэгдсэн ойлголттой байх буюу олон улсын хүний эрхийн хэм хэмжээг нэг мөр ойлгох явдлыг хэлнэ.

Сургалтанд энэ зарчмыг баримтлах гэдэг нь дараах зүйлүүдээс бүрдэнэ.

- ✓ Тухайн хичээлийг заахын өмнө багш хүний эрхийн тухайн асуудлаар олон улсын хэм хэмжээний хүрээнд нэг мөр ойлголттой болсон байх;
- ✓ Хичээл болон сурагчдыг үнэлэх үйл явц нь хүний эрхийн тухайн агуулгын талаар нэгдсэн ойлголт бий болсон эсэхийг илрүүлэхэд чиглэх;

#### **Шаардлага 7. Сургалтанд хүний эрхийн харилцан хамааралтай, хуваагдашгүй, салшгүй байх зарчмын үүднээс хандах**

Гэр, сургууль, ажлын газар, шүүх, зах гээд аж амьдралын бүх л хэсэгт хүний эрхийн асуудал оршиж байдаг. Хүний эрхийн зөрчлүүд ч хоорондоо холбоотой. Нэг эрх зөрчигдөхөд нөгөө эрх бас хөндөгддөг. Түүнчлэн хүний аль нэг эрхийг хөхиүлэн дэмжиж сурталчилах нь бусад эрхүүдийг хэрэгжүүлэхэд сайнаар нөлөөлдөг. Хүний бүхий л эрхүүд тухайлбал, иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын болон хамтын эрхүүд нь нэгдмэл, хуваагдашгүй байдаг бөгөөд хүнээс хүчээр булаан авч, салгах боломжгүй билээ. Хүний эрх гэдэг нь хэн нэгэн албан тушаалтан, сайн төрөөс олгож буй хишиг биш бөгөөд энэ нь хүн бүрт төрж мэндлэхэд нь хамт заяадаг зүйл мөн.

Сургалтанд энэ зарчмыг баримтлах гэдэг нь дараах зүйлүүдээс бүрдэнэ.

- ✓ Хичээлийн агуулгаар дамжуулан хүн бүхий л эрхээ эдэлсэн цагт эрхэмсэг орших боломжтойг ойлгуулж, аль нэг эрхийг илүү чухал, давуутай мэтээр ойлголт төрүүлэхээс болгоомжлох, хүний эрхийн зөрчлийг танин мэдэх, түүнээс сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээлгэх арга замуудыг сурагчдад эзэмшүүлэхэд чиглэх, хүний эрх бол таны өөрийн мөн чанар, оршин байхуйн үндэс мөн гэдгийг таниулахад чиглэсэн байх;
- ✓ Сургалтын явцад нэг эрх зөрчигдөхөд бусад эрх нь дагаад зөрчигддөг болох, нэг хүний эрх зөрчигдөх нь бусад хүний эрх мөн зөрчигдөх эхлэл болж байдгийг ойлгуулах;
- ✓ Сургалтын явцад сурагчдын эрхээ салшгүйгээр эдлэх нөхцлийг бүрдүүлэх, тухайлбал үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах, хайх, ялгаварлан гадуурхагдахгүй байх гэх мэт эрхүүдийг хангахад чиглэсэн байх;

#### **Шаардлага 8. Сургалтанд хариуцлагатай байх зарчмын үүднээс хандах**

Хүний эрхийн салбарт хариуцлагын тухай асуудал нь хэд хэдэн түвшинд тавигддаг. Тухайлбал төрийн, хувь хүний, иргэний нийгмийн хүлээх хариуцлага гэх мэт. Төрийн хариуцлага: хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй. Төр зарим





Хүний эрхийн салбарт хариуцлагын тухай асуудал нь хэд хэдэн түвшинд тавигддаг. Тухайлбал төрийн, хувь хүний, иргэний нийгмийн хүлээх хариуцлага гэх мэт. Төрийн хариуцлага: хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй. Төр зарим хүний эрхийг нь эдлүүлээд нөгөө хэсэгт нь эдлүүлэхгүй байх учиргүй. Ингэсэн тохиолдолд төр хариуцлага хүлээх ёстой. Хувь хүний хариуцлага: Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх, сурталчлах, хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй. Иргэний нийгэм: Корпорациуд, төрийн бус байгууллагууд, сангууд, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийн хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэгтэй.

Сургалтанд энэ зарчмыг баримтлах гэдэг нь дараах зүйлүүдээс бүрдэнэ.

- ✓ Хичээлийн агуулга нь нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг бөгөөд хязгаарыг давсан тохиолдолд буруутай этгээд хариуцлага хүлээх ёстой, нөгөө талаасаа сургалтанд оролцогч талууд сургуулийн удирдлага, багш, ажилчид, сурагчид бүгд хүний эрхэд хүндэтгэлтэй хандах үүргийг хүлээдэг болохыг ойлгуулахад чиглэх;
- ✓ Сургалтын явцад үүргээ биелүүлээгүйн төлөө сурагчдад оногдуулж буй хариуцлага нь шударга ёсны болон хүний эрхийн зарчимд нийцсэн байх;

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС



Төсөл

## **ЗӨВЛӨМЖ**

Хүн эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэх нэг үндсэн нөхцөл нь хүний эрхийн боловсрол мөн болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас цохон тэмдэглэж, энэ чиглэлээр олон санал, санаачлага гарган ажиллаж байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1995-2004 оныг Хүний эрхийн боловсролын 10 жил болгон зарласан бөгөөд түүний залгамж болгон Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг батлаад байна. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат (2005-2007) нь хүний эрхийн боловсролыг бүх нийтийн ерөнхий боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох, хүний эрхийн багш бэлтгэх зорилтыг дэвшүүлэн тавьсан.

Монгол улсын хувьд 1990-ээд оноос ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын агуулга, арга зүйг шинэчлэн боловсронгуй болгох талаар багагүй ажил хийгдэж ирсэн. Энэ чиглэлээр хийгдсэн чухал ажлын нэг бол “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д хүний эрхийн боловсролын агуулгыг тодорхойлсон явдал мөн. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаа нь хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй, хоорондоо уялдаа холбоо муутай явж ирлээ.

Үүнээс гадна албан ба албан бус боловсролын бусад салбарт ч хүний эрхийн боловсролын чиглэлээр дорвитой ахиц гарахгүй байна. Энэ нь хүний эрхийн боловсролын чиглэлээр төрийн нэгдсэн бодлого байхгүй явж ирсэнтэй холбоотой бөгөөд 2003 онд батлагдсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт ч хүний эрхийн боловсролын асуудал орхигдсон байна.

Иймээс Хүний эрхийн Үндэсний Комисс холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан **ЗӨВЛӨХ НЬ:**

### **Монгол Улсын Их Хурал,**

1. Төрөөс хүний эрхийн боловсролын чиглэлээр баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах: Энэхүү бодлого нь Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийн дэд хөтөлбөр байдлаар боловсруулагдах боломжтой.
2. Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн орчныг бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэх;

### **Монгол Улсын Засгийн Газарт:**

3. Төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулах, УИХ-аар батлуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, үүнд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг бий болгох, хуваарилах;
4. Хүний эрхийн олон улсын баримт бичгүүд, хүний эрхийн боловсролд холбогдох хууль, тогтоомж, олон улсын болон үндэсний хэмжээний хурал,



зөвлөгөөний баримт бичгүүдийг орон нутгийн, үндэсний түвшинд түгээн дэлгэрүүлэх;

#### **Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яаманд:**

5. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд багш нарыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, үүний тулд багш бэлтгэдэг их дээд сургуулийн заавал судлах хичээлийн агуулга, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг тодорхой кредит цагаар оруулах бодлого баримтлах;
6. Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтныг бэлтгэх болон давтан бэлтгэхдээ хүний эрхийн сургалтын менежментийг хэрэгжүүлэх чадвартай болгоход анхаарч ажиллах;
7. Багшлах эрхийг олгох шалгуурт хүний эрхийн мэдлэг, хандлагыг үнэлэх үзүүлэлтүүдийг оруулах;
8. Хүний эрхийн хичээлийг заах багшийн мэргэжил, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг боловсруулж, батлан, мөрдүүлэх;
9. Хүний эрхийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сурах бичиг, гарын авлага, материалыг боловсруулах, энэ чиглэлээр гарч байгаа үүсгэл санаачлагыг дэмжих;
10. Түүх, нийгмийн ухааны боловсролын стандартад тусгагдсан хүний эрхийн боловсролын агуулгын хэрэгжилт болон энэ талаар холбогдох байгууллага, агентлагууд хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг үнэлэх, хариуцлага тооцож ажиллах;
11. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн удирдлага, багш нарын ажлыг үнэлж, дүгнэх шалгуурт тухайн сургуулийн хүний эрхийн орчин, сургуулийн дүрэм, журам хүний эрхэд суурилсан байдал зэрэг үзүүлэлтийг тусгах;
12. Хүний эрхийн боловсролын чиглэлээр ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, сургуулиуд, судлаачид, багш нар, хувь хүмүүсийн үйл ажиллагааг тогтмол дэмжих;
13. Ерөнхий боловсролын зорилго, агуулга, сурах бичиг, хэрэглэгдэхүүн нь хүний эрхэд суурилсан байх бодлогыг барьж ажиллах;

#### **Улсын Мэргэжлийн Хяналтын Газарт:**

14. Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, боловсролын хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын стандартын хэрэгжилт, орчинд үнэлгээ, шинжилгээ, шалгалт хийх;
15. Тухайн үнэлгээ, шинжилгээ, шалгалтын дүнд тулгуурлан зөрчлийг арилгах, сайжруулах талаар зөвлөмж, албан шаардлагыг холбогдох талуудад явуулж, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж хэвших;

#### **Боловсролын хүрээлэнд:**

16. Монгол улсын хүний эрхийн боловсролын чиглэлээр баримтлах бодлого, хөтөлбөрийн шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, энэ чиглэлээр холбогдох олон улсын болон үндэсний мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах санаачилгыг өрнүүлэх;





17. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичигт хяналт шинжилгээ хийх ажлыг тасралтгүй явуулж, холбогдох байгууллагуудыг эрдэм шинжилгээ, арга зүйн зөвлөмжөөр хангах;
18. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын арга зүйч, сургуулийн удирдлага, менежерүүд, багш нарын дунд хүний эрхийн боловсролын талаар мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зөвлөлгөө өгөх;
19. Хүний эрхийн боловсролыг нийгмийн бүх бүлэг, сургалтын түвшинд хүргэх зорилгоор судалгаа шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлох, үүнд судлаач багш нарыг өргөн оролцуулах;
20. Ерөнхий боловсролын агуулга, сурах бичиг, хэрэглэгдэхүүнийг хүний эрхэд хэрхэн суурилсан байх зарчим, үзүүлэлтийг боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

#### **Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газарт:**

21. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад хүний эрхийн сургалтын менежментийн талаар арга зүйн зөвлөмж өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих;
22. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын чанар, стандартын хэрэгжилтэнд хяналт, шинжилгээг тогтмол хийх;
23. Ерөнхий боловсролын сургуульд “Хүний эрх” хичээл зааж буй багш нарт хүрч, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжиж ажиллах;
24. Хүний эрхийн хичээл зааж буй багш нарын дунд харилцан туршлага солилцох, хөгжүүлэх зорилгоор уулзалт ярилцлага, мэргэжлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж хэвших;

#### **Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад:**

25. Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, багш мэргэжлийн бүх ангиудад заавал судлах хичээл байдлаар оруулах;
26. Ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн хичээл заах багшийг бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
27. Хүний эрхийн хичээлийн ач холбогдол, үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, багш, оюутнуудыг хүний эрхийн ном, сэтгүүл, гарын авлагаар хангах зорилго бүхий хүний эрхийн боловсрол мэдээллийн төв байгуулах;
28. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын арга зүйч, сургуулийн удирдлага, менежерүүдэд хүний эрхийн боловсролын талаар мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зөвлөлгөө өгөх;
29. Багш боловсролд холбогдох хүний эрхийн судалгааг дэмжих, судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулах;

#### **Ерөнхий боловсролын сургуулиудад:**

30. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер нь хүний эрхийн сургалтыг удирдлагаар хангах мэдлэг, чадвартай байх;
31. ЕБС-ийн хүний эрхийн хичээл заах багш нарыг “Хүний эрхийн хичээл заах багшид тавигдах шаардлага”-д нийцүүлэн сонгох, сургууль дээрээ мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
32. Хүний эрхийн боловсролын үндэс болсон сургуулийн хүний эрхийн орчныг төлөвшүүлэхэд тэмүүлэх. Үүний тулд:
  - ✓ Сургуулийн дотоод амьдралыг зохицуулж буй дүрэм, журмуудыг хүний эрхэд суурилан боловсруулах;



- ✓ ЕБС-ийн багш бүр хүний эрхийн зохих боловсрол, мэдрэмж, хандлагатай байхыг шаардах, ажил дүгнэх шалгуурт тусгах;
  - ✓ Сургуулийн орчинд нэн тэргүүнд тэгш, ялгаварлан гадуурхагдахгүй, халдашгүй дархан байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөхөөс сэргийлж хүний нэр төр, алдар хүнд, эрхэм зэргийг хүндэтгэх соёлыг төлөвшүүлэх;
  - ✓ Сурагч, багш нар болон эцэг эхчүүдийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагааг оролцоонд тулгуурлан зохион байгуулж хэвших;
33. Хүний эрх, хүүхдийн эрхийн төрийн ба төрийн бус байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, багш бэлтгэх болон бусад ЕБС-иудтай хүний эрхийн боловсролын чиглэлээр хамтран ажиллах, харилцан туршлага солилцох;

**НҮБ, түүний агентлагууд болон олон улсын байгууллагуудад:**

- 34. Хүний эрхийн боловсролыг дэмжих, бодит үйл хэрэг болгох талаар олон улсын болон бүс нутгийн түвшинд гарч буй бодлого, хөтөлбөр, санал санаачлагыг Монгол улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх;
- 35. Монгол улсын хүний эрхийн боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажилд мэргэжлийн болон техникийн туслалцаа дэмжлэгийг үзүүлэх;
- 36. Хүний эрхийн багш бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд гарч байгаа санал, санаачлагууд, сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэгт хүний нөөцийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- 37. Үндэсний болон бүс нутгийн түвшинд хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

Зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2005 онд явуулсан “Хүний эрхийн боловсрол Ерөнхий боловсролын сургуульд” сэдэвт судалгааны ажлын үр дүнд тулгуурлан боловсруулсан болно.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС**